



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН

НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН НЭГТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

ХУВИЛБАР 2.0

2021 оны 6 дугаар сарын 29

БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн нэр	НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН НЭГТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ
Баримт бичгийн тайлбар	Нийгэм, жендэрийн нэгтгэсэн төлөвлөгөө нь Мянганы сорилтын Компакт гэрээний зорилго, зорилт, үйл ажиллагаа, үр дүн, үүрэг хариуцлага болон хэрэгжилтийн хүрээнд жендэрийн тэгш байдал, нийгмийн оролцоог хангах арга замыг тусгасан баримт бичиг юм. Тус төлөвлөгөө нь Монголын МСС-гийн бодлого, үйл ажиллагааны гол баримт бичгүүдийн нэг бөгөөд Компакт гэрээний хэрэгжих хугацаанд нийгэм, жендэрийн асуудалтай холбогдох дүн шинжилгээ, оролцоо, хүний нөөц, шаардлагатай сургалтуудыг тусгасан болно.
Баримт бичгийг боловсруулсан	Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн асуудал хариуцсан захирал

БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРУУЛСАН, БАТАЛСАН, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ТҮҮХ

Хувилбар	Огноо	Боловсруулсан /Шинэчилсэн	Баталсан
1.0	2020.12.14	Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн асуудал хариуцсан захирал	МСК-ын Нийгэм, жендэрийн асуудал хариуцсан захирал
2.0	2021.06.29	Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн асуудал хариуцсан захирал	МСК-ын Нийгэм, жендэрийн асуудал хариуцсан захирал

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	4
I. КОМПАКТ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА.....	6
II. НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН НЭГТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА	7
A. НЖНТ-Г БОЛОВСРУУЛАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	8
B. НЖНТ-НИЙ АГУУЛГА	8
C. МОНГОЛЫН МСС-ГИЙН НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ БАГ...9	
D. МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГИЙН НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН НЭГТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
III. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	11
A. МОНГОЛ УЛСЫН ХОЛБОГДОХ ХУУЛИУД.....	11
B. НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБОГДОХ БОДЛОГУУД	13
C. МСК-ЫН ШААРДЛАГА БОЛОН ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД	14
IV. ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮДИЙН ЭРСДЭЛ БОЛОН ЭЕРЭГ БОЛОМЖУУД.....	16
A. КОМПАКТ ГЭРЭЭГЭЭР САНХҮҮЖИЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, БОГИНО ХУГАЦААНЫ АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ	16
B. ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ	24
V. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСЛИЙН НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ.....	31
A. ЗАРДАЛ НӨХӨХӨД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	32
B. ГЭР ХОРООЛЛЫН УС ХАНГАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ ДЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	35
C. УС АШИГЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ДЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА	39
D. ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УСЫГ УРЬДЧИЛАН ЦЭВЭРЛЭХ, БОХИРДЛЫГ ХЯНАХ ДЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА	42
E. ОЛОН НИЙТИЙН ДАДАЛ, ХАНДЛАГЫГ ӨӨРЧЛӨХ ДЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА..	42
VI. НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН НЭГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	46
VII. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ (БНҮ)-НИЙ БАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЗОХИЦУУЛАЛТ	62
VIII. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ.....	63
IX. ТАЛУУДЫН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА	68
X. ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТ	72
XI. НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААР ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ	72

ХII. ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ, ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ХЭРЭГЦЭЭ	72
ХIII. НЖНТ-НИЙ ҮНЭЛГЭЭ, ШИНЭЧЛЭХ ҮЙЛ ЯВЦ	73
ХАВСРАЛТ I: БЭЛГИЙН ДАРАМТ, ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ГЭРЭЭЛЭГЧИД ТАВИХ НААД ЗАХЫН ШААРДЛАГА	74
ХАВСРАЛТ II. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БОЛОН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД ..	79

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АД	Ажлын даалгавар
АХБ	Азийн хөгжлийн банк
АБТ	Амьжиргааны баталгаажих түвшин
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНСС	Байгаль орчин, нийгмийн суурь судалгаа
БОННУ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНМТ	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
БОНУ	Байгаль орчин, нийгмийн үнэлгээ
БХИ	Барилгын хяналтын инженер
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БЭУШБТ	Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл
ГЗ	Гүйцэтгэх захирал
ГБХЗХА	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн агентлаг
ГС	Гүйцэтгэлийн стандарт
ГОУХАН	Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ДЦС	Дулааны цахилгаан станц
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЖЭТБХТХ	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль
ЗГ	Засгийн газар
ЗНТ	Зардал нөхөх төлөвлөгөө
ЗНТТ	Зардал нөхөх техникийн туслалцаа
Компакт	Мянганы сорилтын Компакт гэрээ
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МСС	Мянганы сорилтын сан
МСК	Мянганы сорилтын корпорац
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
МБСҮМАЗТ	Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв
НЖО	Нийгэм, жендэрийн оролцоо
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НШТ	Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө
НЖНТ	Нийгэм, жендэрийн нэгдсэн төлөвлөгөө
ОУСК	Олон улсын санхүүгийн корпорац
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
СТГ	Суурин төлөөлөгчийн газар
СИУ	Санал ирүүлэх урилга
ТУ	Тендерийн урилга
ТЦБ	Төв цэвэрлэх байгууламж
ТББ	Төрийн бус байгууллага
ТТЭ	Төлбөр төлөх эрмэлзэл
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТҮББ	Тендерийн үндсэн бичиг баримт
ТХТ	Тоо хэмжээний тооцоо
УБН	Урьдчилсан болзолт нөхцөл
УСТБХТ	Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл
УБ	Улаанбаатар
УСУГ	Ус сувгийн удирдах газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ФБХ	Фокус бүлгийн хэлэлцүүлэг
ХДХ	Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр
ХХГХТ	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал

ХЗТ	Хөдөлмөр зарцуулалтын тооцоолол
ХҮ	Хяналт, үнэлгээ
ХУДБТ	Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХМЗ	Хөтөлбөрийн менежментийн зөвлөх
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
ШУТИС	Шинжлэх ухаан, техникийн их сургууль
ШХХАА	Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны агентлаг
ШУТИМ	Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл болон математик
ЭТӨ	Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх
ЭӨТӨ	Эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх

I. КОМПАКТ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Мянганы сорилтын корпорац нь сайн засаглал, эдийн засгийн эрх чөлөөг дэмжин, хүний хөгжилд хөрөнгө оруулахаар зорин ажиллаж буй улс орнуудад туслалцаа үзүүлэх үндсэн зорилго бүхий Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын агентлаг бөгөөд Монгол Улсын Засгийн газартай байгуулсан Мянганы Сорилтын Компакт гэрээний хүрээнд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хязгаарлагч хүчин зүйлсийн нэг болох “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний өндөр өртөг”-ийг шийдвэрлэхэд зориулж 350 сая ам.доллар хүртэлх хэмжээний буцалтгүй тусламжийг үзүүлнэ. Тус Компакт гэрээний хүрээнд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод тулгамдаад буй усны хомсдолыг бууруулж, ахуйн хэрэглэгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагчдын тооцоолж буй усны эрэлтийг хангахад чиглэсэн Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлнэ. Улаанбаатар (УБ) хотод Монгол Улсын нийт хүн амын 50 орчим хувь амьдардаг бөгөөд нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн дөрөвний гурав нь үйл ажиллагаа явуулдаг, нийт эдийн засгийн эргэлтийн гуравны хоёрыг бүрдүүлдэг хот юм. Компакт гэрээг хэрэгжүүлснээр ойролцоогоор 656,124 өрх (2,427,657 орчим хүн) үр шимийг нь хүртэнэ гэж тооцоолсон. Тус Компакт гэрээний үр шимийг хүртэгчид нь УБ хотын нийт хүн ам юм.

Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд харилцан уялдаа бүхий доорх гурван үйл ажиллагаанд хөрөнгө оруулна. Үүнд:

- **Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаагаар** гүний худгууд, шахуурга, ус цуглуулах сав, дамжуулах шугам хоолой бүхий шинэ эх үүсвэр болон дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна;
- **Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаагаар** хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр, дахин боловсруулсан ус дамжуулах шугам хоолойг байгуулж, 3 болон 4 дүгээр Дулааны цахилгаан станц (ДЦС)-ын хэрэглээнд өндөр түвшинд цэвэршүүлсэн хаягдал усыг ашигласнаар чөлөөлөгдсөн газрын гүний цэвэр усыг хотын ус хангамжид ашиглах боломж бүрдэнэ;
- **Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа** нь Улаанбаатар хотын ус хангамжийн урт хугацааны тогтвортой байдлыг сайжруулах зорилгоор усны салбарын институцийн тогтолцоо, хууль, эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулах, чадавхыг бэхжүүлж, техникийн туслалцаа үзүүлэх асуудлыг хамарсан дараах таван дэд үйл ажиллагаанаас бүрдэнэ. Үүнд:
 1. **Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагааны** хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (ХСУХАТАҮЗЗ)-д техникийн туслалцаа үзүүлэх бөгөөд ингэхдээ орон сууцны болон гэр хорооллын хэрэглэгчдийн ус хангамжийн сайжруулсан үйлчилгээнд төлөх төлбөрийн чадвар, төлбөр төлөх эрмэлзэл болон тодорхой шалгуурын дагуу хэрэглэгчид үзүүлэх Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр (ХДХ)-ийн хэрэгжүүлэх боломжийг нарийвчлан судална.
 2. **Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагааны** хүрээнд Улаанбаатар хотын гэр хороололд ус түгээх байраар дамжуулан ус хангамжийн үйлчилгээг хүргэхэд Ус сувгийн удирдах газар (УСУГ)-аас зарцуулж буй өндөр зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ дэд үйл ажиллагааны хүрээнд ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулж, цагийг уртасгах үүднээс энгийн ус түгээх байрыг "ухаалаг" буюу автомат ажиллагаанд шилжүүлэх үйл ажиллагаа багтана.

Түүнчлэн, нийслэлийн хэмжээнд ус хангамжийн дэд бүтцийг өргөжүүлж, хөгжүүлэх асуудлаар УСУГ болон нийслэл, дүүргийн харьяа байгууллагууд хоорондын мэдээлэл солилцоо, төлөвлөлт, уялдаа холбоог сайжруулахад туслалцаа үзүүлнэ.

3. **Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагаа** нь ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, харьцуулалт хийхэд зориулж Олон улсын усны нийгэмлэгээс боловсруулсан "AquaRating" үнэлгээний аргачлалыг ашиглан УСУГ-ын үйл ажиллагааны чадавхыг тодорхой чиглэлүүдээр сайжруулах зорилготой. Энэ хүрээнд, УСУГ-ыг үйл ажиллагааны хувьд ижил төстэй, нийтлэг бэрхшээл бүхий, хөгжингүй орны, өндөр туршлагатай ус ашиглалтын байгууллагатай иж бүрэн түншлэлийн харилцаа тогтооход шаардлагатай санхүүгийн туслалцааг үзүүлнэ. Түүнчлэн, УСУГ-ын хөрөнгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэхийн зэрэгцээ (тухайлбал, төлөвлөх, захиран зарцуулах, ашиглалттай холбоотой засвар үйлчилгээг гүйцэтгэх зэрэг) хэрэглэгчдийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, үр дүнг оновчтойгоор ашиглах чадварыг сайжруулахад чиглэсэн тодорхой тусламжийг үзүүлнэ.
4. **Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах дэд үйл ажиллагаа** нь шинэ Төв цэвэрлэх байгууламж баригдаж, ашиглалтад орохоос урьтаж нийслэлийн хаягдал ус татан зайлуулах систем дэх үйлдвэрийн бохирдлын түвшинг бууруулах хүчин чармайлтыг дэмжих зорилготой. Түүнчлэн, энэхүү дэд үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд усны бохирдолд хяналт тавих, илрүүлэх, ус бохирдуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Засгийн газрын болон нийслэлийн харьяа байгууллагуудад техникийн туслалцаа үзүүлж, лабораторийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангана.
5. **Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх дэд үйл ажиллагааны хүрээнд** Улаанбаатар хотод нүүрлэж болзошгүй усны нөөцийн дарамт, хомсдолын талаар болон байгаль орчинд ээлтэй, нийгмийн эрх ашигт нийцсэн байдлаар ус олборлох, ашиглахтай холбоотой бодит өртгийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор холбогдох талууд, олон нийтийн харилцаа, хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

II. НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН НЭГТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Нийгэм, жендэрийн нэгтгэсэн төлөвлөгөө (НЖНТ) нь Мянганы сорилтын Компакт гэрээ (Компакт)-ний зорилго, зорилт, үйл ажиллагаа, үр дүн, үүрэг хариуцлага болон хэрэгжилтийн хүрээнд жендэрийн тэгш байдал, нийгмийн оролцоог хангах арга замыг тусгасан баримт бичиг юм. НЖНТ-г боловсруулах болон шинэчлэх үйл явц нь Мянганы сорилтын корпорац (МСК), Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС), болон холбогдох бусад оролцогч талтай харилцан зөвшилцөж, тэдний оролцоог хангах замаар хэрэгжинэ. Тус төлөвлөгөө нь Монголын МСС-гийн бодлого, үйл ажиллагааны гол баримт бичгүүдийн нэг бөгөөд Компакт гэрээний хэрэгжих хугацаанд нийгэм, жендэрийн асуудалтай холбогдох дүн шинжилгээ, оролцоо, хүний нөөц, шаардлагатай сургалтууд, жендэр, нийгмийн оролцоотой холбогдох асуудлууд, салбарын хүрээний холбогдох эрсдэлүүдийг тусгаснаас гадна эмэгтэйчүүд болон бусад бүлгүүдийн хүртэж болохуйц үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжуудыг тодорхойлсон юм. Түүнчлэн, тендэрт оролцогчид, зөвлөхүүд, гэрээлэгчид, гэрээлэгчдийн туслан гүйцэтгэгчид, болон

хэрэгжүүлэгч байгууллагуудад Компактын хүрээнд хэрэгжих үйл ажиллагаануудын төсөл, төлөвлөгөө, үйл ажиллагааны хэрэгжилт болон хаалтын үе шат бүрд нийгэм, жендэртэй холбогдох дүн шинжилгээ, үйл ажиллагаануудыг хэрхэн тусгах талаар зааварчилгааг багтаасан юм.

A. НЖНТ-Г БОЛОВСРУУЛАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Монголын МСС-гийн хэрэгжүүлж буй Ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн, үйл ажиллагаанууд нь МСК-ын Жендэрийн бодлого, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх (ХХГХТ) бодлого, Нийгмийн оролцоог хангах зааварчилгаа, болон Бэлгийн хүчирхийлэлтэй холбогдох зааварчилгаа зэрэгт нийцсэн байх шаардлагатай юм. Дэлхийн бусад улс оронд үйл ажиллагаа явуулж буй Мянганы сорилтын сангууд, түүний дотор Монголын МСС нь жендэрийн холбогдох судалгааг боловсруулах, хүйсээр ангилсан тоон мэдээллийг цуглуулах, төсөл болон үйл ажиллагааны төлөвлөлтөд жендэрийн эрх тэгш байдал, нийгмийн оролцооны асуудлыг тусгах, мөн НЖНТ-ний хэрэгжилтийн хүрээнд жендэр, нийгмийн оролцоог хангахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй юм. НЖНТ нь МСК-ын зүгээс бүх Мянганы сорилтын сангийн үйл ажиллагаанд тавьдаг шаардлагуудын нэг бөгөөд НЖНТ-г боловсруулах болон шаардлагын дагуу хэрэгжүүлэх нь бүх Мянганы сорилтын сангуудад тавигддаг хөтөлбөрийн санхүүжилтийн Урьдчилсан болзолт нөхцөл (УБН)-үүдийн нэг юм. Монголын МСС нь хөтөлбөрийн хоёр дахь санхүүжилт хийгдэхээс өмнө НЖНТ-г агуулга, хэлбэрийн хувьд МСК-ын шаардлагад нийцүүлэн боловсруулж, батлуулсан байх шаардлагатай юм.

B. НЖНТ-НИЙ АГУУЛГА

НЖНТ нь нийгэм болон жендэрийн зарим дүн шинжилгээг багтаасан бөгөөд энэ ньтухайн улсад Компакт гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, үйл ажиллагааны чиглэлтэй холбогдох хууль, эрх зүй, бодлого болон нийгэм, жендэрийн гол асуудлуудыг тусгаснаас гадна төслийн үйл ажиллагааны хүрээнд нөлөөлөлд өртөж болзошгүй эмэгтэйчүүд, бага орлоготой иргэд болон бусад бүлгүүдийн талаарх мэдээллийг багтаасан болно. Түүнчлэн, тус НЖНТ-ний чухал хэсгүүдийн нэг болох жендэр, нийгмийн оролцоог хангах Үйл ажиллагааны төлөвлөгөөг дараах үндсэн зорилтуудыг хангах хүрээнд боловсруулсан болно. Үүнд:

- Эмэгтэйчүүд болон бусад эмзэг, зорилтот бүлгүүдтэй зөвлөлдөх үйл ажиллагааг тогтмол, үр дүнтэй, хүртээмжтэй зохион байгуулах арга замуудыг тодорхойлох;
- Төслийн нийгэм, жендэрийн дүн шинжилгээний үр дүн болон зөвлөмжүүдийг төслийн эцсийн дизайнд нэгтгэх стратегийг боловсруулах;
- Компактын үйл ажиллагааны хүрээнд нийгмийн оролцоо, жендэрийн тэгш байдлын зорилтуудад хүрэхэд шаардлагатай алхмуудыг тодорхойлох;
- Нийгэм, жендэрийн оролцоог хангах үйл ажиллагааны зорилго, үүрэг хариуцлага болон цаг хугацааг нарийвчлан тодорхойлох;
- Төслийн эцсийн дизайн, барилга угсралтын тендерийн бичиг баримт, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө зэрэгт жендэр, нийгмийн дүн шинжилгээний үр дүнг тусгаж, нийцтэй байдлыг хангаж буйг хянах зэрэг болно.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) болон Нийгэм, жендэрийн оролцоо (НЖО)-г хариуцсан багууд хамтран дэд бүтцийн төслүүдийн Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) болон гэрээлэгчийн БОНМТ-ний

хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг НЖНТ-нд багтаасан болно. Түүнчлэн, Компактын бүх төсөл, үйл ажиллагааны хүрээнд нийгэм, жендэртэй холбогдох шаардлагуудыг багтаах үүднээс Хяналт үнэлгээ (ХҮ), одоогийн болон ирээдүйн боломжит хамтрагч байгууллагууд, олон нийттэй харилцах үйл ажиллагаа, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, болон шаардлагатай техник, арга зүй, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон тус төлөвлөгөөнд багтаасан болно.

С. МОНГОЛЫН МСС-ГИЙН НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ БАГ

Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн оролцоог хангах асуудлыг хариуцсан баг нь НЖНТ-ний хэрэгжилтээр дамжуулан Компактын хүрээнд хэрэгжиж буй бүх төсөл, үйл ажиллагаанд нийгэм болон жендэрийн асуудлуудын хэрэгжилтийг хангах ерөнхий үүрэгтэй. Нийгэм, жендэрийн оролцооны асуудал хариуцсан баг нь Нийгэм, жендэрийн оролцоо хариуцсан захирал болон Нийгэм, жендэрийн мэргэжилтнээс бүрдэнэ. Тус баг нь Компакт гэрээний хэрэгжилт, үйл ажиллагааны үе шат бүрд МСК-ын Жендэрийн бодлого, Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ын Гүйцэтгэлийн стандарт (ГС), Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, бодлого, стандартуудыг хангуулах үүрэгтэй юм. Түүнчлэн, Нийгэм, жендэрийн оролцооны асуудал хариуцсан баг нь Хөтөлбөрийн менежментийн зөвлөх (ХМЗ) болон БОНУ-ний багтай хамтран Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа болон Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагааны хүрээнд боловсруулан хэрэгжих Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ), Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) болон Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө (НШТ)-нд жендэр, нийгмийн оролцоог хангахтай холбогдох шаардлагуудын хэрэгжилтийг хангах, хянах үүрэгтэй.

Нийгэм, жендэрийн оролцоог хангах асуудал хариуцсан баг нь Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа болон Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх дэд үйл ажиллагааг хариуцдаг. Эдгээр дэд үйл ажиллагаа нь хэрэглэгчдийн мэдээллийг цуглуулах, мэдээллийг үр дүнтэй ашиглахад суурилсан бодлогын өөрчлөлтөөр дамжуулан УБ хотын аж байдлын түвшин доогуур өрхүүдийн хувьд тэгш хүртээмжтэй усны үйлчилгээний үнэ тариф болон тэдний худалдан авах чадвартай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэх юм. Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагаа нь хэрэглэгчдийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаанаас гадна усны ашиглалтын болон зохицуулагч байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зорилго бүхий Зардал нөхөх төлөвлөгөө (ЗНТ)-г боловсруулахад мэдээллээр хангах зорилготой юм. Түүнчлэн, Нийгэм, жендэрийн асуудал хариуцсан баг нь Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих дэд үйл ажиллагааны хүрээнд АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж буй Нийтийн аж ахуйн салбарт жендэрийн оролцоог нэмэгдүүлэх болон Хэрэглэгчдийн мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийж ашиглах бүрэлдэхүүн хэсгүүдэд техник, арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллах юм. Үүнээс гадна, Зардал нөхөх техникийн туслалцаа (ЗНТТ)-ны хүрээнд Нийгэм, жендэрийн асуудал хариуцсан баг нь хэрэглэгчдийн төлбөрийн чадамжийг тодорхойлох болон Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр (ХДХ)-ийг боловсруулах үйл ажиллагаагаар дамжуулан ЗНТ-г боловсруулахад оролцох бөгөөд Монголын МСС нь хөтөлбөрийн санхүүжилтийн Урьдчилсан болзолт нөхцөл (УБН)-ийн нэг болох ЗНТ-ний тарифын өөрчлөлтийн хувилбарыг боловсруулах юм.

D. МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САНГИЙН НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН НЭГТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. НЖНТ 1.0

Компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлж буй дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтын төслүүд нь Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа болон Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаа юм. Монголын МСС-гийн зүгээс эдгээр үйл ажиллагааны нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжуудыг тодорхойлох, холбогдох эрсдэлүүдийг үнэлэх зорилгоор НЖНТ Хувилбар 1.0-ийг боловсруулж, Компакт гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө зарлагдсан тендерийн баримт бичигт тусгасан болно. Компакт гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнө боловсруулж, батлуулсан НЖНТ-ний Хувилбар 1.0 тендерт оролцогчид, гэрээлэгч байгууллагууд, тэдгээрийн туслан гүйцэтгэгч нарт Компактын НЖНТ болон дараах шаардлагуудын хоорондын уялдаа холбооны талаарх мэдээллийг өгөх зорилготой байв. Үүнд:

1. ОУСК-ын ГС-д заасан техник, арга зүй, хүний нөөц, хяналтын шаардлагыг дагаж мөрдөх;
2. МСК-ын Жендэрийн бодлого, МСК-ын ХХГХТ бодлого, МСК-ын Бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх зааварчилгаа болон бусад холбогдох гэрээний стандарт заалтуудыг дагаж мөрдөх;
3. МСК-ын Компакт гэрээний хүрээнд санхүүжүүлж бүтээн байгуулалтын төсөлд ажиллаж буй нийт ажиллах хүчний 30-аас багагүй хувь нь эмэгтэй байлгаж зорилтод хүрэх болон эмэгтэйчүүдийн эдийн засгийн хувьд чадавхжуулах;
4. БОНМТ-нд тусгасан холбогдох шаардлагуудад нийцүүлэн гэрээлэгчийн БОНМТ-г боловсруулан хэрэгжүүлэх зэрэг болно.

2. НЖНТ 2.0

НЖНТ Хувилбар 2.0-ыг боловсруулахдаа үндэсний, нийслэлийн болон дүүргийн хэмжээний оролцогч талуудтай зөвлөлдөж, тэдний идэвхтэй оролцоог хангаж ажиллав. Түүнчлэн Монголын МСС-гийн холбогдох багуудад болон Хөтөлбөрийн менежментийн зөвлөх (ХМЗ) багийн Жендэрийн мэргэжилтэнд НЖНТ Хувилбар 1.0-ийг танилцуулж, дотоодын санал солилцох уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Мөн НЖНТ-ний Үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, нийгэм, жендэрийн холбогдох дүн шинжилгээг нэмж боловсруулан багтаасан болно. НЖНТ Хувилбар 2.0-ыг боловсруулах ажлын хүрээнд хийсэн оролцогч талуудын уулзалт, хэлэлцүүлгийн мэдээлэл болон цаашид талуудын оролцоог хангах нарийвчилсан төлөвлөгөөний мэдээллийг Бүлэг IX-өөс харна уу.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр, МСК-ын Жендэрийн бодлого, Монгол Улсын болон олон улсын бусад бодлого зэрэгтэй нийцүүлж НЖНТ Хувилбар 2.0-ыг боловсруулах үүднээс Монголын болон олон улсын холбогдох хууль, тогтоомж, бодлого, журмуудыг судалж, нэмэлт дүн шинжилгээг хийсэн болно. НЖНТ Хувилбар 2.0-ыг боловсруулах болон эхний хувилбарыг шинэчлэх ажлын хүрээнд Монголын МСС-гийн Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл (УСТБХТ)-ийн багтай хамтран ажилласан бөгөөд УСТБХТ-ийн үйл ажиллагаатай уялдуулсан болно. Хэрэглэгчдийн худалдан авах чадвар болон бага орлоготой өрхүүдтэй холбогдох асуудлаас үүсч болохуйц эрсдэлийг бууруулах арга хэмжээг тус төлөвлөгөөний Бүлэг V-т багтаасан болно.

III. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Энэхүү бүлэг нь Компакт гэрээний хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаатай холбогдох болон тус төлөвлөгөөг боловсруулахад ашигласан жендэрийн эрх тэгш байдал, хөдөлмөр, хүний эрхтэй холбоотой Монгол Улсын хууль, тогтоомж болон бодлогуудын талаарх ерөнхий мэдээллийг багтаав. Хөдөлмөр, хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, нийгмийн хамгаалалтай холбогдох бусад хууль, тогтоомжийг Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн суурь судалгааны тайлангаас харж болно.

A. МОНГОЛ УЛСЫН ХОЛБОГДОХ ХУУЛИУД

1. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ

Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн зорилт нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын эрх, үүргийг нарийвчлан тусгасан бөгөөд бүхий л салбарт жендэрийн ялгаварлан гадуурхалтаас дараах гурван арга замын хүрээнд урьдчилан сэргийлж, тэмцэхээр тогтоосон байдаг. Үүнд:

1. Жендэрийн үндэсний хорооны чадамжийг нэмэгдүүлэх;
2. Бодлого боловсруулалтын бүх түвшинд жендэрийн тэгш байдлын зорилтыг нэвтрүүлэх;
3. Салбар дундын жендэрийн мэдрэмжтэй бодлого боловсруулах.

Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа. Тус хуулийн 11 дүгээр зүйлд Компакт гэрээний худалдан авах үйл ажиллагааны хүрээнд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой заалтуудыг тусгасан бөгөөд үүнд 1) иргэнийг ажилд авахдаа тухайн байгууллага болон түүний бүтцийн нэгж дэх хүйсийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг харгалзан цөөн тоотой хүйсийн хүнийг сонгох (11.3.3); 2) адил хөдөлмөр буюу адил чанарын ажил эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил тэгш цалин хөлс олгох, ижил нөхцөл тогтоохтой холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах (11.3.4); 3) ажилд авах үйл явцыг ил тод байлгах гэх зэрэг заалтууд орсон.

Бэлгийн дарамттай тэмцэх арга хэмжээ. Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх зорилгоор ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах гэж заасан. Түүнчлэн тус хууль нь ажил олгогч бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг нээлттэй мэдээлэх үүргийг тусгайлан тусгасан.

2. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зорилт нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг нь тогтоон арилгах, хохирогчийн эрхийг

хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Түүнчлэн, хуулийн хүрээнд нийгмийн хамгаалал, хөдөлмөр, эрүүл мэнд, боловсрол болон мэргэжлийн хяналт зэрэг салбарын төрийн байгууллагуудын хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мөн хохирогчийг хамгаалах болон туслахтай холбоотой хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага, эрх зүйн хэм хэмжээг тодорхойлсон. Тус хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжуудын зүйл заалтуудтай уялдсан.

3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

Энэ хууль нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэхэд төр, төрийн бус байгууллага, иргэд, хуулийн этгээд болон эрх бүхий этгээдүүд хэрхэн оролцох талаарх эрх зүйн үндсийг тогтоосон. Тус хуулийг баталснаар эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулах болон эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад том алхам болсон юм. Тус хууль нь Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиудтай уялдсан.

4. ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ

Хүйсээр ялгаварлах болон насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хориглох. Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн ганцаарчилсан ба хамтын маргаан, хөдөлмөрийн нөхцөл, удирдлага, хяналт болон хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж талуудын харилцан эрх тэгш байдлыг хангахад оршино. Тус хууль нь ажлын байран дээрх жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтыг хориглохоос гадна жирэмсэн болон хөхүүл ээжүүдийн эрхийг хамгаалсан зүйл заалтуудыг тусгаж өгсөн. Ажлын байран дээрх бэлгийн дарамтыг тус хуульд шууд тодорхойлон тусгаагүй бөгөөд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд тусгасан. Хуулийн 109 дүгээр зүйлд насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг тусгайлан заасан бөгөөд ажил олгогч насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно гэж тусгайлан заасан.

5. ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ

Энэ хуулийн зорилт нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус хууль нь орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээтэй холбогдох дүрэм журам, ус хангамжийн байгууллага, хэрэглэгчдийн харилцааг тусгайлан зохицуулсан заалтуудыг багтаасан. Усны тоолууртай хэрэглэгчдийн усны үйлчилгээний төлбөрийг баталгаажсан усны тоолуурын заалтыг үндэслэн тооцох бөгөөд усны тоолуургүй хэрэглэгчийн хэрэглэсэн унд, ахуйн ус, хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг тогтоосон хэрэглээний жишиг, нормыг үндэслэн тодорхойлон тооцно. Хэрэв үйлчилгээний төлбөрөө цагт нь төлөөгүй хуримтлуулсан гэх зэрэг хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд заасан нөхцөлийг хэрэглэгч

биелүүлээгүй тохиолдолд усны үйлчилгээг хязгаарлаж болно. Тус хуульд ХСУХАТАҮЗЗ-ийн үүрэг, эрх мэдлийг тусгасан бөгөөд усны үйлчилгээ үзүүлдэг тусгай зөвшөөрөл эзэмшдэг байгууллагуудын цэвэр, бохир усны суурь хураамж, усны үнэ тарифыг тогтоох аргачлалыг боловсруулах, хянах, аргачлалыг олон нийтэд танилцуулах үүрэг, хариуцлагыг тусгайлан хуульчилсан. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10.2.4 болон 10.3 хэсгүүдэд усны тариф нь үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурласан байхаас гадна тухайн хот, суурин газарт хүн амыг цэвэр усаар хангах үйлчилгээний тарифыг ижил түвшинд хүргэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ гэж тусгажээ. Хяналт, зохицуулалтын тухайд усны чанарыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) хянах бөгөөд цэвэр бохир усны үйлчилгээний чанар, тарифын талаарх хэрэглэгчдийн гомдлыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар (ШӨХТГ) хянан шийдвэрлэнэ гэж заасан байна.

В. НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБОГДОХ БОДЛОГУУД

1. МОНГОЛЫН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГО

Монгол Улсын Засгийн газраас жендэрийн асуудалд чиглэсэн бодлого, төлөвлөлтийг сурталчлах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, Жендэрийн тэгш эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд жендэрт суурилсан ялгаварлан гадуурхах явдлыг арилгахад чиглэсэн системтэй арга хэмжээ авах зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг 2017 онд батлан гаргасан. Түүнчлэн, Жендэрийн үндэсний хорооны үндсэн чиг үүрэгт жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр болон бусад арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажил багтдаг бөгөөд үүнд жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эдийн засаг, хууль эрх зүйн нөхцөл байдлыг үнэлэх, хянах болон зөвлөмж хүргүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлэхэд үндэсний хэмжээний институцүүдийн чадавхыг нэмэгдүүлэх гэх мэт чиг үүрэг орно. Жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамттай холбоотой асуудлыг Гэр бүлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Боловсролын тухай багц хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудад тус тус тусгасан байдаг.

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРТ ЖЕНДЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО (2018-2025)

Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)-ны барилга, хот байгуулалтын салбарт баримтлах жендэрийн бодлого нь жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт, үнэлгээг барилга хот байгуулалтын салбарт хөгжүүлэх зорилготой. Тус бодлого нь барилгын салбарт ажиллаж буй ажилчид болон шийдвэр гаргагчдын дунд жендэрийн тэнцвэртэй байдлыг дараах алхмуудад тулгуурлан бий болгох юм. Үүнд:

- Хот, суурин, барилга байгууламжийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, бүтээн байгуулах үндэсний чадварыг сайжруулах;
- Барилга, хот байгуулалтын салбарт ажиллагчдын зохистой хөдөлмөр эрхлэлтийг жендэрийн мэдрэмжтэй хүний нөөцийн бодлогоор дэмжих;
- Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхлаас сэргийлэх, жендэрийн асуудлаар санал гомдол хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог байгууллагын түвшинд хөгжүүлэх;

- Ажлын байран дээрх ялгаварлан гадуурхах, дарамтаас урьдчилан сэргийлэх дүрмийг боловсруулахад зөвлөмж бэлтгэх, ажлын байран дээрх бэлгийн дарамт, хүйс болон насаар ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх;
- Төр, хувийн хэвшлийн байгууллагуудын дунд жендэрийн хариу үйлдэл үзүүлэх хүн төвтэй, нийгмийн хариуцлагатай менежментийн загварыг бий болгож, сурталчлах;
- Жендэрийн тэгш байдлын зорилтыг дотоодын болон олон улсын тендерийн сонгон шалгаруулалтад тусгах, ингэснээр ажилчдын дунд аль нэг хүйсийн эзлэх хэмжээ 15%, шийдвэр гаргагчдын дунд эзлэх хэмжээ 25%-аас доошгүй байна.

3. ТӨРӨӨС ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогыг 2020-2030 онд гурван үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Гуравдугаар үе шатны хүрээнд 2026-2030 онд салбарын санхүүгийн бие даасан байдал хангагдаж, орон сууц, түүний инженерийн дэд бүтэц, ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, хүртээмж өсөн нэмэгдэж буй хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангах түвшинд хүрч, нийт хүн амын 90%-ийг инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангах нөхцөл бүрдэж, аюулгүй ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 90% болж, хүн амын 60% нь сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон байна. Тус бодлого нь салбарын санхүүгийн бие даасан байдлыг бий болгож цэвэр, бохир усны хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын зардлыг нөхөхөд шаардлагатай тарифын өөрчлөлт бий болоход суурь болох юм.

4. ГЭР ХОРООЛЛЫН ХЭРЭГЛЭГЧДЭД УСНЫ ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Монгол Улсын Засгийн газраас 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдөр гэр хороололд амьдардаг бага орлоготой гэр иргэдийн төлбөрийн чадамжтай холбоотой асуудлыг багасгах зорилгоор гэр хорооллын болон орон сууцны хэрэглэгчдийн төлдөг усны тарифын зөрүүг арилгах тухай тогтоол гаргасан. Энэхүү тогтоолоор Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй хэрэглэгчдийн усны тарифын түвшинг орон сууцанд амьдарч буй иргэдийн усны тарифын түвшинд аажмаар хүргэхэд шаардлагатай арга хэмжээний талаар ХСУХАТАҮЗЗ-д санал хүргүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад үүрэг болгосон байдаг. Түүнчлэн, Засгийн газрын тогтоолд усны тарифын хөнгөлөлтийн улмаас 2012 онд усны үйлчилгээ үзүүлэгчид учрах алдагдлыг тооцон санхүүжилтийг шийдэж, Нийслэл болон аймгийн засаг дарга нарт санхүүжилтийг жил бүрийн орон нутгийн төсөвт суулгахыг Сангийн сайдад үүрэг болгосон байдаг.

Тодорхой хугацаанд тус тогтоол нь усны тариф, хэрэглэгчдэд чиглэсэн татаас, усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын санхүүгийн тогтвортой байдлыг хангах болон хэрэглэгчдийн эдийн засгийн хамгаалал хоорондын уялдаа холбоо чухал гэдгийг харуулсан. Гэвч усны тариф, хэрэглэгчдийн төлбөр төлөх чадамж болон санхүүгийн тогтвортой байдал зэргийн уялдааг хангасан урт хугацааны бодлого дутагдаж байгаа юм.

С. МСК-ЫН ШААРДЛАГА БОЛОН ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУД

1. ОУСК-ЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН СТАНДАРТУУД

ОУСК-ын Тогтвортой байдлыг хангах тогтолцоо (2012 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн) нь байгаль орчин, нийгмийн эрсдэл болон нөлөөллөөс урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулах, зохицуулах үйл ажиллагааг цогцоор нь тусгасан бүрэн хэмжээний бодлого, стандартуудын нэг хэмээн олон улсад өндөр үнэлэгдсэн тогтолцоонуудын нэг юм. Тус тогтолцоонд ОУСК-ын Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн Гүйцэтгэлийн стандартууд болон Мэдээллийн ил тод байдлыг хангах бодлого багтсан. ОУСК-ын Гүйцэтгэлийн стандартууд байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулахад захиалагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байдаг. Дараах найман Гүйцэтгэлийн стандартыг ОУСК-ын санхүүжилттэй төслүүд хэрэгжих хугацаанд захиалагч дагаж мөрдөх шаардлагатай гэж тодорхойлсон. Үүнд:

- Гүйцэтгэлийн стандарт 1: Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, эрсдэлийг үнэлэх, менежментийн төлөвлөгөө боловсруулах
- Гүйцэтгэлийн стандарт 2: Хөдөлмөр эрхлэлт ба ажиллах нөхцөл
- Гүйцэтгэлийн стандарт 3: Нөөцийн тогтвортой ашиглалт, бохирдлыг бууруулах
- Гүйцэтгэлийн стандарт 4: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал
- Гүйцэтгэлийн стандарт 5: Газар зохион байгуулалт, нүүлгэн шилжүүлэлт
- Гүйцэтгэлийн стандарт 6: Байгаль орчин, биологийн тогтвортой байдлыг хангах
- Гүйцэтгэлийн стандарт 7: Уугуул иргэд
- Гүйцэтгэлийн стандарт 8: Түүхийн өв, соёл

2. МСК-ЫН ЖЕНДЭРИЙН БОДЛОГО

МСК-ын Жендэрийн бодлогод Компакт гэрээгээр буцалтгүй тусламж авах шалгуурт тэнцсэн орнууд “МСК-аас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үнэлгээнд жендэрийн ялгаа, тэгш бус байдлын үнэлгээг хийх” үүрэг хүлээсэн байдаг. МСК болон Компакт гэрээг хэрэгжүүлэгч улс Компакт гэрээний хэрэгжилтийн үе шат бүрд оролцооны аргаар жендэрийн оролцоог хангах зэрэг тус бодлогын шаардлагыг хангах үүргийг хүлээнэ. Компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлгээний үе шат бүрд жендэрийн асуудлыг тусгах гол үүргийг гэрээг хэрэгжүүлэгч улс хүлээнэ. Тухайн улс нь Компакт гэрээг боловсруулах үе шатанд төлөвлөсөн төслийн үр шимийг эрэгтэй болон эмэгтэй хүмүүс тэгш хүртэх боломжийг хязгаарлагч жендэрийн тэгш бус байдлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

3. МСК-ЫН ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ БОДЛОГО

МСК нь хүн худалдаалах гэмт хэрэг буюу хүч хэрэглэх, залилан мэхлэх, албадан хүчлэх замаар бусдыг мөлжих гэмт хэргийг үл тэвчих бодлого баримталдаг. Тус бодлогын хүрээнд хүн худалдаалах гэдэг нь 1) 18 нас хүрээгүй хүүхдийг хүч хэрэглэх, залилан мэхлэх, албадан хүчлэх замаар биеийг нь үнэлүүлэх; 2) хүүхдийг хүч хэрэглэх, залилан мэхлэх, албадан хүчлэх замаар албадан хөдөлмөр эрхлүүлэх, зарцлах, боолчлох зорилгоор хүмүүсийг ажилд зуучлах, ажилд авах, саатуулах, тэвэрлэх зэрэг багтана. Монголын МСС нь МСК-ын заавар, зөвлөмж болон хяналтад тулгуурлан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжүүлэлтэд ХХГХТ-д дагаж мөрдөх шалгуур үзүүлэлтүүдийн хяналтыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ. Тус шалгуур үзүүлэлтүүдийг МСК-ын ХХГХТ

бодлогын Хавсралт А-д тодорхой тусгасан бөгөөд төслийн бүх бичиг баримт, ажил, үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг бүх гэрээнд тусгайлан тусгагдсан байдаг.

IV. ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮДИЙН ЭРСДЭЛ БОЛОН ЭЕРЭГ БОЛОМЖУУД

Тус бүлэгт Компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлж буй томоохон дэд бүтцийн төслүүдтэй холбогдох нийгмийн эерэг боломж болон сөрөг нөлөө, болзошгүй нөлөөлөл, эрсдэлүүдийг тодорхойлон дараах байдлаар харуулав. Үүнд:

- A. Компакт гэрээгээр санхүүжиж буй төсөл, үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг нэмэгдүүлэх:**
1. Төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах;
 2. Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн төгсөгчид, мэргэшсэн ажиллах хүчний ажлын байрны боломжийг нэмэгдүүлэх;
 3. Гэрээлэгчид нийт ажилчдынхаа 30 ба түүнээс дээш хувьд эмэгтэйчүүдийг авч ажиллуулах, сургахыг дэмжих;
 4. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг нэмэгдүүлэхэд ХМЗ-ийн үүрэг, хариуцлага.
- B. Дэд бүтцийн төслүүдтэй холбоотой нийгэм жендэрийн эрсдэлийг тодорхойлох, нөлөөллийг бууруулах:**
1. Барилгын салбар дахь хөдөлмөрийн мөлжлөг;
 2. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт;
 3. Хүн худалдаалах гэмт хэрэг;
 4. Бэлгийн дарамт;
 5. Нийгэм, жендэрийн эрсдэлийг тодорхойлох, нөлөөллийг бууруулахад ХМЗ-ийн үүрэг, хариуцлага.

Тус бүлгийг боловсруулахад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хийсэн хэлэлцүүлэгүүдийн үр дүн, Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн БОННУ болон МСК-ын бусад орнуудад хэрэгжүүлсэн дэд бүтцийн томоохон төслүүдийн туршлагауудыг ашигласан. Түүнчлэн, тус бүлэг нь Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн БОНМТ-тэй холбогдох суурь мэдээлэл болон холбогдох шаардлагауудыг багтаасан болно.

Шаардлагатай бол тус НЖНТ-г Хаягдал ус дахин боловсруулах төслийн БОННУ бүрэн дууссаны дараа холбогдох нэмэлт мэдээллийг багтаан шинэчлэх болно.

A. КОМПАКТ ГЭРЭЭГЭЭР САНХҮҮЖИЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ТҮР АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Тус дэд бүлэг нь дэд бүтцийн төслүүдийн хэрэгжилттэй холбоотой орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг нэмэгдүүлэхтэй холбоотой жендэр, нийгмийн дүн шинжилгээг багтаасан бөгөөд дараах дөрвөн хэсэгт хувааж боловсруулсан болно. Үүнд: 1) Төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах; 2) МСҮТ-ийн төгсөгчид, мэргэшсэн ажиллах хүчний ажлын байрны боломжийг нэмэгдүүлэх; 3) Гэрээлэгчид нийт ажилчдынхаа 30 ба түүнээс дээш хувьд эмэгтэйчүүдийг авч ажиллуулах, сургахыг дэмжих; 4) Орон нутгийн иргэдийн

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, богино хугацааны ажлын байрыг нэмэгдүүлэхэд ХМЗ-ийн үүрэг, хариуцлага. Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, орлого нэмэгдүүлэх боломжоор хангах нийгэм, жендэрийн оролцоог хангахтай холбоотой зорилтуудад хүрэх гол үйл ажиллагаануудын нэг нь Компактын үйл ажиллагааны хүрээнд бий болсон ажлын байрны талаарх мэдээллийг орон нутагт түгээх, орон нутгийн иргэдийг нээлттэй ажлын байранд өрсөлдөх нөхцөлийг нэмэгдүүлэх юм.

Компакт гэрээний санхүүжилтээр хэрэгжиж буй дэд бүтцийн төслүүдэд бий болох ажлын байранд Улаанбаатар хотын иргэд, ялангуяа төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэд болон эмэгтэйчүүдийг түлхүү хамруулж өрсөлдүүлэх замаар төслийн иргэдэд хүрэх үр шимийг нэмэгдүүлэх нь эрсдэлийн менежментийн нэг чухал хэсэг юм. Түүнчлэн, гадны хөрөнгө оруулалттай төслүүдэд нийтлэг ажиглагддаг сөрөг хандлага болох гадаадаас ажиллах хүч ихээр оруулж ирэн дотоодоос ажиллах хүч авдаггүй байдлыг Компактын хүрээнд хэрэгжих үйл ажиллагаануудад үүсгэхгүй байх нь чухал юм. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны тоон мэдээллээс үзэхэд, зөвхөн 2020 оны III улиралд 4,384 гадаад ажилчид Гадаадын иргэн, харьяатын газар бүртгэлтэй байгаагийн 64% нь барилга, уул уурхай, үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

1. ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨЖ БУЙ ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАХ

Ерөнхий мэдээлэл. Сонгинохайран болон Хан-Уул дүүргийн алслагдмал хэсгийн иргэдийн тодорхой хэсэг нь УБ хотын төвд амьдарч буй иргэдтэй харьцуулахад нийгэм, эдийн засгийн хувьд тусгаарлагдсан байдаг. Иймд шинээр бий болох ажлын байрууд нь хэдийгээр Компакт гэрээ хэрэгжиж дуустал цаг хугацааны хувьд хязгаарлагдмал боловч иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм.

- 2020 оны байдлаар төслийн нөлөөлөлд өртөж буй өрхийн дийлэнх хэсэг нь амьжиргааны баталгаажих түвшин (АБТ)-ээс доогуур буюу сард нэг хүнд ногдох орлогын хэмжээ 230,000₮-өөс бага байна. Эдгээр өрхийн дунд ажилгүйдэл өндөр, орлого олдог гэр бүлийн гишүүний тоо цөөн, эсвэл бага насны хүүхэд, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй гишүүн олонтой өрхүүд байгаа учир эдгээр өрх нь эдийн засгийн хямралд өртөх магадлал өндөр гэж үздэг.
- Төслийн нөлөөлөлд өртөж буй өрхүүдийн дунд эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх олон байгаа бөгөөд эдгээр нь эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхүүдтэй харьцуулахад ядууралд өртөх магадлал өндөр.
- Нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийн тодорхой хэсэг нь амьдралын нөхцөлөө дээшлүүлэх эдийн засаг боломж хайж олон нутгаас шилжин ирэгсэд байна. Эдгээр иргэд хувиараа албан бус хөдөлмөр эрхлэх нь элбэг бөгөөд зарим тохиолдолд бага цалинтай хөдөлмөрийн мөлжлөгөд өртөх магадлал өндөр байдаг. Тодруулбал, барилгын салбарт иргэд бригад болон нэгдэж ажил үйлчилгээ үзүүлэх нь түгээмэл байдаг. Эдгээр бригад нь ихэвчлэн албан бус байдалтай байдаг бөгөөд ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй нь ажлын байрны баталгаа болон аюулгүй байдлыг хангахгүй байх нөхцөл байдал үүсгэдэг.

Сонгинохайрхан болон Хан-Уул дүүргүүдийн Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтсийн Хөдөлмөрийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах хамгийн үр дүнтэй арга нь ажлын байрны зарыг орон нутагт түгээж, ажил олгогчидтой хамтран ажлын байрны нээлттэй өдөрлөг зохион байгуулах юм. Түүнчлэн, ажил олгогч нь төслийн нөлөөлөлд өртөж буй иргэдтэй шууд уулзалт

хийж, ажлын байрны боломжийн талаар мэдээлэл өгөх нь орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах үр дүнтэй аргуудын нэг юм. Дүүргүүдийн Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтсүүд ажлын байрны боломжийг эрэлхийлж буй иргэдийг хөдөлмөрийн эрэлтэд нийцүүлэх сургалт, чадваржуулах арга хэмжээнүүдийг зохион байгуулж, орон нутгийн захиргаа, ажилчид (үйлдвэрчний эвлэл), ажил олгогч нарын төлөөллийг багтаасан Гурван талт үндэсний хороотой хамтран ажилладаг. Тус ажлын хэсэг нь ажлын байрны нээлттэй өдөрлөг зохион байгуулах, ажлын байрны талаарх зарыг олон нийтэд хүргэхэд ажил олгогч нартай шууд хамтран ажиллах сонирхолтой байдаг.

Төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах нь эрсдэлийн менежментийн нэг чухал хэсэг юм. Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн БОННУ-г боловсруулах шатанд зохион байгуулсан оролцогч талууд болон олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр орон нутгийн иргэд тус төслийн хүрээнд олон тооны ажлын байр орон нутагт бий болно гэсэн хүлээлттэй байгаа талаараа илэрхийлж байв. Төслийн үргэлжлэх хугацаа болон онцлогийг бодолцон үзэхэд түр ажлын байрыг бий болгох нь орон нутгийн иргэдэд Компактын хүрээнд үзүүлж болох эерэг нөлөөллийн нэг юм. Иймээс, барилга угсралтын ажлын гүйцэтгэгч байгууллагууд төслийн хүрээнд орон нутгийн иргэдийг мэргэжлийн ур чадвар бага шаарддаг ажлын байранд хамруулах зэргээр дэмжих нь чухал юм. Барилгын гүйцэтгэгч компани орон нутгийн иргэдийг авч ажиллуулах нь олон талын ач холбогдолтой. Үүнд:

- Түр ажлын байр байгуулах болон гаднаас ажиллах хүч авахтай холбоотой захиргааны зардлыг бууруулах;
- Орон нутгийн иргэд болон ажилчдын хооронд үүсч болзошгүй аливаа эрсдэлийг бууруулах.

Гэрээлэгчийн үүрэг, харивцлага. Дэд бүтцийн төслийн гэрээт гүйцэтгэгчид нь Монголын барилгачдын нэгдсэн холбоо, орон нутгийн засаг захиргаа, барилгын салбарын худалдаа эрхлэгч, мэргэжлийн холбоодоор дамжуулан орон нутгаас ажиллах хүч хайх, тодорхойлох, ажилд авах арга зам ашигладаг. Түүнчлэн, төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдтэй барилгын ажил гүйцэтгэгч компани шууд уулзах нь үр дүнтэй арга юм. Дүүргийн Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтэс болон хороодын Засаг даргын тамгын газрууд орон нутгийн иргэдийг хөдөлмөрт зуучлах зэрэг хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг. Түүнчлэн, тус байгууллагууд ажилгүй болон ажил хайж буй иргэдийн мэдээллийг цуглуулдаг бөгөөд компаниуд эдгээр төрийн байгууллагуудтай хамтран орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах боломжтой юм. Мөн, компаниуд ажлын байрны зар нийтлэх болон ажлын өргөдөл гаргахад туслах замаар орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах боломжийг нэмэгдүүлнэ. Дэд бүтцийн тендерт шалгарсан гүйцэтгэгч компаниуд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Тодорхой шалгуур болон ажлын байрны төрлийг ил тод заасан нээлттэй ажлын байрны зарыг төслийн нөлөөлөлд өртсөн орон нутаг болон хороо, дүүргийн хэмжээнд зарлах;
- Нээлттэй ажлын байрны талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд тогтмол түгээх;
- Ажлын байрны боломж, худалдан авах ажиллагааны боломжийн талаар орон нутгийн иргэдийн тавьсан асуултуудад гэрээлэгч компани тогтмол хариу мэдээлэл өгч байх;
- Ирээдүйд бий болох ажлын байрны төлөвлөгөө болон ажлын байрны сонгон шалгаруулалтын стратегийг боловсруулах. Үүнд:

- Төслийн үе шат бүрд орон нутгийн иргэд, эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн болон туслах ажлын байраар хангах;
 - Нээлттэй ажлын байрны талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх;
 - Ажлын байрны төрөл бүрд эмэгтэй ажилчдын тоог нийт ажилчдын 30%-д хүргэхээр зорих;
 - Орон нутгийн хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон барилгын бригадад чиглэсэн сургалт зохион байгуулах
- Монголын МСС болон ХМЗ нартай хамтран иргэдийг ажлын байрны өргөдөл гаргахад туслах болон орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах зорилгоор нээлттэй ажлын байрны өдөрлөг зохион байгуулах;
 - Бүх төрлийн мэдээллийн хэрэгслийг ашиглан нээлттэй ажлын байрны талаарх мэдээллийг олон нийтэд үр дүнтэй хүргэх арга, хэрэгслүүдийг ашиглах.

2. МЭРГЭЖИЛ, СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ (МСҮТ)-ҮҮДИЙН ТӨГСӨГЧИД, МЭРГЭШСЭН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ АЖЛЫН БАЙРНЫ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

Ерөнхий мэдээлэл. Монгол Улс дахь мэргэшсэн ажиллах хүчний хомсдол, ялангуяа барилга болон уул уурхай салбар дахь мэргэжлийн боловсон хүчний хомсдол нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд саад болж буй хүчин зүйлсийн нэг юм. Үүнд, Компакт гэрээний санхүүжилтээр хэрэгжиж буй дэд бүтцийн төслүүдийн гэрээлэгч байгууллагууд болон тэдний туслан гүйцэтгэгч компаниуд ажлын байран дээрх сургалтаар хангах, инженерчлэл болон холбогдох салбарын оюутнуудыг дадлага хийх болон дагалдан ажиллах боломжоор хангах гэх зэрэг ажиллах хүчний нөөц бүрдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй алхмуудыг хэрэгжүүлэх нь чухал юм.

Барилгын салбарт нүүрлээд буй мэргэжлийн боловсон хүчний хомсдолыг бууруулах үүднээс Монгол Улсын Засгийн газар МСҮТ-үүдтэй холбоотой хууль, эрх зүйн орчныг сайжруулах болон залуусыг МСҮТ-д элсэн ороход түлхэц болохуйц бодлогоор дэмжих арга хэмжээг авч ажиллаж байна. Түүнчлэн, салбарын эрэлттэй байгаа боловсон хүчний төрөл болон МСҮТ-үүдийн сургалтын хөтөлбөрийг уялдуулах талаар ажиллаж байна. Жишээ нь, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ны харьяа Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв (МБСҮМАЗТ) нь Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН)-тэй хамтран барилгын салбарын ажиллах хүчний эрэлтийн судалгааг боловсруулж байна. Тус судалгаа нь барилгын салбар дахь одоогийн болон ирээдүйн ажиллах хүчний эрэлтийн нарийвчилсан дүн шинжилгээг хийх юм. Энэ нь МСҮТ-үүдэд тулгараад буй гол асуудлуудын нэг болох салбарын зах зээл, боловсон хүчний эрэлтэд тулгуурласан боловсон хүчин бэлтгэдэг болох чухал алхам юм. Түүнчлэн, МСҮТ-үүдийн сурагчид хангалттай дадлага хийдэггүй, сургалтын хөтөлбөрийн чанарын хяналтыг нэмэгдүүлэх шаардлагатай, МСҮТ-үүдийн төсөв санхүүгийн хангалтгүй байдал зэрэг томоохон бэрхшээлүүдийг Засгийн газраас шийдвэрлэхээр ажиллаж байна.

Гэрээлэгчийн үүрэг, хариуцлага. Дэд бүтцийн төслийн гэрээлэгч болон тэдний туслан гүйцэтгэгч компаниуд иргэд, ажилчид болон оюутнуудыг дадлага хийх, дагалдангаар ажиллах, эсвэл техник ур чадварын сургалтад хамруулах нь ажил олгогчдод чухал давуу тал болох юм. Гэрээлэгч байгууллага дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнд:

- Орон нутгийн иргэд болон ажилчдад ажлын байран дээрээ техникийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд чиглэсэн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах;
- МСҮТ, Шинжлэх ухаан, техникийн их сургууль, Монголын Барилгын үндэсний ассоциац зэрэг холбогдох боловсрол, сургалт, ур чадвар нэмэгдүүлэхэд чиглэсэн байгууллагуудтай дараах хүрээнд хамтрах. Үүнд:
 - Мэргэшсэн ажиллах хүчийг ажилд авах;
 - Ус, инженерчлэл болон бусад холбогдох сэдвээр их дээд сургуульд суралцдаг оюутнуудыг дадлага болон дагалдах хөтөлбөрөөр хангах.
- Ажилчдад техник ур чадвар сайжруулах сургалт, ажлын байран дээрээ дадлага, дагалдан ажиллах сургалтыг МСҮТ зэрэг байгууллагуудтай хамтран хүргэх.

3. ГЭРЭЭЛЭГЧИД НИЙТ АЖИЛЧДЫНХАА 30 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВЬД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АВЧ АЖИЛЛУУЛАХ, СУРГАХЫГ ДЭМЖИХ

Ерөнхий мэдээлэл. Дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой салбар дахь эмэгтэйчүүдийн нөхцөл байдал Монгол Улсад харьцангуй тааруу байна. Жишээ нь, барилгын салбарт ажилладаг эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй харьцуулахад 69%-аар бага орлоготой байна. Төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутагт амьдардаг эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхийн нэг хүнд оногдох сарын дундаж орлогын хэмжээ 241,880₮ байгаа нь ядуурлын шугам буюу 230,000₮-өөс дөнгөж 11,880₮-өөр л өндөр байна. Эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрхүүдийн олонх нь амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьдарч байгаа бөгөөд тэдний дунд ажилгүйдэл их байгаа нь гэр бүлийн олон гишүүнээ асардаг болон ажилд ороход хүйсээр ялгаварлан гадуурхалтай тулгардагтай холбоотой юм. Эмэгтэйчүүд эдийн засгийн бүх салбарт эрэгтэйчүүдтэй ажлын байрны ижил боломжтой байх шаардлагатай бөгөөд ижил төрлийн ажил хөдөлмөрт адил хэмжээний цалин авдаг байх нь чухал юм.

Монгол эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд, түүний дотор барилгын салбарт тодорхой хэмжээгээр оролцдог боловч харьцангуй бага байдаг нь тус салбарт эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой олон асуудал байдагтай холбоотой юм. Эмэгтэйчүүд зөвхөн цалингийн тэгш бус байдалтай холбоотой ажлын байран дээрх хүйсийн ялгаварлан гадуурхалтад өртөхөөс гадна ажил олгогчид эмэгтэйчүүдийг ажилд авах тал дээр ялгавартай ханддаг болон ажлын байран дээр эмэгтэйчүүдийн тушаал ахиж дэвших боломж бага байдаг юм. Эдгээр нь ажлын байран дээрх хүйсийн ялгаварлан гадуурхалтыг бий болгодог бөгөөд зарим тохиолдолд ажлын байрны бэлгийн дарамтын суурь болж байдаг. Сонгинохайрхан болон Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтэстэй хийсэн зөвлөх уулзалтаас үзэхэд ажил олгогчид 40-өөс дээш насны болон хүүхдээ асрах шалтгаанаар хөдөлмөр эрхлэлгүй удсан эмэгтэйчүүдийг ажилд авах сонирхолгүй байна. Түүнчлэн, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд урт хугацааны тогтвортой эсвэл хагас цагийн ажил эрхлэх сонирхолтой байдаг байна. Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хэлтсийн тоон мэдээнээс үзэхэд тус дүүргийн нийт ажилгүй иргэдийн 60% нь эмэгтэйчүүд байна.

Хэдийгээр барилгын салбар дахь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн хувь харьцангуй бага байгаа боловч инженерчлэл, үйлдвэрлэл болон барилгын чиглэлээр их дээд сургуулиудад сурдаг оюутнууд болон төгсөгчдийн нийт тоог харвал Монголын МСС-гийн дэд бүтцийн төслийн гэрээлэгчид ШУТИС, МСҮТ болон бусад холбогдох төрлийн боловсон хүчин бэлтгэдэг сургуулиудын төгсөгчдөөс чадварлаг, мэргэшсэн эмэгтэй ажиллах хүч олох боломжтой юм. Түүнчлэн, энэ нь барилгын салбар дахь эмэгтэй мэргэшсэн боловсон хүчний нийлүүлэлт бага эсвэл тэдний ур чадвар дутмаг гэдгээс

илүүтэй эмэгтэйчүүдийн барилгын салбар дахь ажил эрхлэлт бага байгаа нь хүйсийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гэдгийг харуулж байна.


- БХБЯ-ны Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаарх баримтлах бодлогын тоо баримтаас үзэхэд, барилгын чиглэлээр суралцаж буй нийт оюутнуудын 40% нь эмэгтэйчүүд байна.
- 2020 оны Дэлхийн жендэрийн тэгш байдлын ялгаа (Global Gender Gap) судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсад их дээд сургуульд суралцаж буй нийт эмэгтэйчүүдийн дөнгөж 9.84% нь инженерчлэл, үйлдвэрлэл, барилгын чиглэлээр суралцаж байгаа гэсэн тоон мэдээлэл байгаа нь эрэгтэйчүүдийн дунд тус үзүүлэлт 33.12% байгаатай харьцуулахад маш бага тоо юм.
- Өөр нэг судалгааны үр дүнгээс харахад 2016 онд нийт инженерчлэл, үйлдвэрлэл, барилгын чиглэлээр суралцаж буй оюутнуудын 20.4% нь эмэгтэйчүүд байсан байна (MECSS 2017).

Зураг 1. Барилгын салбар дахь эрэгтэй, эмэгтэй ажилчдын харьцаа



Барилгын салбар дахь эрэгтэй болон эмэгтэй ажилчдын хоорондын цалингийн ялгаа судалгаануудын үр дүнгээс илт харагдаж байна. Эмэгтэйчүүдийн хувьд барилгын салбар дахь ажлын байр нь цалингийн хувьд бусад салбартай харьцуулахад өндөр байдаг байна. Доорх Зураг 2-т харуулснаар, 2019 оны байдлаар эмэгтэй болон эрэгтэй хүмүүсийн цалингийн хэмжээ хоорондоо ялгаатай буюу улсын дунджаар эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн цалингийн 84%-тай тэнцэх хэмжээний цалин авч байна. Харин барилгын салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн тоо харьцангуй цөөн боловч дундаж цалингийн хэмжээгээр эрэгтэйчүүдээс яльгүй өндөр буюу 3% илүү байна. Энэ нь барилгын салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн ихэнх хэсэг нь мэргэжлийн ур чадвар өндөр шаарддаг ажил эрхэлдэг бөгөөд эдгээр ажил нь нийт барилгын салбарын дундаж цалинтай харьцуулахад өндөр байдагтай холбоотой юм. Ус хангамж, ариутгах татуургын салбарт эрэгтэй болон эмэгтэйчүүдийн дундаж цалин ойролцоо (эрэгтэйчүүдтэй харьцуулахад 0.96%) байгаа бол эмэгтэйчүүд Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа (1.13%), Уул уурхай болон олборлолт (1.09%), Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа (1.08%)-ны салбаруудад эрэгтэйчүүдээс дунджаар өндөр цалин авч байна.

Зураг 2. Эрэгтэй болон эмэгтэйчүүдийн цалингийн харьцаа, Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар



Гэрээлэгчийн үүрэг, хариуцлага. Гэрээлэгч нь ажилчдыг сонгон шалгаруулахдаа эмэгтэйчүүдэд давуу байдал үүсгэх үүрэггүй юм. Харин гэрээлэгч нь эмэгтэйчүүдийг ажилд орох ижил тэгш боломжоор хангах, эмэгтэйчүүдэд шинэ нээлттэй ажлын байрны талаарх зарыг хүргэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх нь орон нутгийн иргэдийн дунд түр ажлын байрыг нэмэгдүүлэхэд ч мөн адил чухал нөлөөтэй юм. Гэрээлэгчид орон нутгийн иргэд, тэр дундаа эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах, тэдэнд мэдээлэл хүргэх зорилгоор орон нутгийн болон төрийн байгууллагууд, Монголын Барилгачдын холбоо зэрэг салбарын байгууллагуудтай хамтрахаас гадна орон нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулах гэх зэрэг олон нөөц боломж байгаа юм. Дүүргийн Хөдөлмөр, нийгмийн халамжийн хэлтэс болон хороодын Засаг даргын тамгын газрууд тухайн орон нутгийн иргэддээ хөдөлмөр зуучлал зэрэг хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг юм. Түүнчлэн, тус байгууллагууд ажилгүй болон ажил хайж буй иргэдийн мэдээллийг хүйсээр ангилан цуглуулдаг бөгөөд компаниуд эдгээр төрийн байгууллагуудтай хамтран орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах боломжтой юм. МСК-ын төсөл хөтөлбөрийн ажилчдын 30%-аас багагүй хэсэг нь эмэгтэй байх зорилтыг хэмжихийн тулд гэрээлэгч байгууллагууд хүйсээр ажилчдыг ангилсан жагсаалттай байх шаардлагатай бөгөөд үүнийгээ тогтмол шинэчлэх үүрэгтэй юм.

4. ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, ТҮР АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ХМЗ-ИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Компактын хүрээнд хэрэгжиж буй дэд бүтцийн төслүүдэд орон нутгийн иргэдийн түр ажлын байраар хангагдах боломжийг нэмэгдүүлэх нь зөвхөн гэрээлэгчийн үүрэг хариуцлага биш юм. Монголын МСС нь гэрээлэгчдийг орон нутгийн болон үндэсний хэмжээний төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахад чиглүүлэх бөгөөд ХМЗ нь гэрээлэгч үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих юм.

Монголын МСС-гийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон үүрэг хариуцлагууд Бүлэг VI буюу Үйл ажиллагааны төлөвлөгөө хэсэгт багтсан болно. Харин тус дэд бүлэгт Монголын МСС болон ХМЗ компанийн зүгээс төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн төгсөгчид, мэргэшсэн ажиллах хүчний ажлын байрны боломжийг нэмэгдүүлэх, гэрээлэгчид нийт ажилчдынхаа 30 ба түүнээс дээш хувьд эмэгтэйчүүдийг авч ажиллуулах, сургахыг дэмжих зэрэгт хүлээх үүргийг ерөнхийд нь багтаасан болно.

Төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах.

Монголын МСС-гийн зүгээс дүүргийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хэлтэс болон орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлээр Гэрээлэгч байгууллагын Нийгэм, жендэрийн оролцоо хариуцсан менежер болон Олон нийттэй харилцах ажилтантай хамтран ажиллана. Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд Монголын МСС нь дараах ерөнхий үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Гэрээлэгч компанийг дүүргийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хэлтэстэй холбон зуучлах;
- Гэрээлэгч компанийн Нийгэм, жендэрийн оролцоо хариуцсан менежерийг нөлөөлөлд өртсөн орон нутгийн ажиллах хүчний мэдээллийг гаргах, орон нутгийн иргэдэд нээлттэй ажлын байрны талаар мэдээлэл түгээх, зөвшилцөх уулзалт зохион байгуулахад чиглүүлэх;
- Гэрээлэгч компанийг нээлттэй ажлын байрны өдөрлөг болон орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан худалдан авах үйл ажиллагаатай холбоотой нээлттэй өдөрлөг зохион байгуулахад чиглүүлэх.

Харин ХМЗ компанийн зүгээс Гэрээлэгч компанийн орон нутгийн хөдөлмөрийн хэлтсүүдтэй хэрхэн хамтран ажиллаж байгаа болон орон нутгийн иргэдийг ажлын байрны боломжоор хангах тал дээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт тавина. Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд ХМЗ нь дараах ерөнхий үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Гэрээлэгч компанийн Нийгэм, жендэрийн оролцоо хариуцсан менежер нь нөлөөлөлд өртсөн орон нутгийн ажиллах хүчний мэдээллийг цуглуулах, орон нутгийн иргэдэд нээлттэй ажлын байрны талаар мэдээлэл түгээх, зөвшилцөх уулзалт зохион байгуулж буй эсэхэд хяналт тавих;
- Орон нутгийн иргэдэд нээлттэй ажлын байрны талаарх мэдээллийг түгээж буй эсэхэд хяналт тавих;
- Гэрээлэгч байгууллагыг орон нутгийн нийгмээс тусгаарлагдсан болон эмзэг бүлгийн иргэдийг ажлын байраар хангах боломжийг нэмэгдүүлэхэд уриалах зэрэг болно.

Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн төгсөгчид, мэргэшсэн ажиллах хүчний ажлын байрны боломжийг нэмэгдүүлэх.

Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн оролцоо хариуцсан багаас ХНХЯ-ны харьяа МБСҮМАЗТ-тэй албан ёсны хамтын ажиллагаа эхлүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд тус хамтын ажиллагааны үр дүнд Гэрээлэгчид МСҮТ-ийн төгсөгчдийг ажлын байраар хангах боломж нээгдэх юм. Түүнчлэн Монголын МСС болон МБСҮМАЗТ-ийн хамтын ажиллагааны хүрээнд МСҮТ-ийн сурагчдад Гэрээлэгч байгууллагын ажлын байран дээр дадлага хийх боломж нээгдэх юм. Ажлын байран дээр дадлага хийх боломжийг нэмэгдүүлэх нь орон нутгийн

иргэдийг ажлын байраар хангах болон иргэдийн мэргэжлийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх чухал алхам болох юм.

Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн төгсөгчид, мэргэшсэн ажиллах хүчний ажлын байрны боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд ХМЗ дараах ерөнхий үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Их сургуулиудын инженерийн хөтөлбөр, МСҮТ-үүд, мэргэжлийн холбоодтой хамтран мэргэшсэн, чадварлаг боловсон хүчнийг олж, ажилд авах чиглэлээр явуулж буй Гэрээлэгч компанийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- МСҮТ-ийн оюутнуудыг дадлага хийх, дагалдан суралцах боломжоор хангах талаар ажиллахад гэрээлэгчдийг дэмжин ажиллах.

Гэрээлэгчид нийт ажилчдынхаа 30 ба түүнээс дээш хувьд эмэгтэйчүүдийг авч ажиллуулах, сургахыг дэмжих. Компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлж буй нийт төсөл, үйл ажиллагаанд оролцож буй ажилчдын 30%-д эмэгтэйчүүд байх зорилгод хүрэхийн тулд Монголын МСС-гийн Нийгэм жендэрийн оролцооны асуудал хариуцсан захирал болон мэргэжилтэн үйл ажиллагааны төлөвлөлт, худалдан авалт, барилга угсралт, хаалт зэрэг дэд бүтцийн төслүүдийн үе шат бүрд техник, арга зүйн зөвлөгөө, заавар чиглэл, хяналтаар ханган ажиллах шаардлагатай. Түүнчлэн Монголын МСС-гийн удирдлага, Монголын МСС-гийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан баг, Байгаль орчин, нийгмийн үнэлгээ хариуцсан баг, дэд бүтцийн төслүүд хариуцсан баг, МСК-ын Суурин төлөөлөгчийн газар болон ХМЗ-ийн хамтын ажиллагаа болон дэмжлэг нэн чухал юм. Төсөл, хөтөлбөрийн хамгийн чухал үр дүнгүүдийн нэг нь Гэрээлэгч компани нийт ажилчдын ихэнх хувийг орон нутгийн иргэдээс бүрдүүлэхээс гадна ажилчдын 30%-д эмэгтэйчүүдийг авч ажиллуулах юм. Энэ нь Гэрээлэгчийн боловсруулсан Олон нийттэй харилцах төлөвлөгөөний хүрээнд Гэрээлэгч компанийн ажилчид орон нутгийн иргэд, тэр дундаа эмэгтэйчүүдэд нээлтэй ажлын байрны талаарх мэдээллийг хэрхэн түгээх болон ажиллах сонирхолтой иргэдийн нэрсийн жагсаалтыг хэрхэн боловсруулахаас ихээхэн хамаарна. Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах боломжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа нь эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах боломжийг нэмэгдүүлэхэд мөн адил чухал нөлөө үзүүлнэ. Монголын МСС дараах үндсэн үүргийг хүлээнэ. Үүнд:

- Гэрээлэгч компани ажлын байрны ур чадварын түвшин бүрд ажилчдын 30%-д эмэгтэйчүүдийг авч ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;
- Орон нутгийн мэргэжилтэй болон мэргэжилгүй иргэд, тэр дундаа эмэгтэйчүүд, залуусыг ажлын байраар хангах болон орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчдээс худалдан авалт хийхэд Гэрээлэгчдийг дэмжин ажиллах.

ХМЗ нь дээрх зорилтуудад хүрэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг хянах үүрэг, хариуцлага хүлээнэ.

В. ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ

Тус бүлэгт Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн БОННУ болон БОНМТ-үүдэд тулгуурлан Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн оролцоог хангах асуудал хариуцсан баг, Гэрээлэгчид, ХМЗ компаниудтай хамтран болзошгүй нөлөөллийг бууруулах нийгмийн дөрвөн эрсдэлийг авч үзэв. Тэдгээр эрсдэлийг Монголын МСС-

гийн Байгаль орчин, нийгмийн үнэлгээ хариуцсан багтай хамтран БОНМТ-ны хүрээнд бууруулах арга хэмжээ авах юм. Эдгээр эрсдэлүүд нь 1) барилгын салбар дахь хөдөлмөрийн мөлжлөг; 2) хүүхдийн хөдөлмөр эрхлэлт; 3) хүн худалдаалах гэмт хэрэг; болон 3) бэлгийн дарамт болно. Түүнчлэн тус бүлэгт дээрх эрсдэлүүдийг бууруулахад Монголын МСС болон ХМЗ компанийн хүлээх үүрэг, хариуцлагыг багтаасан болно.

1. БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН МӨЛЖЛӨГ

Ерөнхий мэдээлэл. Монголын барилгын салбарт хөдөлмөрийн мөлжлөгтэй холбогдох эрсдэл дотоодын болон гадаадын ажилчдын хувьд өндөр байна. Дэлхийн банкнаас гаргасан Улаанбаатар хотын ядуурлын байдал (Singh 2017) судалгаанаас үзэхэд 2010-2014 оны хооронд нийт ажиллах хүчний хамгийн ядуу 20%-д ногдох ажиллах хүчний цалингийн өсөлтийн талаас илүү хувийг барилгын салбар эзэлж байна. Гэвч тус судалгааны хүрээнд цалин хөлсийг бүрэн төлөхгүй байх, хэсэгчлэн төлөх, хууль бус гэрээ байгуулах, ажлаас үндэслэлгүй халах зэргээр албан бус ажил эрхлэгчдийг мөлжиж буй байдлыг салбар тус бүрээр судлан дүн шинжилгээ хийсэн байна. Улаанбаатар хотод амьдарч буй албан бус ажил хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй иргэдийн дунд зохион байгуулсан фокус бүлгийн хэлэлцүүлгүүдийн үр дүнгээс үзэхэд оролцогчдын олонх нь “ажил олгогч нар залуу бөгөөд гадаад ажиллах хүчнийг илүүд үзэх өрөөсгөл хандлага, болон хөдөлмөрийн мөлжлөгийн аргууд, мөн кронизм болон авлигын асуудал өргөн дэлгэрсэн байдлыг ажилгүйдлийн гол шалтгаан буюу ажилтай болоход тулгардаг гол бэрхшээл гэж санал нэгдсэн нь сонирхолтой юм” гэж дүгнэжээ (Singh 2017, 29).

Монголд барилгын салбарт албан бус ажил үйлчилгээ үзүүлдэг жижиг дунд бизнес эрхлэгчид буюу “Бригад” гэсэн ойлголт байдаг. Барилгын салбарт ажилладаг хувь хүмүүс нэгдэн бригад байгуулж ажилладаг боловч тэдний ихэнх нь албан бус байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд энэ нь тэднийг албан хөдөлмөр эрхлэгчидтэй харьцуулахад хөдөлмөрийн мөлжлөгтэй илүү тулгарах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Ихэнх тохиолдолд бригадууд нь барилгын компанитай албан гэрээ байгуулж ажилладаггүй нь мөнгөө цагт нь авч чадахгүй, эсвэл бүр огт авахгүй байх зэрэг нөхцөл байдал үүсгэж байдаг. Үүний шалтгаан нь ажлын гүйцэтгэлийн хангалтгүй байдал болон захиалагчтай албан бус гэрээ хийдэггүйтэй холбоотой юм. Бригадууд нь ихэнх тохиолдолд хуулийн этгээд, эсвэл албан байгууллагын бүртгэлгүй байдаг бөгөөд орлогын албан татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, ослоос сэргийлэх даатгал зэргийг төлдөггүй байна. Ихэвчлэн харьцангуй жижиг хэмжээний, бага санхүүжилттэй барилгын төслүүд бригадуудыг авч ажиллуулах сонирхолтой байдаг бөгөөд томоохон барилгын төслүүд албан бус бригадуудыг авч ажиллуулах нь ховор байдаг байна.

Гэрээлэгчийн үүрэг, хариуцлага. Гэрээлэгч барилгын ажилчид, бригадуудтай ажиллахдаа ажилчдын хөдөлмөрийг мөлжихөөс сэргийлж, дараах түгээмэл зөрчлийг анхаарч бүх ажилчид, бригадуудад ажил эхлэхээс өмнө сургалт, танилцуулга хийсэн байх шаардлагатай. Үүнд:

- Албан ёсны гэрээ, хөдөлмөрийн гэрээгүй ажиллах;
- Албан ёсны бүртгэл, гэрчилгээгүй бригадууд ажиллах;
- Барилгын ажил, бригадад эмэгтэйчүүд ажиллах бололцоог хязгаарлах;
- Гүйцэтгэлийн чанар шалгах, цаг баримтлах, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлыг анхаарахгүй байх зэргээр ажлын зохион байгуулалт муу байх;
- Ажлын зохион байгуулалттай холбоотой бодлого журам хангалтгүй байх;

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хөдөлмөрлөх эрхийнхээ талаар сайн мэдэхгүй байх.

2. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Ерөнхий мэдээлэл. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нь хүний эрхийн зөрчил бөгөөд үүний гол шалтгаан нь ядуурал байдаг. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн дунд сургуулиас завсардах эрсдэл бусадтай харьцуулахад өндөр байдаг бөгөөд боловсролын түвшин доогуур байдаг. Түүнчлэн, хүүхдүүдийн дундаж цалин харьцангуй бага байдгаас гадна хөдөлмөрийн мөлжлөг, хууль бус хөдөлмөр эрхлэлт, шударга бус цалин хөлс, хортой хүнд нөхцөлд ажиллах болон уртасгасан цагаар ажиллах зэрэг эрсдэлд өртөмтгий байдаг байна.

Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуульд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүүхдүүдийг барилгын салбар болон бусад хортой, хүнд нөхцөлд ажиллахаас урьдчилан сэргийлнэ хэмээн тусгасан байдаг. 18 нас хүрээгүй хүүхэд барилгын салбарт ажиллах ёсгүй боловч барилга дээр хүүхэд хөдөлмөр эрхлэх нь түгээмэл байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын 2016 оны Ажиллах хүчний судалгаанаас үзэхэд Монгол Улсын 5-17 насны нийт хүүхдүүдийн 10% буюу 56,000 гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлдэг бөгөөд эдгээр хүүхдүүд ихэвчлэн хөдөө аж ахуй, барилга, уул уурхайн салбарт хөдөлмөр эрхэлдгээс гадна морь унах байдлаар хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд олон байна.

Компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, үйл ажиллагааний нөлөөлөлд өртөж буй орон нутагт хүүхдийн хөдөлмөр эрхлэх эрсдэл өндөр байна. Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагааны БОННУ-ний үеэр авсан өрхийн судалгааны үр дүнгээс үзэхэд, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьдарч буй 49 өрхөөс 41 нь нэмэлт орлого олох зорилгоор хүүхдээ хөдөлмөр эрхлүүлж байсан нь тогтоогдсон юм. Түүнчлэн, барилга угсралтын хугацаанд нөлөөлөлд өртөж буй орон нутгийн хүүхдүүдийн аюулгүй байдлын талаар санаа зовж байгаагаа иргэд мэдэгдэж байв. Төслийн нөлөөлөлд өртөж буй орон нутагт ядуурал өндөр байгаатай холбогдуулан өрхүүд нэмэлт орлого олох зорилгоор хүүхдүүдээ барилга дээр ажиллуулах эрсдэл өндөр байна. Үүнээс гадна, барилгын компаниуд өртөг бууруулах үүднээс хүүхдүүдийг авч ажиллуулах эрсдэл байж болзошгүй юм.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн агентлаг (ГБХЗХА)-ийн дэргэдэх Хүүхэд хамгаалал, хөгжлийн төв нь улсын хэмжээний эмзэг бүлгийн хүүхдэд шаардлагатай нийгмийн халамжийн талаарх мэдээллийн сантай бөгөөд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн эрхийн зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авдаг Хүүхдийн тусламжийн “108” дугаартай утсыг 24 цагаар ажиллуулж байна. Мөн тус төвд хүүхдүүд 24-168 цаг хүртэл байрлах боломжтой түр хугацааны хорогдох байр байдгаас гадна 6 сар хүртэл амьдрах боломжтой хүүхдийн хорогдох байр байдаг байна. Ихэвчлэн хүчээр машин угаалгын газар ажиллуулах, замын хажуугаар бараа зарах, барилга дээр ажиллах, гуйлга гуйлга гэх зэрэг хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх явдал Монгол Улсад гардаг.

Гэрээлэгчийн үүрэг, хариуцлага. Монголын МСС болон Гэрээлэгч компаниуд хооронд байгуулах бүх гэрээнд насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөрийг хориглох, Гэрээлэгч нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, түүнийгээ хэрэгжүүлэх заалт тусгасан байдаг. Монголын МСС болон ХМЗ-ийн зүгээс тус шаардлагыг Гэрээлэгч хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар тогтмол хяналт тавих бөгөөд зарим тохиолдолд ажилчдын биеийн байцаалтыг шалгах юм. Тиймээс хэдийгээр эрсдэл өндөр боловч нөлөөлөл нь харьцангуй бага байх юм. Тухайн

эрсдэлийг бууруулах үүднээс Гэрээлэгч нь гэрээний зүйл заалтыг чанд мөрдөх шаардлагатай юм. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй тэмцэх зорилгоор гэрээлэгч нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- 18-аас доош насны хүүхэд ажиллуулахгүй байх;
- Гэрээлэгч нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хянаж, илрүүлэхийн тулд ханган нийлүүлэгчээ тогтмол хянах;
- Хүүхдэд хөдөлмөр эрхлүүлсэн тохиолдол илэрвэл Хөдөлмөрийн Менежментийн Төлөвлөгөөнд тусгасны дагуу арга хэмжээг авах;
- Гэрээлэгч нь Монголын МСС, Хөтөлбөрийн менежментийн зөвлөх багт бүх ажилчдын ажилласан цаг, ажилчдын цалингийн мэдээллийг албан тушаал, нас, хүйсээр ялган олгосон бүртгэл зэргийг сар бүр гаргаж өгөх;
- Ажилчдын бүртгэлээр хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хянах;
- Төсөл хэрэгжих орон нутгийн иргэдэд хүүхдийн хөдөлмөрийг хориглосон бодлогыг таниулах.

3. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Ерөнхий мэдээлэл. Монгол Улсад бэлгийн мөлжлөг, хүчээр хөдөлмөр эрхлүүлэхээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хүлээн авсан, гаргасан аль аль тохиолдол тогтмол гардаг. Монгол Улсад бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын ихэнх нь хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу бэлгийн мөлжлөгийн хохирогч болон орж ирсэн байдаг байна. АНУ-ын 2020 оны хүн худалдаалах гэмт хэргийн талаарх тайлангаар Монгол Улсыг 2 дугаар түвшинд ангилсан байна. Үүгээр Монгол Улс хүн худалдаалах гэмт хэргийг бүрэн устгасан байх наад захын жишигт хараахан хүрээгүй, энэ талаар ажиллах шаардлагатай болохыг харуулж байна.

2017 онд Засгийн газраас урьдчилан сэргийлэлт, хамгааллын арга хэмжээгээ сайжруулах зорилгоор “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” (2017-2021) болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний дэд зөвлөлийн удирдлага дор хэрэгжүүлж буй юм. Уг хөтөлбөр нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд байгууллага хоорондын уялдаа зохицуулалтаар хангах зорилготой юм. Түүнчлэн, ХНХЯ-ны харьяа ГБХЗХА 2018 оноос эрсдэлд өртөж болзошгүй хүн амын мэдээллийн санг байгуулсан бөгөөд энэхүү мэдээллийг санг олон улсын байгууллагуудтай хамтран салбар дундын ажлыг хэсгүүдийг байгуулах замаар хот, дүүргийн хэмжээний эрсдэлд өртөөд буй хүүхдүүдийн эрхийг хамгаалах зорилгоор ашиглаж байна. Мөн Засгийн газраас хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг хүлээн авдаг тусламжийн утасны системийг ажиллуулах зорилгоор Төрийн бус байгууллага (ТББ)-уудад 20 сая төгрөг (7,320 ам.доллар)-ийн санхүүжилт үзүүлсэн байна.

МСК нь хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах болон хянах тал дээр түнш орнуудтайгаа хамтран ажилладаг. МСК-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх (ХХГХТ) бодлого нь Компакт гэрээний аливаа үйл ажиллагаанд хүн худалдаалах гэмт хэргийг үл тэвчих үзэл санааг агуулсан байдаг¹. Үүнд барилгын талбай дээрх хүн худалдаалахтай холбоотой үйл ажиллагаанаас гадна барилга дээр ажиллаж буй ажилчид болон орон нутгийн иргэд хоорондын хүн худалдаалахтай холбоотой бүхий л үйлдлүүд багтана. МСК хүн худалдаалах гэмт хэргийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

¹ Хавсрал I, А Бүлэг

- 1) Хүч хэрэглэх, залилах, дарамтлах замаар насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлэхээр бэлгийн мөлжлөг хийх;
- 2) Хүч хэрэглэх, залилах, дарамтлах замаар хүнийг ажилд оруулах, тээвэрлэх, ажиллахаас аргагүй байдалд хүргэж ажиллуулах, үйлчлүүлэх бөгөөд хохирогч нь нэг газраас нөгөө газар руу заавал зөөвөрлөгдсөн байх албагүй.

МСК-ын ХХГХТ үзэл баримтлалыг Монголын МСС-гийн бүхий л гэрээнд тусгасан байдаг. Монголын МСС-тай байгуулж буй бүх гэрээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон нь тогтоогдсон тохиолдолд нөлөөллийг бууруулах зорилгоор нөхөн олговор олгоно гэж заасан байдаг. Үүнд: *“Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн нь тогтоогдсон хохирогч, Гэрээлэгчийн хүн худалдаалахтай холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тогтоогдсон хэрэг, эсвэл хуулийн дагуу хохирогч болсон нь тогтоогдсон бол Гэрээлэгч нь Монголын МСС-гийн хяналт дор шаардлагатай санхүүгийн болон бусад тусламжийг хохирогчид олгоно.”*

Гэрээлэгчийн үүрэг, хариуцлага. Хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс Гэрээлэгчид тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд эдгээрийг БОНМТ-нд дэлгэрэнгүй тусгасан байна. Үүнд дараах ерөнхий үйл ажиллагаа багтана.

1. Хүн худалдаалахтай холбоотой гэмт хэрэг гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой тусгасан хүн худалдаалахын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;
2. Хүн худалдаалахын эсрэг бодлогын талаар ажилчдад хагас жил тутам зааварчилгаа, танилцуулга, сургалт зохион байгуулж, МСК-ын хүн худалдаалахын эсрэг бодлогыг тогтмол сануулж байх;
3. Монголын МСС-гаас зохион байгуулах ХХ-ын эсрэг бодлогын талаарх уулзалт, сургалт, хэлэлцүүлэг бүрд хоёроос доошгүй ажилтныг хамруулж байх;
4. Хүн худалдаалахаас сэргийлэх арга хэмжээг барилгын талбарт сайтар авч хэрэгжүүлж, хүн худалдаалахын эсрэг шаардлагын хэрэгжилтийг хянах;
5. Хүн худалдаалахын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдээллийг олон нийтэд болон хороо, дүүргийн ЗДТГ-д танилцуулах;
6. Барилгын талбарын ажил эхлэхээс өмнө бүх ажилчдад МСК-ын ХХГХТ бодлого болон Гэрээлэгчийн Хүн худалдаалахын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах;
7. МСК-ын ХХГХТ бодлого болон хүн худалдаалахтай тэмцэх талаар ажилчдад өгөх сургалтын материалыг ажил эхлэхээс өмнө Барилгын хяналтын инженерээр батлуулах;
8. Дээрх сургалтыг ажилтан бүрд ажилд орсноос хойш нэг сарын дотор бүрэн өгөх;
9. Ажилчид ХХГХТ сургалтад хамрагдаж буйг хянах, тайлагнах (Хавсралт I-ээс дэлгэрэнгүй харна уу.);
10. Барилгын хяналтын инженер, эсвэл Монголын МСС-гаас хүссэн тохиолдолд Гэрээлэгчийн Хүн худалдаалахын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөг таниулах зорилгоор оролцогч талуудын төлөөллийг ХХГХТ сургалтад хамруулах;
11. Барилгын талбар дээр хүн худалдаалах гэмт хэргээс сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ХХГХТ бодлогын хэрэгжилтийг хянах, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээ авах;
12. Орон нутгийн иргэд болон ажилчид болзошгүй хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлдэг болох тогтолцоог боловсруулах. Энэ нь Гомдол шалгах тогтолцооноос тусдаа байх бөгөөд үүгээр дамжуулан барилгын талбар, эсвэл

орон нутагт бий болсон хүн худалдаалах гэмт хэргийн талаар Монголын МСС болон Барилгын хяналтын инженерт мэдэгдэх боломжийг бүрдүүлсэн байх;

13. Үндэсний хэмжээнд болон орон нутагт хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдох чиглэлээр ажилладаг байгууллагуудын жагсаалтыг ажилчдад өгөх;
14. ХХГХТ сургалтын материал боловсруулах болон бусад чиглэлээр салбарын мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтрах.

Бүлэг IX-т тус чиглэлээр хамтрах боломжтой байгууллагуудын мэдээллийг оруулав.

4. БЭЛГИЙН ДАРАМТ

Ерөнхий мэдээлэл. Бэлгийн дарамт гэдэг нь бэлгийн сэдлээр үг хэл болон биеэр үйлдсэн таагүй үйлдэл, хүчирхийллийг хэлэх бөгөөд ихэвчлэн бэлгийн болон бие махбодын хүчирхийллийн өмнөх үе шат юм. Бэлгийн болон бусад төрлийн дарамт нь хүний эрхийн зөрчлийн нэг хэлбэр бөгөөд ихэвчлэн эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүдэд чиглэсэн байдаг. Гэвч зарим тохиолдолд эрэгтэйчүүд янз бүрийн бэлгийн чиг хандлагын улмаас хүчирхийлэл, бэлгийн дарамтын хохирогч болдог нь мөн адил МСК-ын дүрэм журам, зааварт харшлах юм.

Хуульд эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийг эдгээр дарамтаас ижил хамгаалахаар заасан байдаг боловч эцгийн эрхт ёс болон хүйсийн тэгш бус байдал Монголд түгээмэл байсаар байна. Эдгээр нийгэм, соёлын нөлөөлөл нь Монгол Улсын хууль, тогтоомж болон МСК-ын бодлогод нийцэхгүй тул төсөл, үйл ажиллагааны төлөвлөлтийн үе шатанд тусгагдсан байх шаардлагатай. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.4 дүгээр зүйлд ажлын байранд бэлгийн дарамт гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг хөдөлмөрийн дотоод журамд тусгах, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгахыг ажил олгогчид даалгасан байдаг. Мөн хуулиар ажил олгогч нь бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг нээлттэй мэдээлэх хариуцлага хүлээнэ. Бэлгийн дарамттай холбогдох зүйл заалтууд Гэр бүлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Боловсролын тухай багц хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Зөрчлийн тухай хуулиудад тус тус тусгагдсан.

Гэрээлэгчийн үүрэг, хариуцлага. МСК-ын гэрээний ерөнхий заалтад “Бэлгийн дарамтыг хориглох болон үл тэвчих” заалт орсон байдаг бөгөөд хариу арга хэмжээ авах болон мэдээлэхтэй холбоотой төлөвлөгөө боловсруулах талаар багтсан байдаг². Гэрээлэгчид тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд эдгээрийг БОНМТ-нд дэлгэрэнгүй тусгасан байна. Үүнд дараах ерөнхий үйл ажиллагаа багтана.

1. Гэрээлэгч бэлгийн дарамтыг хориглох, зөрчлийг мэдээлэх, шалгах тухай бодлогыг ажил эхлэхийн өмнө боловсруулах бөгөөд тус төлөвлөгөө нь Монголын МСС болон МСК-ын стандарт, шаардлагад нийцсэн байх;
2. Бэлгийн дарамт, хүчирхийллийн талаар ажилчдад мэдээлэх шаардлагыг тусгасан Гомдол шалгах толголцоог хэрэгжүүлэх;
3. Бүх ажилтны хөдөлмөрийн гэрээнд 1) аюулгүй, харилцан хүндэтгэлтэй, дарамт шахалтгүй ажиллах орчныг бий болгоход чиглэсэн Гэрээлэгчийн бэлгийн хүчирхийллийн эсрэг бодлого, 2) ажилчдыг бэлгийн болон бие махбодын дарамт

² Хавсралт I, В Бүлэг

үзүүлэхийг хориглосон тухай тусгайлан тусгах. Гэрээлэгч ажилчдад бэлгийн дарамтыг үл тэвчих талаар мэдэгдэхээс гадна хэрэв бэлгийн дарамт үзүүлсэн нь батлагдсан тохиолдолд хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах талаар анхааруулах. Түүнчлэн, Гэрээлэгч компани нь бэлгийн дарамтыг мэдээлэх болон хянан шийдвэрлэх тогтолцоог ажилчдад танилцуулах;

4. Бүх ажилтан, гэрээлэгч нарыг Ёс зүйн дүрэмд гарын үсэг зуруулж, мөрдүүлэх;
5. Бэлгийн дарамт, хэргийг мэдээлэх талаар сургалтад бүх ажилтныг хамруулах. Түүнчлэн, гэрээлэгч нь сургалтын материал болон сургалтын бүтцийг Монголын МСС болон ХМЗ-өөр урьдчилан хянуулж, батлуулах шаардлагатай. Сургалтын материалын стандартын талаар Хавсралт I-т багтаав;
6. Монголын МСС-гаас зохион байгуулж буй бэлгийн дарамтын талаарх уулзалт, сургалт, хэлэлцүүлэг бүрд оролцох хоёроос доошгүй хүнийг томилох;
7. Барилгын талбарт бэлгийн дарамтаас сэргийлэх бодлогоо хэрэгжүүлэх, зөрчил гарвал даруй засах арга хэмжээ авах, мэдээлэх;
8. Бэлгийн дарамтын эсрэг бодлого, Зөрчил мэдээлэх, шалгах төлөвлөгөөний талаар олон нийттэй хийх бүх уулзалтаар мэдээлж, хороо, дүүргийн ЗДТГ-д танилцуулах;
9. Дарамт болон доромжлолтой холбоотой сургалтын төлөвлөгөөг гарган ажилчдыг тогтмол хамруулах. Сургалтын чанарыг хангах үүднээс сургалтуудыг УБ хотод байх тус чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж болно;
10. Бэлгийн хүчирхийлэл, дарамттай тэмцэх төлөвлөгөө болон төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах тогтолцоог боловсруулж, ажилчдад танилцуулах. Хавсралт I-ээс хяналтын стандартыг харна уу;
11. Нэгээс доошгүй бэлгийн дарамтын эсрэг сургалтад оролцогч талуудын төлөөлөл болон холбогдох Монголын МСС-гийн ажилчдыг урьж оролцуулах бөгөөд үүгээр дамжуулан оролцогч талууд Гэрээлэгчийн бэлгийн дарамттай тэмцэх бодлогын талаар мэдээлэл авахаас гадна ажилчдад хэрхэн танилцуулж байгаа талаар ойлгох юм;
12. Үндэсний хэмжээнд болон орон нутагт бэлгийн дарамтын гэмт хэрэгтэй холбогдох чиглэлээр ажилладаг байгууллагуудын жагсаалтыг ажилчдад өгөх;

Бүлэг IX-т тус чиглэлээр хамтрах боломжтой байгууллагуудын мэдээллийг оруулав.

5. НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ХМЗ-ИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Тус НЖНТ болон дэд бүтцийн төслүүдийн БОННУ, БОНМТ-нд туссан нийгэм, жендэрийн эрсдэлийг бууруулах зорилгоор ХМЗ нь 1) Гэрээлэгчийн БОНМТ-ны хэрэгжилтийг хянах, 2) бэлгийн дарамт, жендэрт суурилсан хүчирхийлэл гэх зэрэгтэй холбоотой Гэрээлэгчийн Гомдол шалгах тогтолцооны хэрэгжилтийг хянах, 3) хүн худалдаалах гэмт хэрэг болон хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гомдлуудыг хэрхэн шийдвэрлэж буй талаар хянах үүрэгтэй. ХМЗ нь жендэр, нийгмийн оролцоотой холбоотой дараах ерөнхий үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- Бүх гэрээлэгчээс бэлгийн дарамт, хүчирхийллийг мэдээлэх тухай тусгасан байгууллагын гомдол шалгах тогтолцоо байгуулахыг шаардах, хянах;
- Бүх ажилтан дарамт хүчирхийллийг онцгойлон хориглосон, хариуцлага хүлээлгэх тухай тусгасан ёс зүйн дүрэмд гарын үсэг зурсан байхыг шаардаж, баталгаажуулах;

- Сургалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх хуваарьт дарамт, хүчирхийллийн талаар сургалтыг тусгуулж ойлголтыг тогтмол нэмэгдүүлж буйг хянах;
- Бэлгийн дарамт, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой аливаа зөрчилтэй холбоотой Гэрээлэгчийн гомдол шалгах тогтолцоо хэрэгжүүлэхэд оролцож, үйл явц үр дүнг хянаж баримтжуулан мэдээлсэн, хохирсон, гэрчилсэн хүмүүсийн нууцлалыг хадгалахад анхаарах;
- Гэрээлэгчид нь бүх ажилчдын хөдөлмөрийн гэрээнд дарамт, хүчирхийлэлтэй холбоотой ёс зүйн хэм хэмжээг тусган, эдгээрийг үл тэвчих бодлогыг багтааж, зөрчсөн тохиолдол хөдөлмөрийн гэрээг цуцлах заалтыг оруулсан эсэхийг баталгаажуулах;
- Гэрээлэгч нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хүүхдийн хөдөлмөр, бэлгийн дарамт болон доромжлолтой холбоотой сургалтын төлөвлөгөөг гарган ажилчдыг тогтмол хамруулж буй эсэхэд хяналт тавих. Сургалтын чанарыг хангах үүднээс сургалтуудыг УБ хотод байх тус чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж болно. Зарим мэргэжлийн байгууллагуудын жагсаалтыг Хавсралт II-т оруулав.
- Гэрээлэгчийн Гомдол шалгах тогтолцооны хэрэгжилт болон бэлгийн дарамт, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой гомдлыг хэрхэн баримтжуулан шийдвэрлэж буйг болон хохирогчдын мэдээллийг хэрхэн хамгаалж байгаад хяналт тавих.
- Гэрээлэгч нь МСК-ын ХХГХТ бодлого болон холбогдох шаардлагыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих. Хэрэв хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой асуудал, эсвэл гомдол гарсан тохиолдолд Монголын МСС-нд 24 цагийн дотор мэдэгдэх.

Монголын МСС болон ХМЗ хамтран дараах төлөвлөгөөнүүдийг боловсруулахыг Гэрээлэгчээс шаардаж, хяналт тавих үүрэгтэй. ХМЗ нь дараах төлөвлөгөөнүүдийн хяналтыг тогтмол шалгах бөгөөд шаардлагатай тохиолдолд Монголын МСС-гаас давхар хяналт тавина. Үүнд:

- Гэрээлэгчийн хүн худалдаалахын эсрэг хариу арга хэмжээ авах төлөвлөгөө;
- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой шаардлагыг хэрэгжүүлэх байдал;
- Бэлгийн дарамтын эсрэг бодлого, зөрчлийг мэдээлэх, шалгах төлөвлөгөө.

Бэлгийн дарамт болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой гомдол гарсан тохиолдолд тухайн гомдлыг хянах болон шийдвэрлэх үйл ажиллагаанд Хүйсийн тэгш эрхийн төв, МХЕГ, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг гуравдагч мэргэжлийн байгууллагын оролцоог хангаж буйд хяналт тавих үүрэгтэй. Дээр дурдсан зөрчил илэрсэн тохиолдолд ХМЗ болон Монголын МСС нь БОНМТ-ний дагуу гомдол хүлээн авч шалгах механизмыг хэрэгжүүлэхээр тус бүр нэг гишүүнийг томилно. Түүнчлэн, хэрэв хүн худалдаалах гэмт хэрэг, эсвэл хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд эдгээр асуудлыг Монгол Улсын холбогдох хууль болон МСК-ын ХХГХТ бодлогын дагуу хянан, шийдвэрлэж буйд ХМЗ хяналт тавих үүрэгтэй.

V. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСЛИЙН НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ

Тус бүлэгт Компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлж буй Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөлтэй холбоотой нийгмийн боломж, болзошгүй нөлөөлөл,

тодорхойлсон эрсдэлүүдийг багтаасан болно. Төслийн хүрээнд нийгмийн тогтвортой байдалтай холбоотой эрсдэлүүдээс зайлсхийх, усны салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн ангилал тус бүрд боловсруулсан төлбөр төлөх эрмэлзэл, чадвар дээр тулгуурлан усны салбарын үнэ, тарифтай холбоотой нийгмийн тэгш байдлыг хангах, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (ХСУХАТАУЗЗ)-д техникийн туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагаанууд багтсанаас гадна цэвэр болон бохир усны тарифын бүтцийг тодорхойлсон Зардал нөхөх төлөвлөгөө (ЗНТ)-г боловсруулах үйл ажиллагаа багтана. Түүнчлэн, төслийн хүрээнд УСУГ-ын зарим ус түгээх байрыг ухаалаг картаар ажилладаг технологид шилжүүлэх, УСУГ, УБ хотын төрийн байгууллагууд, дүүргийн төрийн байгууллагуудын чадамжийг сайжруулж, гэр хорооллын ус түгээх үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор дэд бүтэцтэй холбоотой төлөвлөлт, харилцан мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн техникийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм. Мөн УСУГ-т үзүүлэх техникийн туслалцааны хүрээнд хэрэглэгчдийн мэдээллийн сан байгуулах болон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажил багтсанаас гадна усны нөөцийн талаар УБ хотын иргэдэд таниулах, оролцогч талуудтай зөвшилцөхөд УСУГ болон ХСУХАТАУЗЗ-д туслалцаа үзүүлэх ажлууд багтаж байна.

Тус НЖНТ-ний Хувилбар 2.0-ыг боловсруулах хугацаанд, Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн зөвхөн Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагааны ажлын даалгаврыг бүрэн боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байв.

Төслийн бусад дэд үйл ажиллагаа судалгааны болон боловсруулалтын үе шатанд байгаа бөгөөд ажлын даалгаврыг эцэслэх, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах ажил, хэрэгжилт хараахан эхлээгүй байна. Иймд, тус НЖНТ 2.0 нь одоогоор тодорхойлсон урьдчилсан ажлын даалгавар, үйл ажиллагааны төлөвлөгөөнд суурилан нийгэм, жендэрийн дүн шинжилгээг боловсруулсан болно. Тус бүлэг нь НЖНТ-г шинэчлэн боловсруулах үед шинэчлэгдэх бөгөөд Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн үйл ажиллагаануудтай холбоотой нэмэлт нийгэм, жендэрийн дүн шинжилгээг багтаах юм.

А. ЗАРДАЛ НӨХӨХӨД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ерөнхий мэдээлэл. 2020 онд Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн юм. Алсын хараа 2050 бодлогын хүрээнд нийт хүн амын 90%-ийг ундны цэвэр, аюулгүй усаар хангах зорилт багтсан юм. Тус зорилтод хүрэхийн тулд нийт хүн амын тал хувь нь оршин суудаг Улаанбаатар хотын ус хангамж, бохир ус зайлуулах дэд бүтцийг өргөтгөж, сайжруулахад их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай юм. УБ хотын ундны усны эрэлтийг хангахад чиглэсэн эдгээр дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дагаад ашиглалт, үйлчилгээний зардал, элэгдэл, хорогдлын өртөг, нэмэлт ажиллах хүчний зардал, олон улсын хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт зэрэг нэмэлт зардлууд нь УСУГ болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ)-ын санхүүгийн зарцуулалтыг нэмэгдүүлэх юм.

Зардал нөхөх төлөвлөгөө. Өнөөгийн байдлаар УСУГ нь усны тарифаас олох орлогоороо өөрийн зардлаа бүрэн нөхөж чадахгүй байгаа бөгөөд энэ нь УБ хотын усны салбарын урт хугацааны санхүүгийн тогтвортой байдал, үйл ажиллагаанд эрсдэл үүсгэж байна. Иймд, 2020 оны 11 дүгээр сард Компакт гэрээний урьдчилсан болзолт нөхцөлүүдийн нэг болох Зардал нөхөх төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар,

НЗДТГ болон ХСУХАТАҮЗЗ-өөр баталсан юм. УСУГ нь гэр хорооллын болон бусад хэрэглэгчдэд цэвэр ус түгээх болон бохир ус татан зайлуулахтай холбоотой ашиглалт, үйлчилгээний зардал, элэгдэл, хорогдлын өртгийг усны тарифын орлогоос бүрэн нөхдөг болоход Зардал нөхөх төлөвлөгөөний гол зорилго оршино.

Батлагдсан ЗНТ нь УСУГ-ын зардлыг бүрэн нөхөхүйц тарифын өсөлтийн хувилбаруудыг багтаасан болно. Гэвч ЗНТ-нд багтсан тарифын өсөлтийн хувилбарууд нь УБ хотын хэрэглэгчид, тэр дундаа бага орлоготой иргэдэд усны тарифын өсөлт хэрхэн нөлөөлөх талаар дүн шинжилгээ байхгүй юм. Энэ асуудлыг шийдэхийн тулд Монголын МСС-гаас тарифын өсөлттэй холбоотой хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзэл болон бусад санхүүгийн, нийгмийн, төлбөр төлөх чадамжтай холбоотой цогц судалгааг хийх Зардал нөхөх техникийн туслалцаа (ЗНТТ)-г хэрэгжүүлж байна. Тус ЗНТТ нь хоёр үндсэн зорилготой бөгөөд тус үйл ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэх гурван судалгааны үр дүнд тулгуурлан татаасын, эсвэл хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийг тодорхойлох, тус татаасын, эсвэл хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бий болгох юм.

Зардал нөхөх техникийн туслалцаа. ХСУХАТАҮЗЗ болон төрийн шийдвэр гарагчдад ЗНТ-г шинэчлэн боловсруулахад шаардлагатай нийгэм болон санхүүгийн холбогдолтой мэдээллийг хүргэх зорилгоор, харилцан уялдаа холбоо бүхий гурван цогц судалгааг зөвлөх үйлчилгээний гэрээ болон Үндэсний статистикийн хороо, ХСУХАТАҮЗЗ-тэй хамтран хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Төлбөр төлөх эрмэлзэл (ТТЭ)-ийн судалгаа нь зардал бүрэн нөхөхүйц тарифын өсөлтийн хувилбарыг боловсруулах болон үүнийг хэрэглэгчдийн төлбөрийн чадамжтай уялдуулахад шаардлагатай тоон болон чанарын судалгааны мэдээллийг Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-той хамтран цуглуулах.
2. Хэрэглэгчдийн төлбөрийн чадвар, Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр боловсруулах судалгаа нь төрийн шийдвэр гарагчид, тэр дундаа ХСУХАТАҮЗЗ-д хэрэглэгчдийн төлбөрийн чадвартай холбоотой асуудлуудыг шийдэх хамгийн өртөг багатай хувилбарыг зардал нөхөх тарифын өсөлтөд багтаахад шийдвэр гарагчдыг шаардлагатай мэдээллээр хангах зорилготой юм. Үүний тулд усны тарифын өсөлтөөс санхүүгийн хувьд хамгийн их нөлөөлөлд өртөж болох хэрэглэгчдийн бүлгийг тодорхойлж, бага орлоготой ядуу өрхүүдэд чиглэсэн Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр боловсруулах юм.
3. Тарифын хувилбар боловсруулах судалгаа нь ЗНТ-тэй уялдуулан тарифын өсөлтийн хувилбаруудыг боловсруулан харьцуулан үнэлэх юм. Энэ нь ХСУХАТАҮЗЗ-д тарифын урт хугацааны тогтвортой бодлогыг боловсруулж оролцогч талуудын харилцан зөвшилцсөний үндсэн дээр Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм.

НЖО-той холбоотой асуудлууд болон дүн шинжилгээ. Усны үйлчилгээний хүртээмж, усны хэрэглээ, усны төлбөрийн чадамж зэрэг УБ хотын иргэдийн өдөр тутмын амьдралд чухал ач холбогдолтой устай холбоотой нийгмийн гурван төрлийн тэгш бус байдал байдаг.

Усны үйлчилгээний хүртээмж. УБ хотын иргэдийн дунд байгаа нийгмийн тэгш бус байдалтай холбогдох хамгийн том асуудал нь усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны иргэд буюу нийт хэрэглэгчдийн 42% болон нийт хэрэглэгчдийн 58%-ийг эзэлдэг УСУГ-ын ус түгээх байрууд, зарим жижиг хувийн худгууд, бусад

хамгаалагдсан, эсвэл хамгаалагдаагүй ундны усны эх үүсвэрээс усаа авдаг гэр хорооллын иргэд хоорондын ундны усны үйлчилгээний хүртээмжийн ялгаа юм. Усны үйлчилгээний хүртээмжийн хувьд хотын төвд төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон, эсвэл ихэвчлэн хотын захад шугамын болон зөөврийн ус түгээх байрнаас ус авдаг эсэхээс шалтгаалан үйлчилгээний хүртээмж эрс ялгаатай байна. 2020 оны Хүн амын тооллогоос үзэхэд, УБ хотын нийт иргэдийн тал хувь буюу 50.1% нь усны төвлөрсөн шугамд холбогдоогүй байна. Эдгээр иргэд зарим тохиолдолд нийтийн халуун ус, угаалгын газруудаар үйлчлүүлдэг бөгөөд ихэнх нь бохир ус зайлуулах асуудалтай тулгардаг байна. 2010 оны тоо мэдээллээр, УБ хотын нийт усны хэрэглээний дөнгөж 38.4%-ийг ахуйн усны хэрэглээ эзэлж байгаа бөгөөд үүний 95.6%-ийг орон сууцны иргэд, харин үлдсэн 4.4%-ийг гэр хорооллын иргэд хэрэглэдэг гэсэн судалгаа байна.

Төлбөрийн чадамж. Усны салбарт гадны шууд тарифын татаас болон Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрүүд өнөөдрийг хүртэл шаардлагагүй байсан нь усны тарифын хэмжээ үйлчилгээний өртгөөс бага байдагтай холбоотой юм. Монголын МСС, ҮСХ хамтран зохион байгуулсан ТТЭ-ийн судалгаанаас үзэхэд 2020 онд мөрдөж буй усны тарифын хэмжээ нь дунджаар өрхийн нийт зардлын 1.25% - 3.19%-тай тэнцэж буй нь ихэнх өрхийн хувьд боломжийн хэмжээнд байна гэж дүгнэжээ. Өнөөдрийн байдлаар гэр хорооллын иргэд ус түгээх байрнаас авч буй усны литр тутамд 1 төгрөг төлж байгаа бөгөөд одоогоор мөрдөж буй бодлогоор бол орон сууцны усны тарифын үнэ литр тутамд 1 төгрөгөөс их болоогүй тохиолдолд тус үнийг нэмэгдүүлэх боломжгүй юм. Харин төвлөрсөн шугамд холбогдсон орон сууцны иргэдийн хувьд УСУГ, ОСНААУГ, эсвэл хувийн контороор үйлчлүүлж байгаагаас үл хамааран хоёр төрлийн төлбөрийг төлж байгаа бөгөөд үүнд 3,000 төгрөгийг сарын суурь хураамжид, мөн тоолууртай хэрэглэгчид литр тутамд 0.71 төгрөг, тоолуургүй хэрэглэгчид литр тутамд 1.04 төгрөг төлж байна.

2021 оны ТТЭ-ийн судалгаанаас үзэхэд, УБ хотын иргэдийн 26.5% нь 2019 онд тогтоосон амьжиргааны баталгаажих түвшин болох нэг хүн сард 217,900 төгрөгөөс бага орлоготой амьдарч байна. Эдгээр өрхийн ихэнх хувь нь өрхийн гишүүдийн тоо олон, гурав буюу түүнээс дээш хүүхэдтэй, эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй, эсвэл зөвхөн нэг орлого олдог гишүүнтэй өрхүүд эзэлж байна. Харин зөвхөн өндөр настан амьдардаг, гэр бүлийн гишүүдийн олонх нь орлого олдог, өрхийн тэргүүлэгч нь бүрэн дундаас өндөр боловсролтой, эсвэл орон сууцанд амьдардаг өрхүүд ядуу байх магадлал бага байдаг байна.

Усны хэрэглээний түвшин. Урт хугацааны нөлөөллийг авч үзвэл ус ашиглалтын байгууллагуудын орлогыг нэмэгдүүлэх, хамгийн бага орлоготой өрхийн усны хүртээмжийг хангах хоёрын тэнцвэрт байдлыг хангах нь зардал нөхөх тарифын нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулж, ЗНТ-ний зорилтыг биелүүлэх боломжийг олгох юм. Нөгөөтэйгүүр, УСУГ-ын ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг нөхөх зорилгоор усны үнийг мэдэгдэхүйц нэмсэн тохиолдолд хамгийн эмзэг, ядуу өрхүүдийн санхүүгийн ачааллыг нэмэгдүүлж, өдөр тутмын усны хэрэглээгээ бууруулахад хүргэж болзошгүй юм.

2021 оны ТТЭ-ийн судалгааны үр дүнгээс үзэхэд усны тоолууртай хэрэглэгчдийн 57.3% нь нэг хүнд ногдох усны хэрэглээний түвшин буюу өдрийн 200 литрээс бага хэрэглээтэй байгаа бөгөөд харин гэр хорооллын хэрэглэгчдийн 95.3% нь өдрийн 50 литрээс бага хэрэглээтэй байгаа нь тогтоогдсон байна. Харин УБ хотын иргэдийн 41.5% нь амьдардаг

гэр хорооллын хэрэглэгчдийн дийлэнх хэсэг нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас тогтоосон гамшгийн үеийн түвшин буюу нэг хүний өдрийн 20 литрээс бага усны хэрэглээтэй байна. Хангалттай ус хэрэглэхгүй байгаа иргэдийн ихэнх буюу 98.3% нь гэр хорооллын иргэд байгаа бөгөөд энэ нь гэр хорооллын нийт хэрэглэгчдийн 74%-ийг эзэлж байна. Түүнчлэн нийт хэрэглэгчдийн ихэнх нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны А/333 тоот тушаалаар тогтоосон ундны усны түвшнөөс бага хэрэглээтэй байна.

Усны нөөцийн бүлэг 2030 байгууллагын тооцоолсноор, нэг өрхийн усны хэрэглээний эрэлт болон ахуйн усны хэрэглээний эрэлт хурдацтай нэмэгдэхээр байгаа нь 2021-2030 оны хоорондын хүн амын өсөлтөөс шууд хамааралтай юм. Гэвч гэр хорооллын хэрэглэгчдийн усны хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахгүй бол гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээний түвшин бага хэвээр байхаар байна.

Хэрэгжүүлэлтийн зохион байгуулалт. Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн оролцоог хангах асуудал хариуцсан баг Зардал нөхөхөд чиглэсэн дэд үйл ажиллагааг удирдан хэрэгжүүлж байна. ЗНТТ үйл ажиллагааг хэрэгжүүлж буй зөвлөх баг нь усны салбарын оролцогч талуудтай нягт хамтран ажиллах замаар судалгаануудыг боловсруулах бөгөөд судалгааны үр дүнд төлбөрийн чадамжтай холбоотой гол нийгмийн асуудлуудад дүн шинжилгээ хийх юм. Монголын МСС нь ХСУХАТАУЗЗ, УСУГ, ОСНААУГ, НЗДТГ, ХНХЯ зэрэг үндсэн оролцогч талуудаас бүрдсэн ажлын хэсгийг байгуулж, ЗНТТ-г хэрэгжүүлж буй зөвлөх багийн боловсруулсан тайлан, дүн шинжилгээ, үр дүнгийн талаар харилцан ойлголцох, хүлээн авах, санал хүсэлтийг шийдвэрлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ нь төрийн гол хамтрагч талуудыг зөвхөн тариф болон санхүүгийн тоон мэдээллээр хангаад зогсохгүй холбогдох нийгмийн асуудлуудын талаар хангалттай мэдээллээр хангахад чухал үүрэгтэй юм. Түүнчлэн усны тариф нэмэгдсэнтэй холбогдуулан орлого багатай, төлбөрийн чадамж багатай өрхүүдэд тулгарч болзошгүй нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлын талаарх мэдлэгийг орлогч талуудад хүргэхэд чухал ач холбогдолтой юм. Тус ажлын хүрээнд Монголын МСС болон ХСУХАТАУЗЗ 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээ байгуулсан. Хэрэгжүүлэгч байгууллагын хүлээсэн үүргийн дагуу ХСУХАТАУЗЗ нь оролцогч талуудтай хамтран ЗНТ-г боловсруулах болон батлах ажлыг зохион байгуулах юм. Түүнчлэн, ХСУХАТАУЗЗ нь ЗНТТ-ны судалгаануудын үр дүн болон нэмэлт мэдээлэлд тулгуурлан ЗНТ-г шинэчлэн боловсруулах үүрэгтэй.

Хүлээгдэж буй үр дүн. ЗНТТ-ны үр дүнд тулгуурлан, Монголын МСС нь Монгол Улсын Засгийн газрыг төлбөрийн чадамжтай холбоотой хууль, тогтоомж бодлогыг боловсруулан 2020 оны 11 дүгээр сард батлагдсан ЗНТ-д заасны дагуу “хэрэглэгчийн татаасын хувилбарыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бий болгох” хүлээлттэй байна. Хэрэглэгчдийн төлбөрийн чадамжийн тарифын хувилбар боловсруулахад авч үзэх болон Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийг бага орлоготой хэрэглэгчдэд зориулан хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бий болгох нь ЗНТТ-ны зорилго юм. Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн үр шим хүртэгчдийг тодорхойлох зохистой шалгуур үзүүлэлтийг боловсруулж санхүүгийн тусламж хэрэгтэй байгаа өрхүүдийг тодорхойлох нь гэр хорооллын иргэдэд бүхэлд нь чиглэсэн тогтолцооноос давуу талтай юм. Төлбөрийн чадамжид тулгуурласан усны үйлчилгээний төрийн бодлого нь ЗНТ-ний хэрэгжилтэд нөлөөлөх юм.

В. ГЭР ХОРООЛЛЫН УС ХАНГАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ ДЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ерөнхий мэдээлэл. УСУГ нь УБ хотын иргэдийн 50.1%, бага орлоготой иргэдийн дийлэнх хэсэг нь амьдардаг гэр хорооллын иргэдэд үйлчилгээ үзүүлдэг. Гэр хорооллын иргэдэд нийт 671 ус түгээх байраар дамжуулан ус нийлүүлж байгаа бөгөөд 2020 оны эцсийн дүнгээр эдгээр ус түгээх байрны 348-ыг нь том усны савтай ачааны машинаар, харин 323-ыг нь төвийн ус дамжуулах хоолойн системээр усаар хангаж байна. Гэр хорооллын хэрэглэгчдэд ус хүргэх машинуудын явах зайнаас хамаарч литр тутмыг нь 10-19.8 төгрөгийн өртгөөр нийлүүлдэг бол хэрэглэгчдэд литр тутмыг нь 1 төгрөгөөр худалддаг. Гэр хорооллын иргэдэд усны үйлчилгээг хүргэх зардал болон тарифын зөрүү нь УСУГ-ыг алдагдалд хүргэж байна. 2020 онд гэр хорооллын усны үйлчилгээний орлого 1.6 тэрбум төгрөг байсан бол нийт зардал 21.6 тэрбум төгрөг байсан нь УСУГ-ыг 20 орчим тэрбум төгрөгийн цэвэр алдагдалд оруулсан байна. Хэрэв энэ алдагдсан орлогыг бүрдүүлвэл энэ нь УСУГ жилийн нийт орлогын 31.6%-тай тэнцэнэ. Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээнээс үүсдэг алдагдлыг нөхөхийн тулд УСУГ хэрэглэгчдийн хөндлөн татаасын аргыг хэрэглэдэг. Орлогынхоо ихэнх хэсгийг гэр хорооллын үйлчилгээний алдагдалд хөндлөн татаасанд зарцуулснаар УСУГ нь ашиглалт, засвар үйлчилгээ, хөрөнгийн шинэчлэлт, өрийн үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх боломжгүй болж, улмаар санхүүгийн тогтворгүй байдал бий болж байна. Иймд Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагааг нарийвчлан боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тус дэд үйл ажиллагаа нь хоёр хэсэгтэй. Үүнд:

1. Гар ажиллагаатай ус түгээх байруудыг “ухаалаг” болгох буюу автомат ажиллагаатай болгон шинэчилснээр уртасгасан цагаар бага зардлаар ажиллах боломжтой юм;
2. Усны үйлчилгээг сайжруулахтай холбоотой дэд бүтцийг шинээр байгуулахад УСУГ, НЗДТГ болон дүүргийн төрийн байгууллагуудын хоорондын мэдээлэл солилцоо, төлөвлөлт, хамтын ажиллагааг сайжруулах.

УС ТҮГЭЭХ БАЙРУУДЫГ “УХААЛАГ” БОЛГОН ШИНЭЧЛЭХ

Гэр хорооллын ус түгээх байруудыг ухаалаг болгон шинэчлэх үйл ажиллагааны гол давуу тал нь ухаалаг ус түгээх байр нь уртасгасан цагаар, хүний оролцоо багатайгаар ажилладаг болох юм. Одоогоор гар ажиллагаатай ус түгээх байр 165 байгаа бөгөөд Улаанбаатар хотын 6 дүүргийн 6,593 өрхөд үйлчилж байна.

Ус түгээх байруудыг ухаалаг болгон шинэчлэх үйл ажиллагаа нь нийгэм, жендэрийн оролцоотой холбоотой хоёр үндсэн үр нөлөөтэй байна. Үүнд:

1. Ус түгээх байруудыг ухаалаг болгон шинэчилснээр УСУГ-ын зардал буурахаас гадна гэр хорооллын хэрэглэгчдийн усны үйлчилгээний түвшин болон хүртээмж нэмэгдэх юм;
2. Ус түгээх байруудыг ухаалаг болгон шинэчилснээр УСУГ нь ус түгээх байранд ажилладаг ус түгээгч нарт зарцуулдаг зардлыг бууруулах боловч эдгээр ус түгээгч нарийн ихэнх нь эмзэг бүлгийн эмэгтэйчүүд юм.

Усны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх. Гар ажиллагаатай ус түгээх байруудыг ухаалаг болгон шинэчилснээр ДЭМБ-аас зөвлөмж болгосон түвшнээс хавьгүй бага ус хэрэглэж байгаа гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд усны хүртээмжийг сайжруулах боломж бий болно. УСУГ-ын тооцооллоос үзэхэд долоо хоногийн бүх өдөр 24 цагийн ажиллагаатай болох нь ухаалаг ус түгээх байраар үйлчлүүлдэг хэрэглэгчдэд ажлын бус цагаар ус авах боломжийг олгох бөгөөд ердийн ус түгээх байраар

үйлчлүүлдэг хэрэглэгчидтэй харьцуулахад усны хэрэглээ нь өдөрт 1 литр орчмоор нэмэгдэх боломжийг бий болгох юм. Ердийн гар ажиллагаатай ус түгээх байр нь ихэвчлэн өглөөний 10 цагаас оройны 19 цаг хүртэл ажилладаг. Зарим ус түгээх байр амралтын өдрүүдэд хагас цагаар ажилладаг эсвэл ажилладаггүй. Ус түгээх байрны үйл ажиллагааны цагийг уртасгах нь айл өрх ундны усгүй болох эрсдэлийг бууруулдаг. ТТЭ-ийн судалгааны үр дүнгээс харахад гэр хорооллын хэрэглэгчдийн 28% нь ойролцоох ус түгээх байр хаасан тохиолдолд өөр худаг руу явдаг байна. Зарим хэрэглэгч энэ тохиолдолд хүнсний дэлгүүрээс савласан ус худалдан авдаг боловч ТТЭ-ийн судалгааны үр дүнгээс үзэхэд гэр хорооллын хэрэглэгчдийн дөнгөж 14.5% нь савласан ус хэрэглэдэг байна.

ТТЭ-ийн судалгааны гэр хорооллын хэрэглэгчдийн хүссэн усны үйлчилгээний сайжруулалтын дүн шинжилгээнээс үзэхэд, хэрэглэгчид ухаалаг ус түгээх байрны уртасгасан цаг болон төлбөр төлөх боломжийг өндрөөр үнэлсэн байна. Ухаалаг ус түгээх байрыг шинэчлэн бий болгох ажлын даалгаврыг боловсруулах зорилгоор УСУГ-ын техникийн ажлын хэсгийн боловсруулсан анхны тооцоогоор УБ хотын бүх зургаан дүүргийн 7000 орчим өрх ухаалаг ус түгээх байрнаас өгөөж хүртэх боломж үүсэх юм. ТТЭ-ийн судалгааны үр дүнгээс үзэхэд гэр хорооллын иргэдийн хамгийн ихээр хүсэж буй усны үйлчилгээний сайжруулалт нь ухаалаг худгуудыг шинээр бий болгох бөгөөд төлбөрийн урьдчилсан нөхцөл болон бэлэн мөнгөөр бус ухаалаг картаар төлбөр төлөх боломж нь хамгийн их үнэлэгдсэн байна. Гэвч ухаалаг худагтай холбоотой хамгийн том асуудал нь ухаалаг худаг тогтмол эвдэрдэг, бага даралттай ус шахдаг гэсэн гомдол байдаг байна. Ухаалаг худгуудыг шинэчлэн бий болгосноор УСУГ нь ус түгээгч нарыг гар ажиллагаатай ус түгээх байранд ажиллуулахтай холбоотой зардлыг хэмнэх юм.

Ус түгээгч нарын ажлын байртай холбоотой нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах. Ухаалаг ус түгээх байруудыг шинээр бий болгох ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсгийн мэдээлснээр одоогийн байдлаар 180 орчим ус түгээгч болон 28 дундын ус түгээгч ажиллаж байгаа бөгөөд тэд долоо хоногт хоёр өдөр амардаг байна. Ус түгээгчид одоогоор хэрэглэгчдэд үйлчлэхээс гадна ус түгээх байрны цэвэрлэгээ, засвар үйлчилгээг хариуцдаг байна. Ус түгээх байруудад ухаалаг системийг ажиллуулснаар ус түгээгчид зөвхөн ус түгээх байрыг цэвэрлэх, арчлах үүрэгтэй болох бөгөөд нэг түгээгч хэд хэдэн ус түгээх байрыг хянах боломжтой болох тул ажлын ачаалал буурна. Ус түгээх байруудыг ухаалаг болгон ус түгээгч нарын тоог бууруулснаар УСУГ зардлаа хэмнэх боломж үүсэх юм.

Ус түгээгчтэй гар ажиллагаатай ус түгээх байрыг ухаалаг ус түгээх байр болгон шинэчлэхтэй холбогдуулан цомхотголд орсон ус түгээгчдийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн оролцоог хангах баг УСУГ-ын Захиргаа, хүний нөөцийн хэлтэст ОУСК-ын Гүйцэтгэлийн стандартын дагуу Цомхотголын нөлөөллийг бууруулах төлөвлөгөө боловсруулахад техникийн туслалцаа үзүүлж байна. ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт 2 буюу Хөдөлмөр ба ажлын нөхцөл нь олон тооны ажлын байрыг цомхотгох төлөвтэй байгаа бол цомхотгол хийсний улмаас ажилчдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө боловсруулахыг шаарддаг. Энэхүү төлөвлөгөө нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд суурилсан байх бөгөөд УСУГ-ын ажилчид, тэднийг төлөөлөх байгууллага, шаардлагатай тохиолдолд төрийн байгууллагуудтай төлөвлөгөө боловсруулах явцад зөвшилцөн санал зөвлөмжийг нь тусгах ёстой юм.

Хэрэгжилтийг зохион байгуулах. Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн оролцоог хангах баг ус түгээгч нарын ажлын байрны өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхэд УСУГ-т дэмжлэг үзүүлэх үүрэгтэй бөгөөд нөлөөлөлд өртөж болзошгүй ус түгээгчид нь ихэвчлэн эмэгтэйчүүд байгаа тул эдийн засаг, нийгмийн сөрөг нөлөө бий болж болзошгүй юм. Монголын МСС-гийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах болон Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн багийнхан тус үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх юм. Энэхүү тендерийн худалдан авах ажиллагааны өмнөх үе шатанд Монголын МСС-гийн Усны салбарын тогтвортой байдлын хангах баг нь 2021 оны 1 дүгээр сараас эхлэн цахилгаан, механик, мэдээллийн технологийн/автоматжуулалтын инженерүүд, МСК болон түүний зөвлөх Стантек компанийн зөвлөхүүдээс бүрдсэн УСУГ-ын ажлын хэсгийн дэмжлэгтэйгээр техникийн нөхцөл, зардлын тооцоог боловсруулж байна. Худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилтийн үе шатанд Монголын МСС-гийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах баг техникийн туслалцаа үзүүлэх бөгөөд Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн баг, МСК-ын зөвлөх Стантекийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм. Хэрэгжилтийн явцад ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг дагаж мөрдөж буйд хяналт тавих үүргийг Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хариуцсан баг хариуцна.

МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОО, ТӨЛӨВЛӨЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ

Энэ үйл ажиллагааны зорилго нь зөөврийн ус түгээх байруудыг шинээр байгуулах, хөгжүүлэх чиглэлээр хотын байгууллагуудын мэдээлэл солилцох, төлөвлөх, хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх явдал юм. УСУГ, НЗДТГ болон дүүргийн төрийн байгууллагуудын хооронд холбогдох шийдвэр гаргахад бодлогын зохицуулалт, хамтын ажиллагаа дутагдалтай байдгаас шинээр байгуулах ус түгээх байрны төлөвлөлт асуудалтай хэвээр байна. Жил бүр гэнэтийн, эсвэл төлөвлөөгүй шинэ ус түгээх байруудыг Нийслэлийн өмчийн харилцааны газраас барьж, бүртгэж, УБ хотын дүүргүүдээс УСУГ-ын үйл ажиллагаанд шилжүүлэн хуваарилдаг. Ус түгээх байрны төлөвлөлт, барилгын ажлыг зохицуулах хууль эрх зүйн тодорхой зохицуулалт байдаггүй. Тус үйл ажиллагаанаас хүлээгдэж буй үр дүн бол гэр хорооллын зөөврийн ус түгээх байруудын ашиглалтын зардлыг бууруулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх болон талуудын оролцоотой байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах явдал юм.

НЖО-той холбоотой асуудлууд болон дүн шинжилгээ. ТТЭ-ийн судалгааны үр дүнгээс үзэхэд гэр хорооллын хэрэглэгчдийн 57% нь буюу зөөврийн ус түгээх байрны хэрэглэгчид нь ус түгээх байран дээр хүлээх хугацаа, ус түгээх байруудын хоорондын зай, усны чанар (зэв, амт, үнэр), төлбөрийн арга, хэрэглэгчдийн гомдлыг шийдвэрлэх болон үйлчилгээний хүртээмжийн тал дээр сэтгэл ханамжбагатай байдаг. Тус үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зөөврийн ус түгээх байрны хэрэглэгчидтэй зөвшилцөх нь чухал. Тус үйл ажиллагааны гол зорилго нь хөдөө орон нутгаас хот руу шилжин ирэгсдийн ихэнх нь байрладаг УБ хот захаараа тэлэхтэй холбоотой зөөврийн ус түгээх байруудын ирээдүйн төлөвлөлтийг сайжруулах явдал юм. Ирээдүйн хэрэгцээнд үндэслэсэн зөөврийн ус түгээх байрны төлөвлөлт сайжирснаар усны үйлчилгээ хүртээмж муутай байдаг газруудад ус түгээх байр барих ажлыг төлөвлөх замаар

хэрэглэгчдэд, ялангуяа бага орлоготой хүн амын усны үйлчилгээний хүртээмжийг сайжруулах боломжтой болно.

Хэрэгжилтийг зохион байгуулах. Тус үйл ажиллагааг УСУГ-ын тусламжтайгаар Монголын МСС-гийн Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн баг хэрэгжүүлэх юм. УСУГ-ын усан хангамжийн зардлыг байгууллагууд хоорондын зохицуулалт, шийдвэр гаргах ажлыг дүүрэг, хороодын албан тушаалтнуудтай хийсэн өргөн хүрээний хэлэлцүүлэг, зөвлөгөөнд үндэслэн НЗДТГ-аас удирдана. Түүнчлэн зөөврийн ус түгээх байрны өсөлтийг тогтмол хянаж, зөвхөн үйл ажиллагааны зардал багатай байшилд ус түгээх байр шинээр нэмж байгуулах нь УСУГ-ын зардлыг бууруулахад туслах боловч нийгмийн сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй юм. Гэр хорооллын алслагдсан, уулархаг хэсгийн өрхүүд УСУГ-ын үйл ажиллагаанд илүү хэмнэлттэй газар руу хол явахгүйгээр ойролцоох газраас ундны усаа авахыг илүүд үздэг. Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн оролцоог хангах баг дээр дурдсан нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд техникийн дэмжлэг үзүүлнэ.

С. УС АШИГЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ДЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ерөнхий мэдээлэл. Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагааны хүрээнд шинээр бий болох дэд бүтцийг ажиллуулах, үйл ажиллагааг төлөвлөх, засвар үйлчилгээ хийх, хөрөнгийн менежментийг зөв зохистой хийхэд шаардлагатай ур чадварыг бий болгож ус ашиглалтын байгууллагуудыг чадавхжуулахад оршино. Тус үйл ажиллагаанаас хүлээгдэж буй үр дүн нь шинэ хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг илүү сайн хийж гүйцэтгэх чадавх нэмэгдэх бөгөөд энэ нь шинээр бий болох баруун эх үүсвэрийг тогтвортой ашиглах боломжийг бий болгож, одоогийн дэд бүтцийн хөрөнгийг бүрэн хүчин чадлаар нь тасралтгүй ашиглах боломж бий болгох юм. 2021 оны байдлаар тус үйл ажиллагаа гурван дэд үйл ажиллагаанаас бүрдэж байгаа, эдгээр нь одоогоор боловсруулалтын шатанд явж байна. Үүнд:

1. Ус ашиглалтын байгууллагуудын хооронд туршлага солилцох, түншлэх
2. Хэрэглэгчдийн мэдээллийн сан байгуулах
3. Хөрөнгийн менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг болно.

Хөрөнгийн менежменттэй холбоотой дэд үйл ажиллагаа нь байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд нийгэм, жендэрийн оролцоотой холбоотой ямар нэг үйл ажиллагаа байхгүй тул тус НЖНТ-ний энэ бүлгийг Ус ашиглалтын байгууллагуудын туршлага солилцох, түншлэх, Хэрэглэгчдийн мэдээллийн сан байгуулах хэсгүүд дээр боловсруулсан болно.

УС АШИГЛАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ, ТҮНШЛЭХ

Ус ашиглалтын байгууллагуудын туршлага солилцох, түншлэх үйл ажиллагаа нь УСУГ, ОСНААУГ болон өндөр хөгжилтэй орны туршлагатай бөгөөд ижил нөхцөл байдалд, ижил төрлийн асуудлуудтай тулгардаг ус ашиглалтын байгууллага хоорондын Усны байгууллагуудын түншлэлийг бий болгох төлөвлөгөөтэй юм. Түүнчлэн, тус үйл ажиллагааны гол зорилго нь УСУГ-ын чухал үйл ажиллагааны чадавхыг бий болгож, байгууллагын ашиглалт, засвар үйлчилгээний гүйцэтгэлийг сайжруулах юм. Компактын хэрэгжилтийн хугацаанд УСУГ, ОСНААУГ болон хөгжингүй орны ус

ашиглалтын байгууллагын төлөөллүүд сайн туршлагаа солилцох зорилгоор жилд хоёр удаа харилцан айлчлал хийх юм.

НЖО-той холбоотой асуудлууд болон дүн шинжилгээ. Монголын МСС-гаас Ус ашиглалтын байгууллагуудын туршлага солилцох, түншлэх үйл ажиллагааны оролцогчдыг сонгон шалгаруулах шалгуурт туршлага, ур чадвар, хичээл зүтгэл, суралцах хүсэл эрмэлзэл болон тухайн үйл ажиллагаанд хамгийн ихээр хамааралтай ажлын байрнаас сонгохоос гадна хүйсийн тэгш байдлыг харгалзан үзэх шаардлагатай юм.

Хэрэгжилтийг зохион байгуулах. Монголын МСС-гийн Усны салбарын тогтвортой байдлыг хангах баг Ус ашиглалтын байгууллагуудын туршлага солилцох, түншлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг удирдан зохион байгуулна. Нийтийн аж ахуйн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх хэрэгцээг тодорхойлохын тулд УСУГ, ОСНААУГ-ын одоогийн үйл ажиллагаа, менежментийн туршлагыг 2019-2021 онд Олон улсын усны ассоциацийн боловсруулсан үнэлгээний хэрэгсэл болох AquaRating-ийг ашиглан цогцоор нь үнэлсэн болно. AquaRating-ийн үнэлгээний зөвлөмж, тэдгээрийн зохион байгуулалтын тэргүүлэх чиглэлд үндэслэн УСУГ болон ОСНААУГ нь Ус ашиглалтын байгууллагуудын туршлага солилцох, түншлэх дэд үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар 2021 оны 4 дүгээр сард Монголын МСС-д анхны саналаа ирүүлсэн.

Ус ашиглалтын байгууллагуудын туршлага солилцох, түншлэх үйл ажиллагааны хүлээгдэж буй үр дүн нь "төлөвлөсөн засвар үйлчилгээ" хийх чадварыг сайжруулахын тулд "боловсон хүчний чадавхыг сайжруулах" зорилгоор "УСУГ болон ОСНААУГ-ын сул талуудыг (AquaRating-ийн илрүүлсэн байдлаар) шийдвэрлэх" юм. Түүнчлэн Ус ашиглалтын байгууллагуудын туршлага солилцох, түншлэх үйл ажиллагааны хэрэгжилт нь үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд хүргэж болох юм.

Монголын МСС 2022 оны эхний хагаст тус үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж дуусгах бөгөөд туршлага, ур чадвар, хичээл зүтгэл, суралцах хүсэл зэрэг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтүүдийг багтаах, холбогдох хэлтсүүдийн өөр өөр түвшний ажилтнуудын төлөөллийг оролцуулахаар төлөвлөж байна. Оролцогчдын хүйсийн тэнцвэртэй байдлыг харгалзан үзэх болно.

НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРТ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ БИЙ БОЛГОХ (ENGENDERING UTILITIES)

Нийтийн аж ахуйн салбарт жендэрийн тэгш байдлыг бий болгох үйл ажиллагаа нь Компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа биш бөгөөд УСУГ болон АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг хоорондын түншлэлийн хүрээнд хэрэгжиж буй юм. Тус үйл ажиллагаа нь Монголын МСС болон МСК-ын зохион байгуулалтын хүрээнд 2020 оны 11 дүгээр сараас хэрэгжиж байна. УСУГ газар 2021 оны 2 дугаар сард тус хөтөлбөрийн хүрээнд дөрвөн байгууллагатай хамт сонгогдсон юм. УСУГ-аас сонгогдсон оролцогчид АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Нийтийн аж ахуй салбарт жендэрийн тэгш байдлыг бий болгох хөтөлбөр хэрэгжүүлэгчээс өгсөн өөрчлөлтийн менежментийн тусгай хөтөлбөрөөс суралцаж байна. Жендэрийн тэгш байдлын гүйцэтгэх удирдлагын хөтөлбөр нь 2021 оны 7 дугаар сараас хэрэгжиж эхэлнэ. Харин ОСНААУГ 2022 оны эхээр эхлэх дараагийн хөтөлбөрт оролцох боломжтой юм.

НЖО-той холбоотой асуудлууд болон дүн шинжилгээ. Нийтийн аж ахуйн салбарт жендэрийн тэгш байдлыг бий болгох үйл ажиллагаа нь жендэрийн тэгш байдлын чухал ялгааг ойлгох, байгууллага доторх эмэгтэйчүүдийн боломжийг шууд нэмэгдүүлэх, нийтийн аж ахуйн үйлчилгээний үйл ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор аж ахуйн нэгжийн удирдагчдыг чадавхжуулдаг юм. Нийтийн аж ахуйн салбарт жендэрийн тэгш байдлыг бий болгох үйл ажиллагаа нь нотлох баримтад суурилсан жендэрийн тэгш байдлын шилдэг туршлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх явдал юм. АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг нь энэхүү арга барилаа өргөжүүлэн хэрэгжүүлсээр байгаа бөгөөд 2015 оноос хойш 21 орны 29 түнш байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Хэрэгжилтийг зохион байгуулах. Монголын МСС-гийн Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн баг Нийтийн аж ахуйн салбарт жендэрийн тэгш байдлыг бий болгох үйл ажиллагаа болон Ус ашиглалтын байгууллагуудын туршлага солилцох, түншлэх үйл ажиллагаа хоорондох боломжит хамтын ажиллагааг дэмжиж, зохион байгуулах ажлыг хариуцна. Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн баг УСУГ-ын "Нийтийн аж ахуйн салбарт жендэрийн тэгш байдлыг бий болгох" хөтөлбөрийг сонгох үйл явцыг дэмжиж, Гүйцэтгэх манлайллын хөтөлбөр дээр хамтран ажиллах боломжтой юм. Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн оролцоог хангах баг Усны салбарын тогтвортой байдлыг хангах багт жендэрийн тэгш байдал, нийгмийн оролцоог харгалзан үзэх үндсэн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор техникийн туслалцаа үзүүлэх юм.

ХЭРЭГЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙН САН БАЙГУУЛАХ

Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн оролцоог хангах баг УСУГ-ын хэрэглэгчийн мэдээлэл, ялангуяа өрхийн усны хүртээмж, хэрэглээний хэв маягийг тодорхойлох тоон мэдээллийг цуглуулах, чанар, дүн шинжилгээ хийх, ашиглах үйл ажиллагааг сайжруулах зорилготой Хэрэглэгчдийн мэдээллийн сан байгуулах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах юм. Тус үйл ажиллагааны зорилго нь бүх төрлийн өрхийн хэрэглэгч, ялангуяа хэрэглэгчдийн усны үйлчилгээнд өмнө нь тулгарч байсан бэрхшээлийг анхаарахад УСУГ-ын хариуцлагыг бэхжүүлэх явдал юм.

НЖО-той холбоотой асуудлууд болон дүн шинжилгээ. УСУГ Харилцагчийн үйлчилгээний хэлтэстэй бөгөөд хэрэглэгчдийн санал хүсэлт, мэдээлэл цуглуулах хэд хэдэн тогтолцоотой бөгөөд дуудлагын төв, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн жилийн судалгаа, ухаалаг ус түгээх байр ашигладаг айлуудын усны борлуулалтыг хянах, ингэснээр өрхийн хэрэглээг ойролцоогоор хянах боломжтой байдаг. Мөн 2021 онд ТТЭ-ийн судалгаа нь гэр хорооллын оршин суугчдын ус авах, усны хэрэглээ, үйлчилгээний боломжит сайжруулалтын сонголт, усны аюулгүй байдлын талаарх ойлголт, усны үнийн талаарх хандлагын талаарх чухал мэдээллийг УСУГ-д өгөх болно.

Хэрэгжилтийг зохион байгуулах. Монголын МСС-гийн Нийгэм, жендэрийн оролцоог хангах багаар ахлуулсан Мянганы сорилтын сангийн ажилтнууд Хэрэглэгчдийн төлбөрийн чадамж, Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр боловсруулах болон Тарифын хувилбар боловсруулах судалгаануудыг хийж гүйцэтгэн, ЗНТ, эсвэл усны үйлчилгээний бусад бодлого, зохицуулалтын шинэчлэлийг хийсний дараа УСУГ-тай хамтран ажиллах болно. Тус үйл ажиллагаа нь дараах үр дүнд хүрэх зорилготой юм. Үүнд:

- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, ус түгээх байрны ухаалаг картны аппликейшнээр цуглуулсан хэрэглэгчдийн мэдээлэл гэх мэт одоо байгаа

судалгааны хэрэгсэл, мэдээллийн эх сурвалжид нэмэлт мэдээлэл цуглуулах цэгүүдийг тохируулах;

- Ус түгээх байранд ирсэн засвар үйлчилгээ болон бусад асуудлын талаарх мэдээллийн өгөгдөлд дүн шинжилгээ хийх, олон нийтэд мэдээлэх, дүн шинжилгээг УСУГ-ын засвар үйлчилгээний төлөвлөлтөд оруулах;
- УСУГ-ын үйл ажиллагааны үндсэн шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлсон, эсвэл жилийн бизнес төлөвлөгөөнд тусгасан аливаа үйлчилгээний стандартыг хэр хангаж байгаа тухай мэдээллийг багтаасан жилийн тайлан гаргах.

Энэхүү үйл ажиллагаа нь усны үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой аливаа өөрчлөлт шинэчлэлийг цаг хугацааны явцад тогтвортой, олон нийтэд нээлттэй байдлаар зохион байгуулах боломжийг УСУГ-т олгох зорилгыг нэн тэргүүнд тавих болно.

Д. ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УСЫГ УРЬДЧИЛАН ЦЭВЭРЛЭХ, БОХИРДЛЫГ ХЯНАХ ДЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шинэ Төв цэвэрлэх байгууламж нь ТЭЗҮ-д зааснаар өдөрт 250,000 м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай байх бөгөөд цэвэрлэсэн усны чанар нь MNS 4943:2015 стандартын шаардлагыг хангасан байх ёстой. Иймд, аж ахуйн нэгжүүдээс Төв цэвэрлэх байгууламжид нийлүүлж буй хаягдал усны бохирдлын хэмжээг 2013 оны түвшин буюу түүнээс доош хэмжээнд хүргэж бууруулсан байх шаардлагыг Компакт гэрээний урьдчилсан болзолт нөхцөлүүдийн нэг болгосон. Бохирдлыг бууруулах гол арга зам бол аж үйлдвэрийн хаягдал усны бохирдлыг бууруулах явдал бөгөөд энэ зорилгоор холбогдох яам, агентлаг, байгууллагуудын оролцоотойгоор бохирдлыг бууруулах төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газрын тогтоолоор баталсан. Энэ хүрээнд аж үйлдвэрлэлийн бохирдлыг бууруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, иргэдийн ухамсрыг дээшлүүлэх техникийн болон захиргааны арга хэмжээг хэрэгжүүлэх 7 чиглэлээр нийт 63 ажлыг хийхээр төлөвлөсөн.

Тус үйл ажиллагаатай холбогдох дүн шинжилгээг НЖНТ-г шинэчлэхэд оруулж, НЖНТ-ний Үйл ажиллагааны төлөвлөгөөг мөн шинэчлэн тодорхойлох юм.

Е. ОЛОН НИЙТИЙН ДАДАЛ, ХАНДЛАГЫГ ӨӨРЧЛӨХ ДЭД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх дэд үйл ажиллагааны хүрээнд Компакт гэрээний усны салбарын ажлын үр нөлөөг сурталчлах, нэмэгдүүлэх, УБ хотын оршин суугчид хотын усны тогтвортой байдлын асуудлыг илүү сайн ойлгох боломжийг олгох зорилготой юм. Улмаар энэхүү ойлголт, тоон мэдээлэлд суурилсан олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх арга барилыг ашиглан эдийн засгийн өсөлтийг дэмжих, Улаанбаатарчуудын амьжиргааг дээшлүүлэх зорилго бүхий МСК болон Монгол Улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд энэ дэд үйл ажиллагаа нь чиглэгдэх болно.

НЖО-той холбоотой асуудлууд болон дүн шинжилгээ. Усны олборлолт, түгээлтийн шугам сүлжээ, бохир усыг дахин боловсруулах дэд бүтцийн чадавч сайжирснаар УБ хотын оршин суугчид болон аж үйлдвэрийн хэрэглэгчдийн усны хэрэгцээг хангахад томоохон хувь нэмэр оруулж байгаа боловч хүмүүсийн дадал, хандлагыг бий болгогч хүчин зүйлс усны салбарын тогтвортой байдалд мөн чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх нь ус хангамжийн системд шаардлагатай хөрөнгө

оруулалтын зардлыг нөхөхийн тулд усны үйлчилгээнд нэмэгдсэн төлбөр төлөхөд хэрэглэгчдийн сэтгэл зүйг бэлтгэх, ойлголтыг нэмэгдүүлэх чадавх, боломж, сэдэлд тулгуурласан аргачлал юм. Олон нийтийн дадал, хандлагын өөрчлөлт нь зөвхөн эрэлт хэрэгцээ төдийгүй усны үйлчилгээ үзүүлэгчид, хэрэглэгчид, усны салбарын оролцогч талууд хоорондын харилцаа холбоо ямар байхыг тодорхойлдог. Улаанбаатар хотын усны салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчдийн ирээдүйн зан төлөвийг өөрчлөх нь хэрэглэгчдийн зарим бүлгүүдийн усны хэрэглээний түвшин хангалтгүй байдал, усны нөөцийг зохистой ашиглах болон байгалийн нөөцийн хомсдолтой холбоотой нийгмийн эрсдэлийг бууруулахад хувь нэмэр оруулах болно.

Төлөвлөлт боловсруулах арга.

Энэхүү үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулах үе шат эхлэхээс өмнө дөрвөн чиглэл бүхий судалгааны арга барилаар нийгмийн дадал, хандлагыг бий болгодог тодорхойлогч хүчин зүйлсийг нарийвчлан судлах болно. Үүнд:

- Олон нийтийн дадал, хандлагыг судлах чанарын судалгааг эхлүүлэх;
- ТТЭ-ийн судалгааны өрхийн асуулгад нийгмийн дадалтай холбоотой асуултуудыг оруулах;
- ТТЭ-ийн судалгааны үр дүнд тулгуурлан дадал, хандлагын талаар нэмж судлах;
- Тус үйл ажиллагааны төлөвлөлтөд хамтран ажиллах зөвлөх, эсвэл хамтрагч байгууллагыг сонгон шалгаруулах.

Эдгээр арга барилд мэдлэг, хандлага, нийгэм болон соёлын хэм хэмжээ, уламжлал, дадал зуршлыг хамааруулан авч үзнэ. Иймд энэхүү дэд үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хувь хүн аливаа зан үйлийг өөрийн болгох, өөртөө шингээж авах чадвар, боломж, хүсэл эрмэлзэлтэй байх үед дадал, хандлагын өөрчлөлт гардаг гэж үздэг МСК-ын олон нийтийн дадал, хандлагыг судлах загварыг ашиглах болно. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцад нийгмийн болон зан төлөвийн өөрчлөлтийн чанарын мэдээлэл цуглуулах эхний үе шатны ажлыг хийж дууссан бөгөөд холбогдох тоон судалгааны өгөгдлүүдийг ТТЭ-ийн судалгаагаар цуглуулсан болно. Чанарын болон тоон мэдээллийг аль алийг нь нарийвчлан шинжилсний үндсэн дээр дадал, зан үйлийг өөрчлөх гол хүчин зүйлс, бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох болно. Олон нийтийн дадал, хандлагыг тодорхойлох тэдгээр гол хүчин зүйлсийг харгалзан УБ хотын усны салбарын тогтвортой байдалд нөлөөлөх олон нийт, оролцогч талуудын зан үйл, дадал хандлагыг өөрчлөхөд чиглэсэн тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөөний нарийвчилсан загварыг гадны түнш байгууллага, эсвэл зөвлөхийн оролцоотойгоор боловсруулан хэрэгжүүлнэ.

Олон нийтийн дадал хандлагыг өөрчлөх МСК-ын жишиг загварын дагуу Компактын хөрөнгө оруулалт нь аливаа бүтэц, нийгэм, хувь хүнд чиглэсэн үйл ажиллагаануудыг санхүүжүүлдэг. Эдгээр үйл ажиллагаа нь нэгэн багц болж хөрөнгө оруулалтын завсрын үр дүнгүүдтэй холбогдох гол зан үйлийг хэрэгжүүлэх, дэмжих хүмүүсийн чадавх, боломж, сэдэлд нөлөөлдөг. Дүрэм журмыг өөрчлөх, шинэ дэд бүтэц бий болгох, стандарт журам боловсруулах зэрэг нь бүтцийн тал дээр хийж буй өөрчлөлтийн алхмууд байх бол тухайн орон нутгийн насанд хүрэгчид, хүүхдүүдэд шинэ дадал үүсгэх, ус ашиглах, хямгадах талаарх нийгмийн хэм хэмжээг хэлэлцэх яриа хэлэлцүүлэг гэх мэт хувь хүний шийдвэр гаргах, зан төлөвт нөлөөлдөг олон нийтийн болон бүлгийн хэм хэмжээг өөрчлөх нь нийгэмд чиглэсэн өөрчлөлтийн арга хэмжээ юм. Мөн хувь хүнд чиглэсэн үйл ажиллагаанд ус хэмнэх шинэ арга барил нэвтрүүлэхийн тулд усны шинэ технологийг хэрхэн ашиглах талаар тайлбарлах, усны шинэ тариф нэвтрүүлэх замаар нийгмийн шударга ёсыг тогтоох талаар ухуулан сурталчлах зэрэг мэдээлэл харилцааны

кампанит ажлууд зохион байгуулж, хувь хүмүүстэй тулж ажиллах, шууд уулзалт хийх зэрэг алхмууд багтана.

Орон сууцны иргэдийн усны төлбөрөө цаг тухайд нь төлөх байдлыг нэмэгдүүлэх.

Усны салбарын зардлыг нөхөхөд тулгарч буй гол бэрхшээлүүдийн нэг бол ОСНААУГ болон хувийн конторуудын үйлчилгээ үзүүлдэг орон сууцны хэрэглэгчид төлбөрөө хоцроох, төлөхгүй байх явдал юм. Гэр хорооллын хэрэглэгчид ус түгээх байрнаас ус авахдаа төлбөрөө төлдөг тул сар бүр төлөх усны төлбөр байдаггүй. Дэлхийн банкны Усны нөөцийн бүлэг 2030 байгууллага УБ хотын ирээдүйн усны эрэлтийн зөрүүг багасгах эдийн засгийн үр ашигтай шийдлүүдийн гидро эдийн засгийн шинжилгээгээр ОСНААУГ-ын орлого бүрдүүлэлтийн жилийн хэмжээ ойролцоогоор 70-80%-ийг эзэлдэг болохыг харуулсан байна. Хугацаа хэтэрсэн төлбөрийг шийдвэрлэх нь УБ хотын усны салбарын урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах чухал асуудлын нэг юм.

Цахилгаан эрчим хүчнээс ялгаатай нь хэрэглэгчид төлбөрөө төлөлгүй усны төлбөр их хэмжээгээр хуримтлагдах үед усыг тасалдаггүй. Үйлчлүүлэгчдийн дунд төлбөрөө хоцроох, төлөхгүй байх зэрэг нь холбогдох нийгэм, санхүүгийн асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай байгааг харуулж байна. Цэвэр, бохир усны тариф нэмэгдвэл оршин суугчид орон сууцны төлбөрөө төлөхгүй байх, төлбөрөө хойшлуулах байдал үүсгэж болох талтай. Усны салбарын урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс усны төлбөрийг хуримтлуулах, төлбөрөө төлөхгүй байх зэрэг нийгмийн болон зан үйлийн бусад хүчин зүйлсийг судалж, УБ хотын усны нөөцийн хомсдол, байгалийн нөөцийн хомсдолоос үүдэлтэй нийгэм, эдийн засгийн ирээдүйн асуудлаас зайлсхийх шаардлагатай байна. Тус дэд үйл ажиллагаа нь ТТЭ-ийн судалгааны үр дүнд нарийвчилсан дүн шинжилгээ хийх, фокус бүлгийн хэлэлцүүлгээс чанарын дүн шинжилгээ хийх замаар төлбөрийн хоцрогдол, төлбөр төлөхгүй байх зэрэг нийгэм, зан үйлийн гол хүчин зүйлсийг судлах болно.

Гэр хорооллын хэрэглэгчдийн дадал, хандлага. ТТЭ-ийн судалгааны урьдчилсан

дүгнэлтээр УБ хотод ядуу гэсэн ангилалд хамаарах таван өрхийн дөрөв нь гэр хороололд амьдардаг. Сүүлийн жилүүдэд гэр хорооллын ядуурлын түвшин өндөр, хот, суурин газрын орлогын өсөлтийн тэгш бус байдал нэмэгдэж байгаа нь бага орлоготой гэр бүлүүд төвлөрсөн цэвэр, бохир усны системтэй холбогдсон орон сууцанд хамрагдах боломж улам багасч, гэр хорооллын иргэд болон орон сууцны оршин суугчдын амьдралын түвшний хоорондын ялгаа улам нэмэгдэж байгааг харуулж байна. Өнөөгийн байдлаар гэр хорооллын хэрэглэгчид усаа зөөврийн ус түгээх байрны үйлчилгээ үзүүлэх зардлаас доогуур үнээр худалдан авч байна. Ус түгээх байрнаас ус авах өрхийн боломжоос шалтгаалан усны хэрэглээ хязгаарлагдмал (нэг хүнд өдөрт 8 литр, ДЭМБ-аас зөвлөмж болгосон 20 л-ээс 60 хувиар бага) байгаа нь гэр хорооллын иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Усны тарифын нэмэгдлийг үр дүнтэй нэвтрүүлж, гэр хорооллын үйлчлүүлэгчдэд хүлээн зөвшөөрүүлэхийн тулд усны тарифын нэмэгдлийг хүлээн зөвшөөрөх, ус түгээх байраар усны үйлчилгээ хүргэхэд гардаг бодит зардал, усны салбарын санхүүгийн тогтвортой байдлын чухлыг ойлгоход нөлөөлөх олон нийтийн дадал хандлагын гол хүчин зүйлсийг тодорхойлох нь туйлын чухал юм. Ингэснээр УБ хотын оршин суугчид усны салбар, усны үйлчилгээний тогтвортой байдалд тулгамдсан асуудал, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх, сайжруулах арга хэмжээний талаар илүү сайн ойлголттой болох юм.

Нэмэгдсэн тарифыг хүлээн зөвшөөрөх. МСК-ын зөвлөх 2019 онд усны төлбөрийн төлөв байдалд ямар хүчин зүйл нөлөөлж болохыг тодорхойлохын тулд орон сууц, гэр

хорооллын усны хэрэглэгчидтэй чанарын судалгааны фокус бүлгийн хэлэлцүүлэг хийсэн. Судалгааны анхны шинжилгээний үр дүнгээс орон сууц худалдан авагчдын төлбөрийн дадалд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг доорх байдлаар тодорхойлов.

- Усны тариф бага байна гэсэн ойлголт;
- Усны үйлчилгээ, хангамжийн чанар;
- Хугацаа хэтрүүлсэн тохиолдолд мөнгөн торгууль төлөхөөс зайлсхийх шаардлагагүй;
- Хугацаа хэтэрсэн төлбөр төлөгчдийг орон сууцны үүдэнд байрлуулсан зар, эсвэл байрны оршин суугчдын харж болох самбар дээр зарлах замаар төлбөрөө төлөөгүй гэж олон нийтэд зарлахаас зайлсхийх;
- Төлбөр төлөх арга хэрэгсэл дутмаг байх;
- Төлбөрийг цаг тухайд нь төлсөн тохиолдолд УСУГ-ын үйл ажиллагаа доголдохгүй гэсэн ойлголт дутмаг;
- Нийгмийн хариуцлага, эсвэл сайн иргэн байх сэдэл.

Тус үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлага болон ТТЭ-ийн судалгааны үр дүнгээс үзэхэд гэр хороолол болон орон сууцны хэрэглэгчдийн аль аль нь одоогийн усны тарифыг хямд гэж үздэг байна. ТТЭ-ийн судалгааны урьдчилсан үр дүнгээс үзэхэд гэр хорооллын хэрэглэгчид УСУГ-ын ус түгээх байрнаас литр тутамд төлдөг 1 төгрөгөөс даруй 6 дахин их, харин орон сууцны хэрэглэгчид одоогийн төлбөрөөс 50%-аар өндөр тариф төлөхөд бэлэн байна. Тус үр дүнд тулгуурлан МСК-ын зөвлөхүүд хэрэглэгчид одоогийн усны тарифаас өндөр тариф төлөх эрмэлзэлд ямар дадал, хандлага нөлөөлж буй талаар судалж байна.

НЖО-той холбоотой асуудлууд болон дүн шинжилгээ. Орон сууцны хэрэглэгчдийн одоогийн цэвэр болон бохир усны хэрэглээ, төлбөр төлөх дадалд нөлөөлж буй хүчин зүйлс нь нийгмийн холбогдолтой зарим талуудыг агуулдаг боловч нийгмийн болон жендэрийн асуудлууд нь нийгмийн хариуцлагатай холбоотой байна. Тус дэд үйл ажиллагааны нийгэм, жендэртэй холбоотой гол бүрэлдэхүүн хэсгүүдийг ТТЭ-ийн судалгааны тоон судалгаа, фокус бүлгийн ярилцлагаас авсан чанарын дүн шинжилгээний аль алийг ашиглан боловсруулсан олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх үйл ажиллагааны загвар дээр үндэслэн тодорхойлно. Эдгээр арга хэмжээ нь олон нийтийн дадал, хандлагатай холбоотой гол хүчин зүйлсийг шийдвэрлэхийн зэрэгцээ нийгэм, жендэрийн асуудлыг мөн анхаарч үзэх ёстой. Жишээ нь, хоорондоо харилцан адилгүй түвшний усны үйлчилгээнд ялгаатай төлбөр төлдөг, нийгэм, эдийн засгийн онцлог шинж чанараараа ялгаатай гэр хороолол, орон сууцны оршин суугчдад чиглэсэн арга хэмжээнүүдийг тодорхойлж, оруулсан эсэхийг анхаарч үзэх ёстой. Эдгээр нийгэм, жендэрийн оролцоотой холбоотой асуудлуудыг дэд үйл ажиллагааны төлөвлөлт, загвар боловсруулах үе шатанд хангах болно.

Хэрэгжилтийг зохион байгуулах. Дэд үйл ажиллагаа амжилттай хэрэгжих, Компакт гэрээний хэрэгжилтэд оруулах хувь нэмрийг баталгаажуулахын тулд тус үйл ажиллагааны ач холбогдлыг Монголын МСС-гийн удирдлагын зүгээс сайн ойлгож, дэмжиж ажиллах нь нэн чухал юм. Үйл ажиллагааны төлөвлөлт, загварыг боловсруулахаас өмнө Монголын МСС-даа уулзалтуудыг зохион байгуулж, Монголын нөхцөлд олон нийтийн дадал, хандлагын онолын үндэс, хэрэглээг тайлбарлаж, хэлэлцэх болно. Хэрэгжүүлэгч байгууллагын гэрээний хүрээнд, ХСУХАТАУ33 нь тус үйл ажиллагааны төлөвлөлт, загварыг боловсруулахад техникийн туслалцаа үзүүлэх юм.

Тус үйл ажиллагаатай холбогдох дүн шинжилгээг НЖНТ-г шинэчлэхэд оруулж, НЖНТ-ний Үйл ажиллагааны төлөвлөгөөг мөн шинэчлэн тодорхойлох юм.

VI. НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН НЭГТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нийгэм, жендэрийн нэгтгэсэн төлөвлөгөө (НЖНТ)-ний энэ бүлэгт Компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны загвар боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх, хаалтын бүх үйл ажиллагааны явцад нийгэм, жендэрийн оролцоо (НЖО)-г хангах зорилтууд, үйл ажиллагаа, хүлээгдэж буй үр дүнг тусгасан болно. НЖНТ-ний Хувилбар 2.0-ыг Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС), Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ) зэрэг баримт бичиг дэх НЖО-г хангахтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулав. НЖО-г хангах зорилт, үйл ажиллагаа, үр дүнг Компакт гэрээг хэрэгжүүлэх бүх шатанд тогтмол хянаж байх болно.

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
I. САЛБАР ДУНДЫН НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА				
Зорилт 1.1 Компакт гэрээний бүх шатанд нийгэм, жендэрийн эрсдэлийг тодорхойлж, сөрөг нөлөөг бууруулах, хариу арга хэмжээ авах	<ul style="list-style-type: none"> НЖО-той холбогдох эрсдэлийн үнэлгээг хийж, хариу арга хэмжээг тодорхойлж, төлөвлөгөөг тогтмол шинэчилж байх Эрсдэлийн үнэлгээний дагуу НЖО-тэй холбогдох эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах 	<ul style="list-style-type: none"> НЖО-той холбоотой эрсдэлийг тодорхойлж, бууруулах, үнэлэх, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг боловсруулж, жил бүр шинэчилсэн байх Бүх боломжит хариу арга хэмжээг авсан байх 	Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: Дотоод аудит	2021 - 2026
Зорилт 1.2 НЖО-той холбогдох гол үр нөлөө, сайн туршлага, амжилтын түүхийг баримтжуулах	<ul style="list-style-type: none"> Компакт гэрээг хэрэгжүүлэх явцад НЖО-г хангасны гол үр нөлөө, сайн туршлага, амжилтын түүхийг баримтжуулах Үр нөлөө, амжилтын түүхийг оролцогч талууд, олон нийтэд сурталчлах Компакт гэрээний хаалтын тайланд НЖО-той холбогдох гол үр нөлөө, сайн туршлага, амжилтын түүхийг тусгах 	<ul style="list-style-type: none"> НЖО-той холбогдох гол үр нөлөө, сайн туршлага, амжилтын түүхийг баримтжуулсан байх НЖО-той холбогдох үйл ажиллагааны эерэг үр нөлөө, амжилтын түүхийг оролцогч талууд, олон нийтэд таниулах уулзалтууд зохион байгуулсан байх Монголын МСС-гийн цахим хуудас, жилийн тайлан, эцсийн тайланд амжилтын түүхийг тодорхойлж нийтэлсэн байх 	Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: Олон нийттэй харилцах баг	2021 - 2026

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
II. ДЭД БҮТЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА				
A. Гэрээлэгчид нийгмийн оролцоог хангах боломжийг нэмэгдүүлж, нийгмийн эрсдэлийг үнэлж, үр дүнтэй хариу арга хэмжээ авч байгаад хяналт тавих				
<p>Зорилт 2.1 БОННУ-нд НЖО-той холбогдох анхаарч ажиллах нийгмийн дүн шинжилгээг тусгаж, БОНМТ-нд НЖО-той холбогдолтой шаардлагыг дэлгэрэнгүй тусгах</p>	<ul style="list-style-type: none"> • БОННУ, БОНМТ боловсруулах ажлын удирдамжид НЖО-той холбоотой техникийн зөвлөмж хүргэх • БОННУ, БОНМТ-ний НЖО-той холбоотой хэсгийг үнэлж, санал, зөвлөмж өгөх • БОННУ, БОНМТ боловсруулахад НЖО-той холбоотой бүх шаардлагыг Ажлын удирдамж боловсруулж буй багт мэдэгдэх 	<ul style="list-style-type: none"> • БОННУ-үүдэд дэд бүтэцтэй холбоотой төлөвлөлтийг үр дүнтэй болгох үүднээс НЖО-той холбоотой мэдээллийг сайтар тусгасан байх • БОННУ-үүдэд МСК-ын бодлого, удирдамж, ОУСК-ын ГС-уудын боломж, эрсдэлүүдийг 100% тусгасан байх • МСК-ын бодлого, удирдамж, ОУСК-ын ГС-ын боломж, эрсдэл бүрийг БОННУ-д тусгахдаа: <ul style="list-style-type: none"> - боломж, эрсдэл бүрийн дүн шинжилгээ - боломж, эрсдэл бүрт авах хариу арга хэмжээ - боломжит хамтрагч талууд - Гэрээлэгчийн хүлээх үүрэг • БОНМТ-үүд гаргаснаар Гэрээлэгчийн БОНМТ-нд хүрэх үр дүнг тодорхой тусгаж, үр бүтээлтэйгээр боловсруулж, төлөвлөж, төсөв хуваарилсан байна. • БОНМТ-үүдэд гэрээлэгчийн бүх төрлийн эрсдэл, ба боломжийг бүрдүүлэх менежментийн арга хэмжээг хяналтын шалгуур, төсвийн хамт МСК-ын жендэр, ХХГХТ 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: Худалдан авах ажиллагааны баг</p>	<p>2020 - 2022</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
		бодлогууд, бэлгийн дарамтын талаарх МСС-гуудад зориулсан удирдамжийн дагуу тусгасан байна.		
<p>Зорилт 2.2 Тендерт оролцогчдод НЖО-г хангахтай холбоотой шаардлагуудыг таниулж, зөвлөх, гэрээлэгч нарт гэрээ, техникийн шаардлага, холбогдох баримт бичигт тавигдах НЖО-г хангах шаардлагуудын талаар удирдамж, чиглэлийг өгөх</p>	<ul style="list-style-type: none"> Холбогдох бүх ажил үйлчилгээний техникийн үзүүлэлт, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулахад НЖО-г хангах шаардлагуудыг тусгасан эсэхийг үнэлж, санал өгөх Холбогдох бүх ажил үйлчилгээний техникийн үзүүлэлт, төлөвлөлтийн баримт бичгүүдэд МСК-ын жендэр, ХХГХТ бодлогууд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн зорилт, дотоодоос хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх эрх, бусад НЖО-г хангах нөхцөлүүд бүхий заалт оруулах Гэрээлэгч, зөвлөхүүдийн төсөвт НЖО-г хангахтай холбоотой БОНМТ-д тусгасан үйл ажиллагааны төсвийн ангиллыг оруулах 	<ul style="list-style-type: none"> Үнэлсэн бүх холбогдох ажил үйлчилгээний техникийн үзүүлэлт, шалгуур бүхий баримт бичигт НЖО-г хангах нөхцөлүүд туссан байна. Бүх техникийн шалгуур, төлөвлөлтийн баримт бичгүүдэд МСК-ын бодлогууд, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт дахь НЖО-г хангах заалт орсон байна. Үнийн саналд НЖО-г хангах үйл ажиллагааны төсөв хуваарилагдсан байна. 	Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Худалдан авах ажиллагааны баг	2020 - 2025
	<ul style="list-style-type: none"> Эмэгтэй ажилчдыг 30%-д хүргэх, дотоодоос ажилчид авах зэргээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бэлгийн дарамт, ХХГХ-ийг үл тэвчих тухай мэдээлэл, шаардлагыг Тендерийн баримт бичигт тусгасан байх Томоохон дэд бүтцийн ажлын тендерийн баримт бичигт Нийгэм, 	<ul style="list-style-type: none"> Тендерийн санал ирүүлэх хүсэлт, ажлын удирдамж, ажлын заавар, БОНМТ болон бусад баримт бичиг дэх хөдөлмөр эрхлэлт, аюулгүй ажиллагаа, эрх тэгш байдал, тэгш хүртээмж, нийгэм, жендэрийн эрсдэлийн менежментийн шаардлагыг тусгасан хувь 	Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Худалдан авах ажиллагааны баг	2020 – 2023

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
	<p>жендерийн менежерийн орон тоог үндсэн ажилтны жагсаалтад оруулах.</p> <ul style="list-style-type: none"> Тендерийн ажлын танилцуулга, зааварчилгаа өгөх хуралд НЖО-г хангахтай холбоотой мэдээлэл шалгуурыг тусгах. 	<ul style="list-style-type: none"> Томоохон дэд бүтцийн төсөлд хамгийн багадаа 1 нийгэм, жендерийн менежер ажиллуулсан байна. НЖО-г хангах шалгуураар үнэлсэн тендерт оролцогчдын хувь НЖО-г хангах талаар санал зөвлөгөө өгсөн тендерийн баримт бичгийн хувь НЖО-г хангах багийн бэлтгэсэн тендерийн баримт бичгийн тоо болон төрөл 		
В. Компакт гэрээний санхүүжилттэй дэд бүтцийн үйл ажиллагаанд орон нутгийн иргэдэд түр хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх				
<p>Зорилт 3.1 Ажилд орох боломжийг тэгш, нээлттэй байлгах замаар орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, эмэгтэйчүүдийн ажил эхлэлтийг 30%-д хүргэх</p>	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, дотоодын худалдан авалтыг дэмжих зорилгоор дүүргийн төрийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааг бий болгох БОНМТ-ний эмэгтэйчүүд, орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих Гэрээлэгчид ажилчдаа хүйс, Хан-уул болон Сонгинохайрхан дүүргийн оршин суух харьяалал, МСҮТ-ийн төгсөгч, (байнгын, түр, бүтэн, хагас цагаар гэх мэт) ажлын төрлөөр ангилсан бүртгэлээ тогтмол хийж, ХМЗ-д мэдээлж байх 	<ul style="list-style-type: none"> Ажилтан авах ажлыг хариуцах тусгайлсан ажилтан, эсвэл бүлгийг томилсон байна. Компакт гэрээг хэрэгжүүлэх хугацаанд дэд бүтцийн хоёр төсөлд хагас болон бүтэн цагийн нийт ажилтнуудын 30-аас багагүй хувьд эмэгтэйчүүд ажилласан байна. Гэрээлэгчид нь ажилчдаа хүйс, Хан-уул ба Сонгинохайрхан дүүргийн оршин суух харьяалал, МСҮТ-ийн төгсөгч, (байнгын, түр, бүтэн, хагас цагаар гэх мэт) ажлын төрлөөр ангилсан бүртгэлээ тогтмол хийж Монголын МСС, ХМЗ-д мэдээлсэн байна. Ажилчид болон гэрээлэгчид хооронд хөдөлмөрийн гэрээ 100% байгуулсан байна (Гэрээнд дугаар, гэрээний 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Худалдан авах ажиллагаа, МҮ-ний багууд</p>	<p>2021 - 2026</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
		<p>нөхцөл, эрүүл мэнд, нийгмийн даатгал, ажил үүргийн хуваарь, бэлгийн дарамт, хүүхдийн хөдөлмөр, албадан хөлөлмөр эрхлэлт хориглосон зэрэг хөдөлмөрлөх эрхийн гол шаардлагуудыг тусгасан байна.).</p> <ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн ур чадвар шаардлагатай болон мэргэжлийн ур чадвар үл шаардах ажилд эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулан орон нутгийн иргэдээс ажилласан хувь барилгын салбарын дунджаас өндөр байна. (Гэрээлэгч хотын түвшний шалгуурыг хороо, дүүргийн засаг захиргаатай хэлэлцэн тогтооно.) • Байнгын болон түр ажлын байранд ажилласан Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн оршин суугчдын тоо (Гэрээлэгч шалгуурыг хороо, дүүргийн засаг захиргаатай хэлэлцэн тогтооно) 		
<p>Зорилт 3.2 Эмэгтэйчүүдийн болон орон нутгийн бизнес эрхлэгчдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг тэлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Гэрээлэгчдийг орон нутгийн бизнес эрхлэгчдээс бараа үйлчилгээ худалдан авахыг дэмжих • Гэрээлэгчдийг орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчид, ялангуяа эмэгтэйчүүдийн эрхэлдэг болон бичил бизнес эрхлэгчдээс бараа, 	<ul style="list-style-type: none"> • Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн бизнес эрхлэгчидтэй бараа үйлчилгээ худалдан авахаар байгуулсан жил бүрийн гэрээний тоо болон хувь • Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн бизнес эрхлэгчидтэй бараа үйлчилгээ 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Худалдан авах ажиллагааны баг</p>	<p>2021 - 2026</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
	<p>үйлчилгээ авах тухай мэдээлэл түгээхийг дэмжих</p> <ul style="list-style-type: none"> • Дүүрэг хорооны засаг захиргаа, олон нийтийн байгууллага, бизнес эрхлэгчдийн холбоо, хэвлэл мэдээллээр бараа үйлчилгээний худалдан авалт, тендерт оролцох боломжийг мэдээлэхэд чиглэсэн уулзалтыг хамтран зохион байгуулах 	<p>худалдан авах жил бүрийн гэрээний нийт мөнгөн дүн</p> <ul style="list-style-type: none"> • Гэрээлэгч нь орон нутгийн төрийн байгууллагууд орон нутгийн иргэдийн бизнесийг дэмжих түншлэлийг бий болгосон байна. • Гэрээлэгч нь дотоодын худалдан авалтын талаар мэдээллээ Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн төрийн байгууллагууд, Монголын МСС-д мэдээлж, худалдан авалт бүрээ орон нутгийн бизнес эрхлэгчид, олон нийтэд сурталчилсан байна. • Эмэгтэйчүүдийн эрхэлдэг бизнесийн худалдан авалтын тоо болон хувь • Үйлчилгээний гэрээ байгуулсан Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн бизнес эрхлэгчдийн тоо, Орон нутгийн (Улаанбаатарын) бизнес эрхлэгчдийн тоо, эмэгтэй эзэнтэй бизнес эрхлэгчдийн тоо 		
<p>Зорилт 3.3 Эмэгтэйчүүд, залуучууд, орон нутгийн иргэдийн ур чадвар, чадавх, эрх мэдлийг нэмэгдүүлэх боломжийг тэлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Гэрээлэгчдийг орон нутгийн ажилчдын ажлын байран дээр ур чадвар нэмэгдүүлэх сургалт, дадлагыг зохион байгуулахыг дэмжих • Гэрээлэгчдийг сургалт, боловсрол, мэргэжлийн ХНХЯ-ны харьяа хэрэжүүлэгч агентлаг МБСҮМАЗТ, ШУТИС, Монголын барилгачдын холбоо зэрэг байгууллагуудтай 1) 	<ul style="list-style-type: none"> • Гэрээлэгч бүр нэгээс багагүй МСҮТ-тэй гэрээ байгуулж, Гэрээлэгч ба Монголын МСС-гийн, эсвэл түүний төлөөлөгчийн тогтоосон зорилтын дагуу төгсөгчдөөс ажилд авсан байна. • Мэргэжлийн болон техникийн ур чадвар олгох ажлын байран дээрх сургалтад оролцсон орон нутгийн ажилчдын тоо 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Худалдан авах ажиллагаа, Олон нийттэй харилцах багууд</p>	<p>2021 - 2026</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
	<p>мэргэжлийн ажилтныг олж ажилд авах, 2) мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дадлага хийлгэх, туршлага солилцох талаар холбох, албан ёсны гэрээ байгуулахыг зохион байгуулах, чиглүүлэх</p> <ul style="list-style-type: none"> Гэрээлэгчид усны салбарын инженер, холбогдох мэргэжлээр их сургуульд суралцагч оюутнуудыг дадлага хийх боломжоор хангах үйл ажиллагааг зохион байгуулах 	<ul style="list-style-type: none"> Гэрээлэгчийн хийж гүйцэтгэж буй ажил дээр дадлага хийж эхэлсэн МСҮТ-ийн оюутан, төгсөгдчийн тоо (гэрээлэгч зорилтыг хэрэжүүлэгч агентлаг МБСҮТ-тэй хэлэлцэн тодорхойлно) Гэрээлэгчийн хийж гүйцэтгэж буй ажил дээр дадлага хийж дуусгасан МСҮТ-ийн оюутан, төгсөгчдийн тоо (гэрээлэгч зорилтыг хэрэжүүлэгч агентлаг МБСҮТ-тэй хэлэлцэн тодорхойлно) Усны салбарын инженер, холбогдох мэргэжлээр их сургуульд суралцагч дадлага хийсэн оюутнуудын тоо Барилгачдын холбооны сертификаттай сургалтад Гэрээлэгчээс тэтгэлэгтэй суралцсан МСҮТ төгсөгчдийн тоо 		
С. Дэд бүтцийн төслийн нийгэм, жендэрийн эрсдэлийг үнэлж, хариу арга хэмээ авах				
<p>Зорилт 4.1 Эрүүл, аюулгүй ажиллах орчин бий болгох</p>	<ul style="list-style-type: none"> Гэрээлэгч нь хүйсээр ялгасан ариун цэврийн өрөө, амрах өрөө, хувцас солих өрөө зэргийг хангасан ажиллах зохистой орчин бүрдүүлсэн байдлыг хянах. Шаардлагатай бол хүүхэд хөхүүлэх, асрахад тохиромжтой хөхүүл эмэгтэйчүүдэд зориулсан өрөөг байгуулуулах 	<ul style="list-style-type: none"> Бүх ажлын талбайд хүйсийн ялгаатай онцлогт тохируулсан ариун цэвэр, амралт, хувцас солих өрөөг байгуулсан байна. 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Худалдан авах ажиллагааны баг</p>	<p>2021 - 2026</p>
<p>Зорилт 4.2</p>	<ul style="list-style-type: none"> Гэрээлэгчийн боловсруулсан бэлгийн дарамтыг хориглох, зөрчлийг 	<ul style="list-style-type: none"> Гэрээлэгч Бэлгийн дарамтын эсрэг бодлого, Зөрчлийг хянан шийдвэрлэх 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг</p>	<p>2021 - 2026</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
<p>Бэлгийн дарамтыг хориглож, зөрчлийг зохистой шийдвэрлэх</p>	<p>ажилчид иргэдээс нэр нууцлан мэдээлэх механизмыг агуулсан хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг хянаж санал өгөх</p> <ul style="list-style-type: none"> • МСК-ын ХХГХТ бодлого, МСС-гуудад зориулсан бэлгийн дарамтыг хориглох тухай удирдамжийн дагуу бүх ажилчдад зориулан ажлын талбарт ажил эхлүүлэхээс өмнө зохион байгууллах бэлгийн дарамтыг хориглох тухай сургалтын чанарыг хянаж ажиглах • Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай зааварчилгаанд бэлгийн дарамтыг хориглох тухай тусгасан эсэхийг болон хэрэгжилтийг хянах • ХМЗ нь гэрээлэгчийн ажилчид, олон нийтээс бэлгийн дарамтын тухай мэдүүлсэн бүх зөрчлийг а) цаг хугацаандаа шийдсэн эсэх б) бэлгийн дарамтын зөрчлийг хянан шийдвэрлэх төлөвлөгөөний дагуу ажилласан эсэх с) нууцлалыг хадгалан ажилласан эсэхэд хяналт хийх 	<p>төлөвлөгөөгөө МСК-ын ХХГХТ бодлого, МСС-гуудад зориулсан бэлгийн дарамтыг хориглох тухай удирдамж, холбогдох Монгол Улсын хуулийн дагуу, мэргэжлийн ТББ, төрийн байгууллагуудыг оролцуулан, хариу арга хэмжээ авахад олон талаас оролцох тодорхой журамтай боловсруулсан байна.</p> <ul style="list-style-type: none"> • Гэрээлэгчийн Бэлгийн дарамтын эсрэг бодлого, Зөрчлийг хянан шийдвэрлэх төлөвлөгөөгөө нь хохирогчийн аюулгүй байдал, нууцлалыг эрхэмлэж хэргийг хэрхэн шийдвэрлэх тухай тусгасан байна. • Ажилтан, туслан гүйцэтгэгчид бүгд ёс зүйн дүрэмд гарын үсэг зурсан байна. • Ажилтан, туслан гүйцэтгэгчид бүгд ажлын талбарт гарахаасаа өмнө бэлгийн дарамтаас сэргийлэх тухай сургалтад хамрагдсан байна. • Ажилчид, олон нийтээс бэлгийн дарамтын тухай мэдүүлсэн бүх зөрчлийг а) цаг хугацаанд нь б) бэлгийн дарамтын зөрчлийг хянан шийдвэрлэх төлөвлөгөөний дагуу с) нууцлалыг хадгалан шийдвэрлэсэн байна. • Зөрчлийг хянан шалгасны дараа барилгын талбар, ажилчдын байр, олон нийтийн орчинд бэлгийн дарамт 	<p>Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Худалдан авах ажиллагааны баг</p>	

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
		<p>үзүүлсэн этгээдийн эсрэг тохирох арга хэмжээ авсан байна.</p> <ul style="list-style-type: none"> •Бүлгийн ярилцлага, олон нийтээс авсан судалгаанд иргэд эергээр үнэлсэн байна. 		
<p>Зорилт 4.3 Хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ), албадан хөдөлмөр эрхлэлтийн талаар ойлголтыг нэмэгдүүлж, урьдчилан сэргийлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Гэрээлэгчийн ХХГХ-т хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг нь МСК-ын ХХГХ-тэй тэмцэх бодлого, гэрээний шаардлагад нийцүүлэх • Гэрээлэгчийн ХХГХ-т хариу арга хэмжээ авах төлөвлөгөөний хэрэгжилтэд ХМЗ-ийн зүгээс хяналт хийх • Гэрээлэгчээр хөдөлмөрийн харилцаа, ажиллах орчны талаар санал асуулгыг дотоод, гадаадын ажилчид, туслан гүйцэтэгч нараасаа жил бүр авахуулж, үр дүнг үйл ажиллагаанд тусгуулж байх 	<ul style="list-style-type: none"> •Ажилчид, туслан гүйцэтгэгчид 100% ёс зүйн дүрэмд гарын үсэг зурсан байна. •Барилгын ажлын явцад нэр нууцлан зөрчлийг мэдээлэх тогтолцоо үр дүнтэй хэрэгжсэн байна. •Гэрээлэгчийн ХХГХ-ийн хариу арга хэмжээ авах төлөвлөгөө нь МСК-ын ХХГХТ бодлого, холбогдох удирдамжад нийцсэн, БОННУ-нд тусгасан ХХГХ-ийн эрсдэлийн хариу арга хэмжээ, хуулийн байгууллагад хэзээ хандах, Улаанбаатар дахь ХХГХТ үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд болон төрийн мэргэжилтнүүдтэй хэрхэн хамтран ажиллах, холбогдох талуудын оролцоог тодорхой тусгасан байна. Төлөвлөгөө нь хохирогчийн аюулгүй байдал, нууцлалыг эн тэргүүнд анхаарч, тохиолдол бүрийг хэрхэн шийдвэрлэх тухай тусгасан байна. •ХХГХ-ийн талаарх мэдүүлсэн зөрчлийг 100% цаг хугацаандаа, 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Хуулийн багууд</p>	<p>2021 - 2026</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
		<p>хоширогчийн ашиг сонирхлыг эрхэмлэж, ХХГХ-т хариу арга хэмжээ авах төлөвлөгөөний дагуу шийдвэрлэсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> • Зөрчлийг мэдээлэх, менежментийн хариу арга хэмжээг үр дүнтэй боловсруулж, ХАБ, бусад холбогдох үйл ажиллагаанд ажилтан, гэрээлэгчид ямар арга хэмжээ авах тухай мэдээллийг өгдөг байна. • Олон нийттэй хийсэн уулзалтаар 100% ХХШХ-ийг үл тэвчих бодлого, Гэрээлэгчийн ХХГХ-ийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг мэдээлсэн байна. • ХХГХ үйлдсэн нь тогтоогдвол Монголын МСС нь ХХГХ-тэй тэмцэх бодлого, стандарт тендерийн баримт бичгийн дагуу залруулах арга хэмжээг авна. 		
<p>Зорилт 4.4 Барилгын салбарт хүүхдийг хөдөлмөрөөс урьчиглан сэргийлэх ойлголтыг өргөтгөх</p>	<ul style="list-style-type: none"> • Гэрээлэгчийн ХАБ-ын зааварчилгаа, хүүхдийн хөдөлмөрийг хориглох тухай ойлголт өгөх улирал тутмын үйл ажиллагааны чанарыг хянаж, ажиглах • Гэрээлэгчийг ажилтан, иргэдээс хүүхдийг хөдөлмөр эрхлүүлсэн зөрчлийн талаар нэр нууцлан мэдээлэх механизмтай болохыг дэмжих 	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн хөдөлмөрөөс ангид байж, ажлын талбарт нэг ч хүүхэд ажиллаагүй байна. • Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөр эрхлэлтийн талаарх зөрчил бүрийг цаг хугацаанд нь хүүхэд, гэр бүлийнх нь эрхийг хүндэтгэн шийдвэрлэсэн байна. • Хүүхдийн хөдөлмөрийн талаар зөрчлийн талаар нэр нууцлан 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Худалдан авах ажиллагааны баг</p>	<p>2021 - 2026</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
	<ul style="list-style-type: none"> • Гэрээлэгч барилгын ажлын улиралд хоёроос цөөнгүй удаа төсөл хэрэгжиж байгаа орон нутгийн иргэдэд хүүхдийн хөдөлмөрийн талаар сургалт, танилцуулгыг зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих. Ажил олгогчийн ажилчдын бүртгэлд ажилтны насыг тодорхойлох нотолгоог оруулах. • МХЕГ, ХМЗ-тэй хамтарсан үзлэгийг санаачлан хэрэгжүүлж байх 	<p>мэдээлэх тогтолцоог бий болгож, ажилтан, тухайн газар нутгийн иргэд үүнийг мэддэг байна.</p> <ul style="list-style-type: none"> • Бүх туслан гүйцэтгэгч, ажилчид хүүхдийн хөдөлмөрийн зөрчлийг илрүүлэх, мэдээлэх тухай ХАБ-ын сургалтад хамрагдсан байна. • Олон нийтийн ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагаагаар хүүхдийн хөдөлмөрийг илрүүлэх, мэдээлэх тухай мэдээллийг иргэдэд өгсөн байна. 		
<p>Зорилт 4.5 Гомдол шалгах үр дүнтэй тогтолцоо (ГШТГШТ)-той байх</p>	<ul style="list-style-type: none"> • Гэрээлэгч өөрийн ажилчид, олон нийтээс ирсэн гомдлыг барагдуулах механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хяналт хийх • Гомдол шалгах тогтолцооны талаар сургалтад дэмжлэг үзүүлж, хамтран зохион байгуулах • Монголын МСС-д ХХГХ, бэлгийн дарамт, гэр бүлийн хүчирхийллийн талаар гомдлыг хүлээн авах хүнийг томилуулж, МСК-ын бодлогыг мөрдөж ажиллах 	<ul style="list-style-type: none"> • Гэрээлэгч ГШТ-г байгуулж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг ХМЗ-өөр батлуулсан байна. • Монголын МСС дээр Гомдол хянан шийдвэрлэх хороо байгуулсан байна. • Бүх гэрээлэгч, ажилтнууд ГШТ-ны талаар зааварчилгаа өгөх сургалтад хамрагдсан байна. • ГШТ-оор шийдвэрлэсэн зөрчлийн тоо • Хохирогчийг хамгаалах, нууцлалыг хадгалах бодлогыг баталж нээлттэй мэдээлсэн байна. • Гомдол хянан шийдвэрлэх хороо байгуулсан байна. • Гэрээлэгчид, ажилчид 100% ГШТ-ны зааварчилгаа өгөх сургалтад суусан байна. 	<p>Хариуцах: НЖО, БОННУ хариуцсан баг Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Хуулийн багууд</p>	<p>2021 - 2026</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
		<ul style="list-style-type: none"> Монголын МСС, ХМЗ, Гэрээлэгчийн тогтоосон хугацаанд байгууллага дотор шийдвэрлэсэн гомдол 		
<p>Зорилт 4.6 Орон нутгийн иргэдийг (бэлгийн дарамт, ХХГХ, хүүхдийн хөдөлмөр зэрэг тусад нь авч үзээгүй бусад) нийгмийн хор нөлөөллөөс сэргийлж бууруулах</p>	<ul style="list-style-type: none"> Гэрээлэгчээр оршин суугчдыг аюулгүй, хамгаалалттай, ажилчид, туслан гүйцэтгэгчид, үйлчилгээ үзүүлэгчдийн зүгээс айлган сүрдүүлэх, хүндэтгэлгүй харьцах явдал гаргуулахгүй байлгах үүднээс Боловсрол, сургалт, олон нийтийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргуулах. МСК-ын бодлого, удирдамж, ОУСК-ын ГС-д нийцсэн ажилчдын ёс зүйн дүрмийн талаар олон нийтэд томтмол танилцуулах, сурталчлахад туслах. 	<ul style="list-style-type: none"> Боловсрол, сургалт, олон нийтийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж байгааг хянана. Төсөл хэрэгжиж байгаа орон нутгийн 5 хороо бүрийн эрэгтэй, эмэгтэй иргэдэд жил бүр 2 удаа олон нийтийн уулзалт, сургалтыг зохион байгуулсан байна. Уулзалтаар гомдол шалгах тогтолцооны талаар мэдээлэл хүргэсэн байна. Олон нийтээс авсан судалгаа, бүлгийн ярилцлагаар цуглуулсан төслийн талаар иргэдийн эерэг сэтгэгдэл 	<p>Хариуцах: НЖО, БОННУ хариуцсан баг Дэмжих: БЭҮШБТ, ХУДБТ, Хуулийн багууд</p>	<p>2021 - 2026</p>
<p>III. ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</p>				
<p>A. Зардал нөхөх үйл ажиллагаа</p>				
<p>Зорилт 5.1 Зардал нөхөх техникийн тусалцаа (ЗНТТ)-ны судалгаануудад нийгмийн болон иргэдийн худалдан авах чадавхын талаар асуудлыг судлан тусгасан байна</p>	<ul style="list-style-type: none"> ХНХЯ, НЗДТГ-тай ЗНТТ-ны судалгаануудад нийгмийн аюулгүй байдлын олон талын болон иргэдийн худалдан авах чадавхын талаарх асуудлуудыг авч үзэх талаар хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах. Усаар хангах үйлчилгээний төлбөр төлөх иргэдийн чадавхтай уялдуулсан бодлого, хэрэглэгчдэд тусалцаа үзүүлэх хөтөлбөрийн талаар шийдвэр гаргах Засгийн 	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчдийн төлбөрийн чадавхыг хэмжих асуултыг ЗНТТ-ны судалгааны арга үзүй, асуулгад тусгуулж, шаардлагатай дүн шинжилгээний төлөвлөгөөг боловсруулсан байна. Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийг боловсруулахад Засгийн газрын голлох оролцогчид зөвлөлдөж, арга зүйтэй танилцсан байна. 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: Усны салбарын Тогтвортой байдлыг хангах төслийн баг</p>	<p>2020 - 2022</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
	<p>газрын оролцогч талуудаас бүрдсэн ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулах.</p> <ul style="list-style-type: none"> Төлбөр төлөх эрмэлзлийн судалгааны асуулгыг боловсруулахад бүх төрлийн үйлчлүүлэгчийн төлөөллөөс төлбөрийн чадавх, нийгмийн асуудлыг тусгасан асуултыг тусгуулахаар техникийн туслалцаа үзүүлэх. ЗНТТ-ны судалгааны дүн шинжилгээнд жендэр, нийгэм-эдийн засгийн ангилан ялгасан мэдээдэл, дүгнэлтийг оруулах 	<ul style="list-style-type: none"> Төлбөр төлөх эрмэлзлийн судалгаанд хүйсийн тэнцвэртэй оролцогчидтой байх төлөвлөгөөг боловсруулсан байна. ЗНТТ-ны судалгааны тайлангуудад нийгэм-эдийн засгийн ангиллаар ялгасан мэдээллийн дүн шинжилгээг оруулсан, төлбөр төлөх чадавхтай холбоотой тусгайлан анхаарах хэрэглэгчдэд зориулсан зөвлөмжийг гаргасан байна. 		
<p>Зорилт 5.2 Тарифын өөрчлөлтөөс төлбөр төлөх чадавх, орлого багатай хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөллийг бууруулах</p>	<ul style="list-style-type: none"> ЗНТТ-ны судалгааны зөвлөмжид ЗНТ-г шинэчлэхдээ тарифын өөрчлөлтөөс төлбөр төлөх чадавх бага, орлого багатай өрхөд үзүүлэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулах, асуудлыг тусгуулах. Хэрэглэгчдэд туслах зорилтот хөтөлбөрийг боловсруулахад оролцогч талуудыг оролцуулах. 	<ul style="list-style-type: none"> Ус худалдан авах чадваргүй, эсвэл усны тарифыг нэмснээс эдийн засгийн хүндрэлтэй тулгарч болзошгүй хэрэглэгчдийг ЗНТТ-ны судалгаануудад тодруулсан байна. Бодлого боловсруулагчид Хэрэглэгчдэд туслах хөтөлбөрт усны салбарын хэрэглэгчдийн төлбөрийн чадавхыг үнэлж, харгалзсан байна. 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: Усны салбарын Тогтвортой байдлыг төслийн хангах баг</p>	<p>2020 - 2025</p>
<p>В. Гэр хорооллыг усаар хангах үйлчилгээ</p>				
<p>Зорилт 6.1 Ус түгээх байрыг автоматжуулах холбоотойгоор эмэгтэйчүүд ажилчдад үзүүлэх нөлөөллийг УСУГ-тай хэлэлцэн бууруулах</p>	<ul style="list-style-type: none"> УСУГ-аас Ус түгээх байрыг ухаалаг болгохтой холбоотойгоор Ус түгээгчдийн ажлын байрны өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулахад ОУСК-ын ГС-2: 	<ul style="list-style-type: none"> УСУГ-тай тогтмол уулзалт зохион байгуулсан, Ус түгээгчдийн ажлын байрны өөрчлөлтийн төлөвлөгөөг боловсруулахад УТБ-ны ажилчид, холбогдох төлөөлөл, оролцогчидтой зөвлөлдөж хөндсөн асуудлыг 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: Усны салбарын Тогтвортой байдлыг хангах төслийн баг</p>	<p>2021-2026</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
	<p>Ажил, хөдөлмөрлөх орчны шаардлагыг танилцуулах</p> <ul style="list-style-type: none"> Хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээний нөхцөлийг хангуулах үүднээс тогтмол уулзалт зохион байгуулж, Ус түгээгчдийн ажлын байрны өөрчлөлтийн төлөвлөгөөний төсөлд бичгээр санал өгөх. УСУГ-ын Ус түгээгчдийн ажлын байрны өөрчлөлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт хийж, шаардлагатай техникийн туслалцааг үзүүлэх 	<p>төлөвлөгөөнд тусган шийдвэрлэхэд анхаарсан байна.</p> <ul style="list-style-type: none"> УСУГ-аас УТБ-ны ажилчдын Цомхтолын төлөвлөгөөг боловсруулж баталсан байна. УСУГ-ын Ус түгээгчдийн ажлын байрны өөрчлөлтийн төлөвлөгөө ОУСК-ын ГС-2-ын дагуу хэрэгжиж, өөрчлөлтөөс ажилчдад учрах нийгэм, эдийн засгийн нөлөө буурсан байна. 		
С. Усны салбарын байгууллагын үйл ажиллагаа				
<p>Зорилт 7.1 Усны салбарын байгууллагуудтай түншлэх, хэрэглэгчдийн төлбөрийн чадавх, дата мэдээллийн удирдлагатай холбоотой туршлага солилцох хөтөлбөрт УСУГ-аас эрэгтэй, эмэгтэй аль аль төлөөллийг оролцуулах</p>	<ul style="list-style-type: none"> Туршлага солилцох хөтөлбөрийн удирдамжийг боловсруулах, оролцогчдыг хүйсийн тэнцвэртэй сонгуулах үүднээс МСК, УСТБ-ын багтай уулзалтуудад хамтран оролцох Хөтөлбөрийн зохицуулагчийн удирдамжид санал өгөх 	<ul style="list-style-type: none"> Туршлага солилцох хөтөлбөрт УСУГ-аас эрэгтэй, эмэгтэй хүйсийн тэнцвэртэй юм уу, УСУГ-аас эмэгтэй оролцогчдын тогтоох харьцаагаар оролцуулна. Туршлага солилцох хөтөлбөрт түншлэгч байгууллагаас эрэгтэй, эмэгтэй хүйсийн тэнцвэртэй юм уу, УСУГ-аас эмэгтэй оролцогчдын тогтоох харьцаагаар оролцуулна. УСУГ, түншлэгч байгууллагын хооронд харилцаа холбоо тогтоон хэрэглэгчдийн төлбөрийн чадавх, мэдээллийн сангийн асуудлаар уулзалтууд хийсэн байна. 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: Усны салбарын Тогтвортой байдлыг хангах төслийн баг</p>	<p>2021-2026</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
<p>Зорилт 7.2 УСУГ-ын туршлага солилцох хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> УСУГ-т Нийтийн аж ахуйн салбарт жендэрийн тэгш байдлыг бий болгох хөтөлбөрийн дэмжлэгтэй хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад оролцоход сонгогдох шалгуур, үйл явцын мэдээллийг орчуулах, оролцогчдын CV, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх зэргээр туслах УСУГ-ыг жендэрийн тэгш бус байдлыг үнэлж эмэгтэй ажилчдыг шууд нэмэгдүүлэх арга хэмжээ авахад туслах 	<ul style="list-style-type: none"> 2021, 2022 оны Нийтийн аж ахуйн салбарт жендэрийн тэгш байдлыг бий болгох хөтөлбөрийн дэмжлэгтэй хөтөлбөрт УСУГ-аас оролцогч сонгогдсон байх Нийтийн аж ахуйн салбарт жендэрийн тэгш байдлыг бий болгох хөтөлбөрийн Гүйцэтгэх удирдлагын хөтөлбөрт хамрагдсан УСУГ-ын оролцогчидтой үр бүтээлтэй хамтран ажиллаж, туршлага солилцох үйл ажиллагаанаас тус байгууллагын чадавх улам бэхжсэн байна. 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: Усны салбарын Тогтвортой байдлыг хангах баг</p>	<p>2021-2026</p>
<p>Зорилт 7.3 Хэрэглэгчийн мэдээллийн сан</p>				
<p><i>Энэхүү үйл ажиллагааны хүрээг бүрэн тодорхойлохоор НЖНТ-г үнэлэн шинэчлэхдээ тодорхой үйл ажиллалааг тусгах болно.</i></p>				
<p>D. Үйлдвэрийн хаягдал усны хяналт</p>				
<p>Зорилт 8.1</p>				
<p><i>Энэхүү дэд үйл ажиллагааны хүрээг бүрэн тодорхойлохоор НЖНТ-г үнэлэн шинэчлэхдээ тодорхой үйл ажиллалааг тусгах болно.</i></p>				
<p>E. Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх</p>				
<p>Зорилт 9.1 Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх (ОНДХӨОНДХӨ) үйл ажиллагааны загварт нийгэм жендэрийн оролцоог хангах агуулга, үйл ажиллагааг тусгах</p>	<ul style="list-style-type: none"> ОНДХӨ талаар судалгааны мэдээлэлд хүйсээр ялгасан байдлаар оруулах (ТТЭ-ийн судалгааны өмнө хүйсээр ялгасан мэдээлэлтэй байсан, судалгааны дараа бүлгийн ярилцлагаар мөн адил мэдээлэл цуглуулна.) Зорилтот бүлэг зэрэг усны хэрэглэгчдийн дунд өөрчлөлтөд нэрвэгдэх бүлгийн хандлагыг өөрчлөхийн тулд ОНДХӨ “Чадавх- 	<ul style="list-style-type: none"> ОНДХӨ-ийн загвар, үйл ажиллагааг ТТЭ, Бүлгийн ярилцлагад оролцогчдын хүйсээр ялгасан мэдээллийг багтаан боловсруулсан байна. ОНДХӨ-д ТТЭ, бүлгийн ярилцлагын мэдээллийг нийгэм, жендэрийн асуудлыг тодотгохын тулд “Чадавх-Боломж-Өөрчлөлт”-ийн арга зүйгээр дүн шинжилгээ хийсэн байна. 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: Усны салбарын Тогтвортой байдлыг төслийн хангах баг</p>	<p>2021 - 2026</p>

НЖО-НЫ ГОЛ ЗОРИЛТ	МОНГОЛЫН МСС-ГИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР	ХАРИУЦАХ МОНГОЛЫН МСС-ГИЙН БАГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
	<p>Боломж-Өөрчлөлт"-ийн арга зүйг ашиглах</p> <ul style="list-style-type: none"> ОНДХӨ үйл ажиллагаанд нийгмийн оролцоог хангахад анхаарах зүйлсийг тодруулахын тулд ТТЭ, бүлгийн ярилцлагын мэдээллийг үнэлэх 	<ul style="list-style-type: none"> ОНДХӨ-тэй холбоотой нийгэм, жендэрийн хүчин зүйлсийг ОНДХӨ үйл ажиллагааны загварыг боловсруулахад харгалзсан байна. 		
<p>Зорилт 9.2 Гэр хороолол, орон сууцны бүх оршин суугчдад олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх үйл ажиллагааны оновчтой зорилтыг дэвшүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> ОНДХӨ үйл ажиллагаа зохион байгуулахад орон сууц, гэр хорооллын оршин суугч, орлого үл харгалзан оролцож, үр ашгийг хүртэх бололцоог тусгуулах Холбогдох гол оролцогч нарыг оролцуулж саналыг авах уулзалтуудыг зохион байгуулах ОНДХӨ үйл ажиллагааны загварыг гаргахад Усны иргэншил, нийгмийн шударга ёс зэрэг нийгмийн чухал үзүүлэлтүүдийг тусгах 	<ul style="list-style-type: none"> ОНДХӨ үйл ажиллагааны загварт Улаанбаатарын орон сууц, гэр хорооллын оршин суугч, орлого үл харгалзан оролцож, үр ашгийг хүртэхээр тусгасан байх ОНДХӨ үйл ажиллагааг төлөвлөхөд бүх талуудыг оролцуулж, загварт усны салбарын нийгэм, жендэрийн агуулгыг багтаасан байна. ОНДХӨ үйл ажиллагааны үр дүнд олон нийтийн усны хангамжийн зардлын талаарх ойлголт нэмэгдэж усны зардлыг нөхөх тарифыг хэрэгжүүлэх, тогтвортой хадгалахад дэмжлэг болох. 	<p>Хариуцах: НЖО хариуцсан баг Дэмжих: Усны салбарын Тогтвортой байдлыг хангах төслийн баг</p>	<p>2021 - 2026</p>

VII. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ (БОННУ)-НИЙ БАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЗОХИЦУУЛАЛТ

A. БОННУ-НИЙ БАГИЙН ЕРӨНХИЙ ҮҮРЭГ

Монголын МСС-гийн БОННУ-ний баг нь Компакт гэрээний бүхий л үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээтэй холбоотой ажлыг зохицуулж, Монголын МСС-гийн Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС)-ийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Мөн Компакт гэрээний Талуудыг оролцуулах төлөвлөгөө (ТОТ)-г боловсруулж хэрэгжүүлэх, тендерийн баримт бичигт БОННУ болон барилгын талбайд байгаа иргэдийг шилжин суурьшуулах төлөвлөгөөг тусгуулах, БОННУ, БОНУ, БОНМТ-г Монгол Улсын Засгийн Газар/БОАЖЯ, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт, МСК-ын удирдамжид нийцүүлэх, батлуулах ажлыг хариуцна. БОННУ-ний баг нь хүрээлэн буй орчныг анхаарч үзэх урьдчилсан болзолт нөхцлийг хангахын тулд тухайн газар нутаг дахь иргэдийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө (НШТ)-г боловсруулж хэрэгжүүлэх юм. Монголын МСС-гийн төслийн баг, зочдод барилгын талбарт ажиллахад хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаагаар хангана.

B. МОНГОЛЫН МСС-ГИЙН БОННУ-НИЙ БАГИЙН БҮТЭЦ

Монголын МСС-гийн БОННУ-ний баг одоогоор гурван хүний бүрэлдхүүнтэй байна.

1. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хариуцсан захиарал нь байгаль орчин, нийгмийн үнэлгээний ажлыг нийтэд нь хариуцах, Монголын МСС-гийн бусад удирдлагатай Монголын МСС-гийн бүхий л үйл ажиллагаанд байгаль орчин нийгмийн нөлөөллийн асуудлыг хангуулахаар хамтран ажиллах, холбогдох эх үүсвэрийг хангуулах үүрэг хариуцлагатай.
2. Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн нь төслүүдэд БОНМС-ийн хэрэгжилтийг хангах, тогтмол хяналтыг хариуцна. Мөн Монгол Улсын Засгийн Газар/БОАЖЯ, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт, МСК-ын удирдамжид нийцүүлэн БОННУ, БОНУ хийхэд оролцох, БОНМТ, ХАБМТ-г боловсруулах, ажлын талбарт хэрэгжүүлэхэд гол үүргийг хүлээнэ.
3. Нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн нь Монгол Улс, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт, МСК-ын Байгаль орчны удирдамжид нийцүүлэн Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, газрыг чөлөөлөх үйл ажиллагааг хариуцна.

Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах, Хаягдал ус дахин боловсруулах, Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийг хариуцсан захирлууд нь БОНМС-ийг Монголын МСС-гийн БОННУ-ний баг, Зөвлөх, Гэрээлэгч нарыг дотоодын хууль тогтоомж, ОУСК-ын ГС, МСК-ын байгаль орчны удирдамжид нийцүүлсэн хэрэгжилтийг ханган ажиллахад холбох үүргийг хүлээнэ.

C. БОННУ-НИЙ БАГ, НЖО ХАНГАХ БАГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

БОННУ, НЖО хангах багууд нь талуудын оролцоог хангах төлөвлөгөө, БОННУ, БОНМТ-нд нэгдсэн саналыг авах, оролцогч талуудтай зөвлөлдөх, барилгын талбар дахь хяналтыг хамтран хийнэ. Багууд нь хөдөлмөрийн менежмент, гэрээлэгч ажилтан авах, худалдан авалт хийх, ХХГХ, бэлгийн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгийн асуудлыг авч

үзэхэд оролцогч талуудын оролцоог хангахад нягт хамтран ажиллана. Монголын МСС-гийн БОННУ, НЖО-ны багууд нь ХМЗ-ийн зохион байгуулснаар барилгын гэрээлэгч нарыг байгаль орчин, нийгмийн асуудлын талаар орон нутгийн иргэдтэй тогтмол холбоотой ажиллуулахыг хамтран хариуцна.

БОННУ-ний баг нь олон нийт, оролцогч талуудыг оролцуулах, байгаль орчны үнэлгээ, шинжилгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажилчдын түр байр, нүүлгэн шилжүүлэлт, соёлын өв, археологийн асуудлаар ажиллана. НЖО хангах баг нь ХХГХ, бэлгийн дарамт, хөдөлмөрлөх эрхийн зөрчил, гэрээлэгчийг (орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, гэрээлэгчид бараа үйлчилгээгээр хангуулах зэргээр) орон нутгийн хөгжлийг түлхүү дэмжих, Компакт гэрээний санхүүжилттэй барилгын ажилчдын 30-аас багагүй хувийг эмэгтэйчүүд байлгах гэсэн МСК-ын зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө бодит чармайлт гаргах зэрэг ажлыг түлхүү хариуцна.

D. БОННУ-НИЙ НӨӨЦ

БОННУ хариуцсан захирал (холбогдох бусад ажилтан) байгаль орчин, нийгмийн менежментийн бодлого журмыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гаргуулахаар Монголын МСС-гийн удирдлагуудтай ажиллана.

Үүнтэй адил ХМЗ нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үйл ажиллагааны (БОНМТ, ХАБМТ, НШТ, ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт, МСК-ын байгаль орчны удирдамжийн дагуу бусад төлөвлөгөө) төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх төсөв, ажиллах хүчнийг хангалттай хуваарилна.

Монголын МСС нь БОНМС-ийн дагуу бүх шаардлагатай байгаль орчин, жендэрийн зөвлөх зэрэг нийгмийн салбарын мэргэжилтэн зөвлөхийг томилно. Зөвлөхийн ажлын удирдамжид Монголын МСС-д байгаль орчин, нийгмийн нөлөөллийн асуудлыг цогцоор нь хангахад чиглэсэн судалгаа, зөвлөмжөөр хангахыг тусгана. Зөвлөхүүд нь Монголын МСС-гийн мэргэжилтнүүдэд төсөл хөрөнгө оруулалтын саналын байгаль орчны баримт бичгийг үнэлэх, шалгах хуудсаар нягтлах, ажлын талбар дээр очиж үзэх, ялангуяа байгаль орчин, нийгмийн зүгээс сөрөг нөлөөтэй бол байгаль орчны үнэлгээг хийхэд туслах бололцоотой байх ёстой.

VIII. ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ


Хяналт үнэлгээ (ХҮ)-ний хэсэгт Компакт гэрээний хөтөлбөрийн логик хүрээний аль хэсэгт НЖО-ны үйл ажиллагаа багтсан байгааг харуулав. Монголын МСС-гийн ХҮ-ний төлөвлөгөөнд тодорхой, хэмжигдэхүйц шалгуурыг НЖО-ны багийг оролцуулан нийт Монголын МСС-гийн хөтөлбөрийн багуудын оролцоотой боловсруулж, үнэлж, шинэчилсэн юм. Монголын МСС-гийн ХҮ-ний төлөвлөгөөнд НЖНТ-ний хэрэгжилтийг хангах үүднээс хүйс, орлого, нас, бусад ангиллаарх НЖО-ны шалгуурыг тусгасан болно.

A. КОМПАКТ ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТ

Компакт гэрээг ХҮ-ний төлөвлөгөөний Шалгуур Үзүүлэлтийн Гүйцэтгэлийн Хүснэгт (ШҮГХ)-ээр Компакт гэрээний үйл ажиллагааг системтэй хянаж, үйл ажиллагааг тогтмол тайлагнана. Хөтөлбөрийн логик хүрээгээр (i) хэрэгжилт; (ii) үр дүн; (iii) үр

нөлөө; (iv) зорилгын дөрвөн түвшний шалгуур бий. Хөтөлбөрийн логик хүрээний түвшин бүрийн шалгуурын зураглалаар төсөл боловсруулагч, менежерүүдэд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь ямар зорилгод хүрэхийг тодорхой харуулах юм. ХҮ-ний төлөвлөгөөнд жендэртэй холбоотой, хүйсээр ялгасан шалгуурыг тусгаж, ШҮГХ-д өрх дэх эмэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүд зэргээр ангилна. ХҮ-ний төлөвлөгөөний ШҮГХ-д НЖО-той холбоотой үйл ажиллагааг тайлагнана. Компакт гэрээний Хөтөлбөрийн логик хүрээ, ХҮ-ний төлөвлөгөөний НЖО-той холбоотой шалгуурыг дараах хүснэгтээр үзүүлэв. ХҮ төлөвлөгөөг үнэлж шинэчлэх явцад НЖО-той холбоотой нэмэлт шалгуурыг тодорхойлох болно.

Шалгуур		Шалгуурын түвшин	Тодорхойлолт	Ангилал	Хариуцах нэгж
1.	Зардал нөхөх тариф хэрэгждэг болсон байх	Үр нөлөө	УСУГ-ын үйл ажиллагаа, засвар, элэгдэл хорогдлын зардлын нөхөх тариф	Ангилалг үй	ХСУХАТАҮЗЗ
2.	Төлбөр төлөх эрмэлзлийн судалгаа хийсэн байх	Үр дүн	ХСУХАТАҮЗЗ-д ТТЭ-ийн судалгааг дуусгаж үр дүнг хүлээлгэн өгсөн огноо	Ангилалг үй	Монголын МСС-гийн УСТБ, НЖО-ны баг
3.	Хэрэглэгчдийн худалдан авах чадвартай холбоотой Засгийн газрын бодлого	Үр нөлөө	Дараа тодорхойлогдоно	Ангилалг үй	-
4.	Хэрэглэгчдэд үзүүлэх татаасыг тодорхойлсон байх	Үр нөлөө	Дараа тодорхойлогдоно	Ангилалг үй	-
5.	Ус хангамжийн үйлчилгээний хэрэглэгчдийн худалдан авах чадварыг харгалзсан байх	Үр нөлөө	Дараа тодорхойлогдоно	Ангилалг үй	-
6.	Хэрэглэгчдийн худалдан авах чадвар, хэрэглэгчдийг дэмжих судалгаа хийсэн байх	Үр дүн	Талуудад судалгааг дуусгаж үр дүнг хүлээлгэн өгсөн огноо	Ангилалг үй	Монголын МСС-гийн УСТБ, НЖО-ны баг
7.	Тарифын хувилбарын судалгаа хийсэн байх	Үр дүн	Усны тарифын хувилбаруудыг ХСУХАТАҮЗЗ санал болгож МСК хүлээн зөвшөөрсөн огноо	Ангилалг үй	Монголын МСС-гийн УСТБХТ, НЖО-ны баг
8.	Ажлын байраар хангасан эмэгтэйчүүд	Хэрэгжилт	Эмэгтэй ажилчдын хувь WS-5 (эмэгтэй ажилчид)-ыг WS-5 (нийт ажилчдад) харьцуулсан хувь	Хүйсээр	Монголын МСС-гийн НЖО, ГДУБЭҮШБ, ХУДБ ҮА-ны төслийн баг
9.	Ус, ариутгалын барилгын ажлын хөдөлмөр эрхлэлт	Хэрэгжилт	МСК-ын гэрээгээр дэд бүтцийн үйл ажиллагаанд хамрагдсан ажилчдын тоо.	Хүйсээр	Монголын МСС-гийн НЖО, ГДУБЭҮШБ, ХУДБҮА-ны төслийн баг



В. ГЭРЭЭЛЭГЧИЙН НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ОРОЛЦООГ ХАНГАЖ БУЙ ЭСЭХЭД ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Компакт гэрээний хяналт үнэлгээний төлөвлөгөөнд тусгасан шалгуураас гадна НЖО-ны баг гэрээлэгчийн нийгэм, жендэрийн оролцоог хангах шаадлагын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй юм. Дараах хүснэгтэд Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагааны БОНМТ-нд тусгасан дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх гэрээлэгч байгууллагуудын боловсруулах төлөвлөгөө, баримт бичгийг жагсаалтаар харуулав. Монголын МСС-гийн НЖО-ны баг дараах баримт бичгүүдийг боловсруулаад техникийн туслалцаа үзүүлж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тогтмол хяналтыг хийх юм.

ТАЙЛАН	ТАЙЛАГНАХ ХУГАЦАА	АГУУЛГА
Гэрээлэгчийн БОНМТ	Ажил эхлэх үеэр нэг удаа, гэрээ байгуулсан тухай мэдэгдсэнээс хойш 28 хоногийн дотор	<p>Гэрээлэгч нь ажлын талбайн байгаль орчин, нийгэм, жендэр, эрүүл мэнд, аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээг хийж, тухайн талбайд нөлөөлж буй нөлөөлөл, түүнийг бууруулах зохих арга хэмжээг тодорхойлно. Гэрээлэгч нь гэрээлэгчийн БОНМТ-ний нэг хэсэг болох шаардлагатай бүтэц, төлөвлөгөөг боловсруулна. Талбайн онцлог гэрээлэгчийн БОНМТ нь барилгын ажил эхлэхээс өмнө БХИ-ээс зөвшөөрөл авсан байх ёстой.</p> <p>Гэрээлэгчийн БОНМТ нь нийгмийн болон жендэрийн нөлөөлөл, эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор дараах нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн менежментийн төлөвлөгөө • Жендэр, нийгмийн оролцооны төлөвлөгөө • Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө • Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө • Барилгын талбар, түр барилга байгууламжийн менежментийн төлөвлөгөө
Сургалтын тайлан	<p>Нэг удаа ажил эхлэхээс өмнө</p> <p>Ажлыг хэрэгжүүлэх явцад сар бүр шинэчлэгддэг</p>	<p>Гэрээлэгч нь барилга угсралтын ажилд хөдөлмөр эрхлэхээс өмнө батлагдсан төлөвлөгөөний дагуу шаардлагатай сургалт, чиг баримжаа олгох талаар мэдээллийг нэгтгэн тайлагнах болно.</p> <p>Төлөвлөгөөний сэдэв, арга хэрэгслүүдийг сар бүр тайлагнах ёстой. Гэрээлэгч нь Сургалтын тайлангийн хуулбарыг БХИ өгөх болно. Гүйцэтгэгч нь сар бүрийн ажлын явцын тайлан дахь ажлыг хэрэгжүүлэх явцад сургалт, чиг баримжаа олгох үйл ажиллагааны талаар сар бүр мэдээлж байх болно.</p>
Байгаль орчин, нийгэм, жендэр, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын тайлан	Ажлыг хэрэгжүүлэх явцад долоо хоног бүр	<p>Гэрээлэгч нь байгаль орчин, нийгэм, жендэр, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт шалгалт хийж, тайлагнах болно.</p> <p>Долоо хоног бүр, тус тайлангийн хуулбарыг гэрээний хугацаанд БХИ-д сар бүр өгөх болно.</p> <p>Нийгэм, жендэрийн тайлан нь дараах чиглэлээр гарч буй асуудлуудыг багтаасан болно.</p> <ul style="list-style-type: none"> • Ажилд авах төлөвлөгөө, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн хөдөлмөрийг хориглох • Ажилчдын ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх, үр дүн

		<ul style="list-style-type: none"> • Жендэртэй холбоотой гомдол, хяналт • Ажилчдын ёс зүй, хүйс, нийгмийн оролцоо, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, эрүүл ахуй, боловсрол, соёлын мэдлэг, ажилчдын санал хүсэлтийн талаар сургалт явуулах
<p>Явцын тайлан</p>	<p>Ажлыг хэрэгжүүлэх явцад сар бүр</p>	<p>Эдгээр тайлангийн хураангуй (байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг багтаасан, зөвшөөрөл, авсан гэрээ гэх мэт) -ийг сар бүр ирүүлэх явцын тайланд оруулах болно</p> <p>Хянан баталгаажуулахын тулд БХИ-т хандана уу. Сар бүрийн явцын тайланд дараах мэдээлэл багтсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Сургалт, чиг баримжаа олгох үйл ажиллагаа • Байгаль орчин, нийгэм, жендэр, эрүүл ахуй байдлын менежментийн арга хэмжээ/авсан арга хэмжээ, үүнд орон нутгийн болон үндэсний эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл хүссэн зөвшөөрөл • Байгууллагын уулзалтын үеэр байгаль орчин, нийгэм, хүйс, эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн талаар гаргасан ажиглалт, санаа зовоосон асуудал ба/эсвэл гаргасан шийдвэр • Байгаль орчин, нийгэм, хүйс, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудалтай холбоотой асуудлууд (саатал, осол, хохирол, зардлын үр дагавар, онцгой байдал гэх мэт) • Гүйцэтгэгчийн дотоод гомдлыг шийдвэрлэх механизмын үр дүнг судлах • Гүйцэтгэгч болон/эсвэл байгаль орчин, нийгэм, хүйс, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагын талаарх энэхүү БОНХЭАХАБ болон техникийн үзүүлэлтүүдийг дагаж мөрдөөгүй байна. • туслан гүйцэтгэгч • Байгаль орчин, нийгэм, хүйс, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагуудтай холбоотой таамаглал, нөхцөл, хэмжүүр, дизайн, бодит ажлын өөрчлөлт. • Түүх, соёл, археологийн олдворуудыг олох боломжтой • Болсон явдлын мөрдөн байцаалт • Гэрээний шаардлагыг дагаж мөрдөөгүй байдлыг арилгах, багасгахын тулд тодорхойлсон арга хэмжээ ба/эсвэл залруулах арга хэмжээний төлөв байдал (түүний дотор засч залруулах арга хэмжээ) болон түүний үр нөлөөг хянах. <p>Тайлант хугацаанд хийсэн талуудын оролцоо, зөвлөлдөх үйл ажиллагаа, гомдлыг бүртгэж шийдвэрлэсэн</p>

IX. ТАЛУУДЫН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ОРОЛЦОГЧ ТАЛ	ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР	ЗӨВЛӨЛД ӨХ	МЭДЭЭЛЭ Х	ХОЛБОО БАРИХ ХАЯГ
КОМПАКТ ГЭРЭЭНИЙ НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА				
НЗДТГ	<ul style="list-style-type: none"> Дэд бүтцийн төслүүдийн зураг төсөл боловсруулах, барилга, угсралт, ашиглалт засвар үйлчилгээний үе шатуудад БОНМТ-г хэрэгжүүлэх Нийгэм, жендэрийн оролцооны тухай амжилтын түүх, сайн жишээг түгээх 	+		+976 11 320461
Сонгинохайрхан дүүрэг, хорооны ЗДТГ	<ul style="list-style-type: none"> Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, НЖО-ны эрсдэлийн чиглэлээр иргэд, олон нийтийг оролцуулан зөвлөлдөх. Нийгэм, жендэрийн оролцооны тухай амжилтын түүх, сайн жишээг түгээх 	+	+	+976 70173203
АХБ	<ul style="list-style-type: none"> Дэд бүтцийн үйл ажиллагааны нийгэм, жендэрийн оролцооны чиглэлээрх туршлага, мэдээлэл солилцох Нийгэм, жендэрийн оролцооны тухай амжилтын түүх, сайн жишээг түгээх. Ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, НЖО-ны эрсдэлийн чиглэлээр зөвлөлдөх 	+		+976 11 313440 +976 99022831
ОРОН НУТАГТ АЖИЛ ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ				
БХБЯ	<ul style="list-style-type: none"> Дэд бүтцийн төслүүдэд нийгмийн төрөл бүрийн бүлгүүдийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломж, чадварыг нэмэгдүүлэх Эрх тэгш хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөх эрхлэх бололцоог олгохыг дэмжих 	+		+976 76003333 /1124, 1126/ info@mcud.gov.mn
ТМБС, МБСУМАЗТ	<ul style="list-style-type: none"> ТБМС-ийн оюуан, төгсөгчдийг, ялангуяа эмэгтэйчүүдийг дадлагажуулах, ажиллах бололцоог нэмэгдүүлэхээр түншлэх Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ур чадварыг өвлүүлэхэд шударга, ялгаваргүй, эрх тэгш хамтын ажиллагааг дэмжих 	+	+	+976 97170051 +976 99108318

ОРОЛЦОГЧ ТАЛ	ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР	ЗӨВЛӨЛД ӨХ	МЭДЭЭЛЭ Х	ХОЛБОО БАРИХ ХАЯГ
Монголын Барилгачдын Нэгдсэн Холбоо	<ul style="list-style-type: none"> ТБМС-ийн оюутан, төгсөгчдийг, ялангуяа эмэгтэйчүүдийг дадлагажуулах, ажиллах бололцоог нэмэгдүүлэхээр түншлэх Хүний нөөцийн мэдээллийн санг байгуулах 	+		+976 11 318685 mongolian.builders.association@gmail.com
Сонгинохайрхан дүүрэг, хорооны ЗДТГ	<ul style="list-style-type: none"> Ажилгүйчүүдийг бүртгэх Ажил олгох, гэрээлэгчтэй холбох Зорилтот бүлгийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх 	+	+	+976 70173203
Монголын барилгын үндэсний ассоциаци	<ul style="list-style-type: none"> ТБМС-ийн оюуан, төгсөгчдийг, ялангуяа эмэгтэйчүүдийг дадлагажуулах, ажиллах бололцоог нэмэгдүүлэхээр түншлэх Хүний нөөцийн мэдээллийн санг байгуулах 	+		+ 976 7016 5055, 7018 5055, 7011 1515, +976 9444 4173 info@mnca.mn http://www.mnca.mn/
Төсөлд хамрагдах бүсийн оршин суугчид	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт, орон нутгаас худалдан авах чиглэлээр хамтран ажиллах мэдээлэл түгээх Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар хэлэлцэх 	+	+	
НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ЭРСДЭЛИЙГ ИЛРҮҮЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ				
Сонгинохайрхан дүүрэг, хорооны ЗДТГ	<ul style="list-style-type: none"> Бэлгийн дарамт, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүн худалдаалах, хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн мөлжлөг зэрэг эрсдэлийг илрүүлэх, хариу арга хэмжээ авахад хамтран ажиллах. Гомдол шалгах толтолцоог бий болгох гомдлыг хэлэлцэх талаар зөвлөлдөх 	+	+	+976 70173203
МХЕГ	<ul style="list-style-type: none"> Ажлын талбар дээрх хяналт, үзлэг ХАБ сургалт, ажлын байрны халдвар хамгаалал 	+		+976 1800-1286 info@inspection.gov.mn
ХЭҮК	<ul style="list-style-type: none"> Ажлын байран дахь бэлгийн дарамтын талаар сургалт Холбогдох зөрчил хэрэгт (утсаар) зөвлөгөө өгөх, шалгах 	+	+	+976 7000 0222 info@nhrcm.gov.mn
Өөрчлөлтийн төлөө эмэгтэйчүүд	<ul style="list-style-type: none"> Ажлын байран дахь бэлгийн дарамтын талаар сургалт Холбогдох зөрчил хэрэгт (утсаар) зөвлөгөө өгөх 	+		+976 70112090
ГИХА	<ul style="list-style-type: none"> Гадаад ажилчдын виза, оршин суух үнэмлэх Хүн худалдаалах гэмт хэргийн талаар сургалт, танилцуулга 	+	+	+976 75751882 info@immigration.gov.mn
Цагдаагийн газар	<ul style="list-style-type: none"> Хэрэг мэдүүлэх, мөрдөн шалгах 	+	+	+976 70191000

ОРОЛЦОГЧ ТАЛ	ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР	ЗӨВЛӨЛД ӨХ	МЭДЭЭЛЭ Х	ХОЛБОО БАРИХ ХАЯГ
	<ul style="list-style-type: none"> Хүн худалдаалах гэмт хэргийн талаар сургалт, танилцуулга 			info@police.gov.mn
ГБХЗХГ	<ul style="list-style-type: none"> Ажлын талбар дээрх хяналт, үзлэг Хөдөлмөр эрхлэлт, хүүхдийн хөдөлмөрийг хориглох сургалт Хүүхэд хамгааллын асуудлаар зөвлөгөө авах 	+	+	+976 62262109 info@fcy.gov.mn
Төсөлд хамрагдах бүсийн оршин суугчид	<ul style="list-style-type: none"> НЖО-ны эрсдэлийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах талаар мэдээлэл хүргэх Эрсдэлийг асуудлыг оролцуулах 	+	+	
УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ				
ХНХМ	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчдэд туслах төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулах. Төлбөр төлөх чадавхыг үнэлэх талаар зөвлөлдөх 	+	+	+976 51-261553 info@mlsp.gov.mn
СЯ	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчдэд туслах төлөвлөгөө, хэрэгжилтийг зөвлөлдөх 	+	+	TBD
НИЙСЛЭЛИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА	<ul style="list-style-type: none"> Хэрэглэгчдэд туслах төлөвлөгөө, хэрэгжилтийг зөвлөлдөх 	+	+	TBD
Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар	<ul style="list-style-type: none"> Мэдээлэл, төлөвлөлт, зохион байгуулалтын талаар зөвлөлдөх 	+	+	TBD
Хотын инженерийн байгууламжийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> Мэдээлэл, төлөвлөлт, зохион байгуулалтын талаар зөвлөлдөх 	+	+	TBD
Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл	<ul style="list-style-type: none"> Зардал нөхөх дэд үйл ажиллагааны түншлэл ЗНТ хэрэгжүүлэх 	+	+	+976 7014-7447 info@wsrc.mn
ҮСХ	<ul style="list-style-type: none"> ТТЭ-ийн судалгааны мэдээлэл цуглуулах ТТЭ-ийн судалгааны тайланг зөвлөлдөх 	+	+	+976 51-263964
УСУГ	<ul style="list-style-type: none"> УСУГ-ын УТБ-ны ажилтны талаар мэдээлэл Ажлын байрны өөрчлөлттэй холбоотой сургалт Зардал нөхөх техникийн судалгаа хийхэд зөвлөлдөх 	+	+	+976 7015-7031 usug1959@gmail.com usugub@yahoo.com usug@usug.ub.gov.mn

ОРОЛЦОГЧ ТАЛ	ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР	ЗӨВЛӨЛД ӨХ	МЭДЭЭЛЭ Х	ХОЛБОО БАРИХ ХАЯГ
ОСНААУГ	<ul style="list-style-type: none"> • Зардал нөхөх техникийн судалгаа хийхэд зөвлөлдөх 	+	+	+976 70005454 +976 70111761
Эрчим хүчний зохицуулах хороо	<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний хэрэглэгчдэд туслах үйлчилгээний сургамж 		+	+ 976-11-320126 info@erc.gov.mn
USAID	<ul style="list-style-type: none"> • Салбарын туршлага солилцох төсөл хөтөлбөө 		+	+202 712-4728 mglees@usaid.gov Kirsten.Klopper@tetrattech.com
Усны нөөцийн бүлэг 2030	<ul style="list-style-type: none"> • Тарифын судалгааны мэдээлэл солилцох 	+	+	obazargochoo@worldbank.org

X. ТӨСВИЙН ХУВААРИЛАЛТ

Зардлын утга		Төсөв
1.	Сургалт, хэлэлцүүлэг	3,000 ам.доллар
2.	Хяналт, ажлын талбарын хяналт	(дараа тодохойлно)
3.	НЖО-ны сайн туршлага, амжилтын түүхийн тухай хэвлэл	15,000 ам.доллар
4.	Компакт дахь НЖО-ны үйл ажиллагааны хаалтын тайлан	20,000 ам.доллар
5.	Хөдөлмөр эрхлэлт, ажлын орчны талаарх судалгаа	60,000 ам.доллар
6.	НЖО-той холбоотой эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах тухай танилцуулга хэвлэл, видео	25,000 ам.доллар

XI. НИЙГЭМ ЖЕНДЭРИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААР ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ

Монголын МСС нь Компакт гэрээний зорилтыг бүх оролцогч тал, олон нийтэд цаг тухайд нь үнэн зөв хүргэж, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, тусламж дэмжлэгийг авах зорилгоор Олон нийттэй харилцах стратеги төлөвлөгөөг боловсруулж байна. Тус зорилтод хүрэхдээ Монголын МСС-гийн Мэдээлэл харилцааны стратеги төлөвлөгөөний хүрээнд хийж гүйцэтгэсэн судалгаанд суурилсан, мэдээлэл хүлээн авах бүлгээ тодорхойлж, тохиромжтой мэдээлэл, уриалга, кампанит ажлыг зорилтот бүлэгт, ялангуяа эрх нь хөндөгдөх бүлэгт хүргэх юм. Ингэснээр Компакт гэрээний бүхий л шатанд НЖО-г хангахын ашиг тусыг таниулах ач холбогдолтой. НЖОНТ-нд оролцогч бүх талд НЖО-г хангах талаар мэдээллийг хүргэх зорилгоор сурталчилгааны материал, видео хийх төсвийг тусгасан болно.

Иймээс Монголын МСС-гийн Мэдээлэл харилцааны стратеги төлөвлөгөөг боловсруулах, үнэлэхдээ НЖО-г хангах талаар тусгуулахын тулд НЖО-ны багтай зөвлөлдөх юм. Монголын МСС-гийн Олон нийттэй харилцах баг нь НЖО-ны багийн боловсруулсан сурталчилгааны бүтээгдхүүнүүдийг Стратеги төлөвлөгөөнд тусгасан эсэхийг үнэлж байна. НЖОНТ-ний хэрэгжилтийн сургамжид тулгуурлан Мэдээлэл харилцааны стратеги төлөвлөгөөг боловсруулах явцад тусгайлан санал оруулна.

XII. ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ, ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦААНЫ ХЭРЭГЦЭЭ

Тус НЖНТ-ний 2 дугаар хувилбарыг боловруулах явцад Монголын МСС-гийн нийгэм, жендэрийн оролцооны талаарх чадавхыг албан ёсоор үнэлээгүй болно. Гэхдээ НЖНТ-ний 1,2 дугаар хувилбарыг боловсруулахдаа НЖО-ны баг Монголын МСС-гийн ихэнх багтай хэлэлцсэн. Уулзалт хэлэлцүүлгүүдээс Монголын МСС-гийн бусад баг НЖНТ-нд тусгасан шаардлагуудыг хэрэгжүүлэхэд НЖО-ны багтай хамтран ажиллах эрмэлзэл дүүрэн байгаагаа илэрхийлж, цаашид өөрсдийн ажлын хүрээнд НЖО-ны талаар ойлголтоо нэмэгдүүлж, НЖНТ-ний үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх үүрэг хариуцлагаа улам бататгах хэрэгцээ байгааг онцолсон юм. Монголын МСС-гийн нийт ажилтнуудын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх үүднээс Компакт гэрээг хэрэгжүүлэх явцдаа дараах үйл ажиллагааг төлөвлөж байна. Үүнд:

- Монголын МСС, ХМЗ багийн бүх ажилтанд НЖНТ-нд тусгасан шаардлагуудыг танилцуулах;
- Монголын МСС-гийн нийт ажилтнуудын НЖО-ны чадавхийг санал асуулгаар үнэлж, үр дүнд туссан асуудлын чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөөг тусад нь боловсруулах;
- Хүн худалдаалахтай тэмцэх, бэлгийн дарамт, хүүхдийн хөдөлмөр, хөдөлмөрийн мөлжлөг зэрэг НЖО-нд хамаарах гол сэдвүүдээр сургалт зохион байгуулах;
- Монголын МСС-гийн НЖО-г хангах зорилт, төрөл бүрийн бүлгүүдэд тохиромжтой хэлбэрээр боловсруулсан товч танилцуулга боловсруулах;
- Монголын МСС дотооддоо НЖО-г хангасан жишээ, сургамжийг таниулж байх.

ХШ. НЖНТ-НИЙ ҮНЭЛГЭЭ, ШИНЭЧЛЭХ ҮЙЛ ЯВЦ

НЖНТ нь жендэр нийгмийн оролцоог хангах удирдамж, зорилтоо хангаж байгаа эсэхийг жил бүр үнэлнэ. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад шинэ боломж, саад бэрхшээл, орхигдуулсан зүйлс, төсвийг тодотгох шаардлага үүсч байгаа эсэхийг жилийн үнэлгээнд тусгахын зэрэгцээ төлөвлөсөн зорилтдоо хүрч байгаа эсэхийг улирал тутам хянан илэрсэн асуудлыг авч үзэх юм. Дараах хуваариар үнэлгээг хийнэ. Үүнд:

- Үнэлгээ шинэчлэл 1: 2022 оны зун
- Үнэлгээ шинэчлэл 2: 2024 оны зун
- НЖО-ны эцсийн тайлан: 2026 оны 2 дугаар сар

ХАВСРАЛТ I: БЭЛГИЙН ДАРАМТ, ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ГЭРЭЭЛЭГЧИД ТАВИХ НААД ЗАХЫН ШААРДЛАГА

A. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ

1. МСК-ЫН СТАНДАРТ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ НЬ (ЖИЖИГ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ 67, ЖИЖИГ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ 6.16 ДУГААР ЗҮЙЛ)

МСК нь АНУ-ын Засгийн газрын байгууллагуудтай адил Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлогоороо хүн худалдаалах гэмт хэргийг үл тэвчих бодлогыг баримталдаг. Бодлогыг хэрэгжүүлэхдээ:

Нэр томъёоны тодорхойлолт. Нэгдсэн ойлголт, хэрэгжилттэй байлгахын тулд дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

- i. МСК-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлогоор “албадлага”, “бэлгийн мөлжлөг”, “өр зээлээр барьцаалах”, “ажил олгогч хүчээр хөдөлмөрлүүлэх”, “хуурч мэхлэх”, “албадан хөдөлмөрлүүлэх буюу үйлчлүүлэх”, “биеийг үнэлүүлэхээр худалдах” гэх мэт нэр томъёо дараах заалтад тугагдсан болно;
- ii. “Хүн худалдаалах” гэдэг нь (а) 18 нас хүрээгүй хүнийг хүчээр, хуурч мэхлэн эсвэл албадан биеийг үнэлүүлж, бэлгийн мөлжлөг хийх юм уу, ийм үйлдэл хийхэд хүргэх (б) албадан үйлчлүүлэх, зарцлах, өр зээлээр барьцаалах, боолчлох зорилгоор хүчээр, хуурч мэхлэн эсвэл албадан ажилд оруулах, орогнуулах, тээвэрлэх, ажил үйлчилгээгээр хангах юм уу, оруулах;

Хориг. Гэрээлэгч, туслан гүйцэтгэгч, зөвлөх болон бусад хамаарах хүмүүс нь МСК-ын санхүүжилтээр аливаа гэрээг хэрэгжүүлэхдээ Хүн худалдаалах гэмт хэрэгт хэрхэвч холбогдох ёсгүй бөгөөд зүй бусаар ажилд авах, ажилд оруулсны шан хураамж авах, ажилтны бичиг баримтыг устгах, нуух, хурааж авах, өгөхгүй байх зэрэг хүн худалдаалах гэмт хэргийг хориглосон АНУ-ын холбогдох хууль, дагалдах журмыг заавал мөрдөх шаардлагатай.

Гэрээлэгчийн үүрэг.

- i. Гэрээлэгч (эсвэл туслан гүйцэтгэгч) нь:
 - a. МСК-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, тус бодлогыг ажилтан зөрчвөл ямар хариуцлага хүлээхийг ажилтнууддаа мэдэгдэнэ. Хариу арга хэмжээ нь гэрээ цуцлах, цалин урамшууллыг бууруулах, ажлаас халах зэрэг байж болно;
 - b. Тус бодлогод заасан хоригийг зөрчсөн хувь хүн, туслан гүйцэтгэгчийг гэрээ цуцлах хүртэл тохирох арга хэмжээ авна.
- ii. Гэрээлэгч бүр нь:
 - a. Гэрээний хугацаанд тус бодлогоор хориглосон хүн худалдаалах аливаа гэмт хэрэгт холбогдоогүй, үйлдээгүй, ийм нөхцөлийг бүрдүүлээгүй болохоо нотолно;
 - b. Алба хаагч, туслан гүйцэтгэгч, гэрээт зөвлөх, холбогдох ажилтнууддаа Хүн худалдаалах болон холбогдох аливаа үйлдлийг үл тэвчихийг баталгаажуулах;

- c. Ийм үйлдэлд холбогдвол гэрээ, ажил эрхлэлтийг зогсоохыг хүлээн зөвшөөрөх.
- iii. Дараах тохиолдолд Гэрээлэгч, туслан гүйцэтгэгч нь Монголын МСС-д 24 цагийн дотор мэдэгдэнэ. Үүнд:
 - a. Аливаа эх сурвалжаас (үүнд хууль сахиулах байгууллага орно) гэрээлэгчийн ажилтан, туслан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн ажилтан нь тус бодлогыг зөрчсөн үйлдэлд холбогдсон тухай аливаа мэдээлэл;
 - b. Холбогдсон ажилтан, туслан гүйцэтгэгч, гэрээт зөвлөх, туслан гүйцэтгэгчийн ажилтанд бодлогод шаардсан хариу арга хэмжээ.

1. АЖИЛТАНД МЭДЭГДЭЛ ӨГӨХ

Ажилтныг ажлын талбарт гарахаас өмнө Гэрээлэгч нь МСК-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, байгууллагын хүн худалдаалахтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулсан мэдэгдлийг ажилтанд эх хэлээр нь бичгээр өгнө. Тус мэдэгдэлд дараах агуулгыг багтаасан байх шаардлагатай. Үүнд:

1. МСК-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, дотоодын хууль тогтоомжоор хүн худалдаалах гэмт хэрэгт юу багтдаг тухай тодорхойлолт;
2. МСК-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод тусгасан хоригууд;
3. Гэрээний ерөнхий нөхцөлийн 67 дугаар зүйлд тусгасан гэрээлэгчийн хүн худалдаалахтай тэмцэх үүрэг;
4. Хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтэй тохиолдлыг хэнд хэрхэн мэдүүлэх, Монголын МСС, гэрээлэгч нь ийм тохиолдол нь нотлогдоход хариу арга хэмжээ авах.

Ажилтан нь тус мэдэгдлийг хүлээн авсан болохоо гэрчилж гарын үсэг зурах юм уу, бусад нотолгоо гаргаж, Гэрээлэгч нь тус гэрчилгээг бүртгэн хадгална.

2. ЧИГЛҮҮЛЭХ СУРГАЛТ

Гэрээлэгч байгууллагын хүн худалдаалахтай тэмцэх тухай сургалтын хөтөлбөр нь наанадаж дараах агуулгыг багтаасан байх шаардлагатай. Үүнд:

1. МСК-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, дотоодын хууль тогтоомжоор хүн худалдаалах гэмт хэрэгт юу багтдаг тухай тодорхойлолт;
2. Хүн худалдаалах ямар төрлийн гэмт хэрэг тухайн улсад тохиолддог жишээ, БОННҮҮ-нд тодорхойлсон төсөлд хамаарах эрсдэлүүд;
3. Ажлын талбар дээр хүн худалдаалах гэмт хэрэгт холбогдож болох тохиолдлууд, БОННҮҮ, байвал бусад бичиг баримтад тусгасан эрсдэлүүдийг хэрвээ өмнө тодорхойлсон бол;
4. МСК-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын тайлбар;
5. Гэрээний ерөнхий нөхцөлийн 67 дугаар зүйлд тусгасан гэрээлэгчийн хүн худалдаалахтай тэмцэх үүрэг;
6. Гэрээлэгчийн хүн худалдаалахтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөө;
7. Хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтэй тохиолдлыг Гэрээлэгч, Монголын МСС, болон тохирох хараат бус/гуравдагч тал нэрээ нууцлан мэдээлэх (гомдол мэдүүлэх утас, нэрээ нууцлан санал, гомдол илгээх хайрцаг гэх мэт) механизмын талаар мэдээлэл, заавар;
8. Ажилтан, орон нутгийн иргэд, ТББ, бусад холбогдох талаас ирсэн Хүн худалдаалах гэмт хэргийн тохиолдлын талаар мэдүүлэг, шалгах шаардлагатай хүн худалдаалах гэмт хэрэг байж болзошгүй тохиолдлыг Монголын МСС эсвэл

хариуцах байгууллагад мэдээлэх Гэрээлэгчийн томилсон хүний нэр, холбоо барих хаяг;

9. БОНМТ-өөр хийх шаардлагатай Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх аливаа үйл ажиллагаанууд;
10. Ажилтнуудын асуултад хариулах цагийг хангалттай байлгах.

Гэрээлэгч нь ажилтанг ажлын талбарт ажиллаж эхэлснээс хойш нэг сарын дотор хүн худалдаалахтай тэмцэх тухай сургалтад хамруулсан байх шаардлагатай.

Гэрээлэгчид 1) ажилтнаа хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон орон нутгийн байгууллага, төрийн байгууллагуудын мэдээллээр хангаж 2) холбогдох сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалтыг зохион байгуулах мэргэшсэн байгууллагатай гэрээлэн ажиллах юм уу, хамтран ажиллахыг төлөвлүүштэй.

3. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ШААРДЛАГЫН ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

Гэрээлэгч нь ажилтан бүрт дараах мэдээллийг агуулсан хяналт (бүртгэл)-ыг хийж байх шаардлагатай. Үүнд:

1. Ажилд орсон болон ажлын талбарт ажиллаж эхэлсэн огноо;
2. МСК-ын Хүн худалдаалахтай тэмцэх бодлого, байгууллагын хүн худалдаалахтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг ажилтны өөрийн хэлээр (Монгол, Казак гэх мэт) бичгээр хүлээлгэн өгсөн огноо;
3. Ажилтан хүн худалдаалахтай тэмцэх тухай танилцуулах сургалтад хамрагдсан огноо;
4. Ажилтан хүн худалдаалахтай тэмцэхтэй холбоотой аливаа хурал, уулзалтад хамрагдсан огноо.

Инженерийн зөвлөх байгууллагатай гэрээ байгуулсан гэрээлэгч бүрийн тогтмол тайланд дээрх үйл ажиллагааны хяналтын тайланг хавсаргаж тайландаа төсөлд хамрагдсан нийт ажиллагсдын тоо, хүн худалдаалахтай тэмцэх тухай сургалтад хамрагдсан болон хамрагдаагүй ажилтны тоо, өмнөх тайлангийн хугацаанаас хойш шинээр ажилд орсон хүний тоо тусгасан байх шаардлагатай.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай танилцуулга сургалтын хяналтын бүртгэлийг Бэлгийн дарамтыг хориглох шаардлагын хэрэгжилтийн хяналт, бүх шаардлагатай мэдээллийг агуулсан бусад хяналтийн бүртгэл, тайлантай хамтатган хийж болно.

В. БЭЛГИЙН ДАРАМТЫГ ХОРИГЛОХ НЬ

1. МСК-ЫН СТАНДАРТ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ: БЭЛГИЙН ДАРАМТЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ (ЖИЖИГ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ 75.1, ЖИЖИГ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭНИЙ 6.17 ДУГААР ЗҮЙЛ)

Компакт гэрээний ашиг шим хүртэгч, түншлэгч, хамтрагч, Монголын МСС-гийн ажилтан, Монголын МСС-гийн зөвлөх, МСК-ын ажилтан, МСК-ын зөвлөхөд зааварчилсны дагуу бүх холбогдох гэрээлэгч, туслан гүйцэтгэгч нар нь бэлгийн дарамт үзүүлсэн аливаа хандлагаас татгалзаж, хориглох шаардлагатай. Тухайлбал бэлгийн

дарамт гэдэг нь бэлгийн харилцаанд орох болзолтой мөнгө олгох, бэлгийн таашаал үзүүлэхийг шаардах, бэлгийн сэдэлтэй дарамтыг үг болон хөдөлгөөнөөр илэрхийлэх, хувь хүний хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн хэвшмэл хандлагаар таагүй байдалд хүргэн доромжлох гэх мэт тохиолдол юм. Гэрээлэгч нь МСК, Монголын МСС-гийн шаадлагад нийцсэн аюулгүй, хүндэтгэлтэй ажлын орчныг дэмжин хүндэтгэж аливаа зөрчлийг тодруулж, мэдүүлэх төлөвлөгөөг өгөх шаардлагатай. Гэрээлэгч нь аюулгүй, дарамтгүй, хүндэтгэлтэй ажлын орчинтой байх тухай тус заалтыг бүх зөвлөх, туслан гүйцэтгэгчийн ажилтнууд ойлгож, ажилладаг байлгах үүрэгтэй. МСС нь (өөрсдөө эсвэл гуравдагч талаар) бэлгийн дарамт болох нь тогтоогдсон аливаа хэргийг мөрдөн шалгана. Энэ заалтыг зөрчсөн тохиолдолд Зөвлөх нь МСС-тай хэргийг мөрдөн шалгахад бүрэн дүүрэн хамтран ажиллана. Зөвлөх нь мөрдөн шалгасан аливаа хэргийг МСК, Монголын МСС-гаар бүрэн дүүрэн шийдүүлж байна.

2. АЖИЛТНУУДАД МЭДЭГЛЭЛ ӨГӨХ

Ажилтныг ажлын талбарт гарахаас өмнө Гэрээлэгч нь байгууллагынхаа бэлгийн дарамтаас хориглож аюулгүй, дарамтгүй, хүндэтгэлтэй ажлын орчинтой байх тухай бодлого, хэрэг зөрчлийг мэдүүлэх, шалгах тухай төлөвлөгөөг танилцуулсан мэдэгдлийг бичгээр өгөх шаардлагатай. Үүнийг ажилтанд эх хэлээр нь хүргэнэ. Тус мэдэгдэлд дараах агуулгыг багтаасан байх шаардлагатай. Үүнд:

1. МСК-аас МСС-гуудад зориулсан бэлгийн дарамтын талаар удирдамжид тусгасан бэлгийн дарамтын талаарх тодорхойлолт;
2. Бэлгийн дарамтын талаар хэрхэн мэдүүлэх;
3. Хэрэгт холбогдсон этгээдэд хүлээлгэх хариуцлага.

Ажилтан нь тус мэдэгдлийг хүлээн авсан болохоо гэрчилж гарын үсэг зурж, нотолгоо гаргаж, Гэрээлэгч нь тус гэрчилгээг бүртгэн хадгална.

3. ТАНИЛЦУУЛГА СУРГАЛТ

Гэрээлэгч байгууллагын бэлгийн дарамтын эсрэг сургалтын хөтөлбөр нь наанадаж дараах агуулгыг багтаасан байх шаардлагатай. Үүнд:

1. Гэрээлэгч байгууллагын бэлгийн хүчирхийллийг хориглох тухай бодлогын танилцуулга. Үүнд МСК-аас МСС-гуудад зориулсан бэлгийн дарамтын талаар удирдамжид тусгасан бэлгийн дарамтын талаарх тодорхойлолт, бэлгийн дарамтын хэргийг хэрхэн мэдүүлэх, дарамт үзүүлсэн хэрэгт холбогдсон этгээдэд хүлээлгэх хариуцлагын тухай тусгасан байх шаардлагатай;
2. Ажлын талбартай холбоотой ямар төрлийн бэлгийн дарамт гарч болох жишээ, бэлгийн дарамт гэж ойлгогдож болох хандлага гаргахаас хэрхэн хамгаалах;
3. Гэрээлэгч байгууллагын хэрэг мэдүүлэх, шалгах ажлын төлөвлөгөө, хэрэг тохиолдлыг хэрхэн баримтжуулах тухай танилцуулга;
4. Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлаар холбоо барих Гэрээлэгч байгууллагын наанадаж нэг хүнийг танилцуулах;
5. Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлаар холбоо барих Зөвлөх инженерийн байгууллагын наанадаж нэг хүнийг танилцуулах;
6. Гомдол гаргасан, гэрчилсэн мэдээллийг бусад ажилтанд дэлгэхгүй байж ажилтны хувийн нууцыг хэрхэн чандлан хадгалах, батламжилахыг танилцуулах;
7. Ажилтнуудын асуултад хариулах цагийг хангалттай байлгах.

Гэрээлэгч нь ажилтнуудыг бэлгийн дарамтаас ангид байх тухай дээрх сургалтад ажлын талбарт ажиллаж эхэлснээс хойш нэг сарын дотор хамруулсан байх шаардлагатай.

Гэрээлэгчид 1) ажилтнаа бэлгийн дарамтын асуудлаар ажилладаг үндэсний болон орон нутгийн багйууллага, төрийн байгууллагуудын мэдээллээр хангаж 2) холбогдох сургалтын хөтөлбөрийг боловсруулах, сургалтыг зохион байгуулах мэргэшсэн байгууллагатай гэрээлэн ажиллах юмуу хамтран ажиллахыг төлөвлүүштэй.

4. БЭЛГИЙН ДАРАМТЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

Гэрээлэгч нь ажилтан бүрт дараах мэдээллийг агуулсан хяналт (бүртгэл)-ыг хийж байх шаардлагатай. Үүнд:

1. Ажилд орсон болон ажлын талбарт ажиллаж эхэлсэн огноо;
2. Гэрээлэгч байгууллагын бэлгийн дарамтыг хориглох тухай төлөвлөгөөний товч танилцуулгыг ажилтан ойлгох хэлээр (Монгол, Казак гэх мэт) нь бичгээр хүлээлгэн өгсөн огноо;
3. Ажилтан бэлгийн дарамтыг хориглох тухай танилцуулах сургалтад хамрагдсан огноо;
4. Ажилтан бэлгийн дарамтыг хориглохтой холбоотой аливаа хурал, уулзалтад хамрагдсан огноо.

Бэлгийн дарамтыг хориглох тухай танилцуулга сургалтын хяналтын бүртгэлийг Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх шаардлагын хэрэгжилтийн хяналт, бүх шаардлагатай мэдээллийг агуулсан бусад хяналтийн бүртгэл, тайлантай хамтатган хийж болно.

ХАВСРАЛТ II. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БОЛОН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАДАГ БАЙГУУЛЛАГУУД

БОННУ-гээр хүн худалдаалах, бэлгийн дарамт, хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийлэл, жендэрийн эрх тэгш байдал зэрэг асуудлаар ажилтны ёс зүй, ажлын нөхцөлийн талаар сургалтын загварыг боловсруулах чадамж, туршлагатай ТББ-уудтай хамтран ажиллахыг зөвлөсөн байдаг.

Мөн БОННУ-нд хохирогч болж болзошгүй хүмүүсийг хэрэгтэй мэдээллээр хангах хэрэгтэй гэж тусгасан. Хорооны нийгмийн ажилтан, хэвлэл мэдээлэл, холбогдох дүүргийн иргэдтэй харилцах ажилтнаас холбогдох мэдээллийг өгдөг байх шаардлагатай.

Тухайлбал, гүйцэтгэгч байгууллага, ажилтнууд, төсөл хэрэгжих газрын олон нийтэд холбогдох мэдээлэл хүргэхэд дараах байгууллагууд байж болно.

Монголын ажил олгогч эздийн холбоо

Цахим хуудас: <http://www.monef.mn>

Хаяг: Монгол Улс: Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай, Таван богд плаза

Утас: +976 11 325 635

Цахим шуудан: monef@magicnet.mn

Монголын ажил олгогч эздийн холбоо нь 1990 онд 35 гишүүнтэй байгуулагдаж байсан бол одоо 21 аймагт 7800 гаруй үйлдвэрлэл, барилга, тээвэр, банк, даатгал, үйлчилгээний салбарын гишүүнтэй болж өргөжсөн юм. Ажил олгогч эздийн эрх ашиг, хувийн салбарын хөгжлийн төлөө үйл ажиллагаа явуулдаг.

Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд

Цахим хуудас: <https://w4cblog.wordpress.com/>

Цахим шуудан: youngwomenforchange@gmail.com

Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд нь Улаанбаатарт байдаг гишүүнчлэлтэй ТББ юм. Монголын эмэгтэйчүүд, залуу эмэгтэйчүүдийг дэмжих, хүчирхэгжүүлэх, тэдний төлөө нөлөөллийн үйл ажиллагаа явуулах зорилготой. Жендэрийн ялгаварлан гадуурхалтын талаар ойлголтыг нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийг мэдлэгтэй, өөртөө итгэлтэй, өөрийгөө дайчилдаг болсноор нийгэмд өөрчлөлтийг авчирах үзэл баримтлалтай юм.

МОНФЕМНЕТ

Цахим хуудас: www.monfemnet.org

Хаяг: Монгол Улс: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, Нэгдэлчин зочид буудал, 96-р орон сууцны 202 тоот

Утас: [+976 7011 0355](tel:+97670110355)

Цахим шуудан: info@monfemnet.org

Тус сүлжээ нь 2000 онд Монголын эмэгтэйчүүдийн 5 дугаар чуулганаар Монголын эмэгтэйчүүдийн ТББ-уудын үндэсний сүлжээ үүсгэх санаачлагаар байгуулагдаж 2007 онд албан ёсоор байгууллага болсон. Эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг эхлүүлэх,

байгууллагуудыг чадавхжуулах, бодлого хэрэгжилтэд хяналт хийх, олон улсын SASA! арга зүйг ашиглан хүйсийн эрх тэгш соёлыг бий болгоход төвлөрөн ажиллаж байна

Монголын хүйсийн тэгш эрхийн төв

Цахим хуудас: <https://www.endslaverynow.org/mongolian-gender-equality-center>

Утас: (+976) 11311 512

Цахим шуудан: gendereqcen@magicnet.mn

ХТЭТ нь 2002 онд хүн худалдаалах гэмт хэрэг нэмэгдэж байгаагийн эсрэг ажиллахаар байгуулагдсан. Хүний наймааны хохирогчдод эрх зүйн зөвлөгөө өгч хамгаалах байраар хангадаг. Монголд хүн худалдаалах гэмт хэрэг нь хүйсээр ялгаварласан гэмт хэргийн тод жишээ юм. Залуу охид, эмэгтэйчүүдийг хууль бусаар биеийг үнэлүүлэхээр наймаалж, бэлгийн мөлжлөгт оруулдаг байна. Тус төв улс улсаас хүний наймааны хохирогч болсон олон зуун хохирогчдод туслалцаа үзүүлээд байна. ХТЭТ нь тус гэмт хэргийн эсрэг эрх зүйн орчныг сайжруулах, урьдчилан сэргийлэх, олон нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэх нөлөөллийн үйл ажиллагаа явуулж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, хамгаалах байраар хангах, мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

Хүний эрх хөгжил төв

Цахим хуудас: <https://chrdmongolia.wordpress.com/>

Утас: +976 11 32 5721

Цахим шуудан: chrd@mongolnet.mn

Азийн сангийн дэмжлэгтэйгээр хүн худалдаалах гэмт хэргийн талаар шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, өмгөөлөгч нарт сургалт зохион байгуулдаг байсан.

Гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв

Цахим хуудас: www.fcy.gov.mn

Утас: +976 62 262109

Цахим шуудан: info@fcy.gov.mn

Монгол Улс дахь тус Нэг цэгийн үйлчилгээний төв нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, тэдний гэр бүлд хамгаалах байр, эмнэлгийн тусламж, сэтгэл зүйн зөвлөгөө, хамгааллын үйлчилгээ, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг нэг дор үзүүлдэг юм. Монгол Улсын Засгийн газраас Хууль зүй, дотоод хэргийн яам, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас НҮБ-ын хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлагийн туслалцаатай байгуулагдсан. Ковид-19 цар тахлын улмаас гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдсэнээс үүдэн дахин 2 төвийг Улаанбаатарт нээн ажиллуулж байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв

Цахим хуудас: www.safefuture.mn

Хаяг: Монгол Улс: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу, 6-р хороо, Байр-40#03, 06,

Утас/Факс: +976-70119949

Тусламжийн утас: +976-96490505

Цахим шуудан: mongolcav@mongol.net

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ) нь 1995 онд Монгол Улсад эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн эсрэг тэмцэх зорилгоор байгуулагдсан ашгийн бус, нам бус, төрийн бус байгууллага юм. Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүмүүст хамгаалах байр, зөвлөгөөгөөр үйлчилдэг.

Монголын ЛГБТ Төв

Цахим хуудас: <http://lgbtcentre.mn/en/home/>

Хаяг: Монгол Улс: Улаанбаатар хот- 14200, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-49/1-201 тоот

Утас: + 976 7011 0323

24 цагийн тусламжийн утас: + 976 9515 9270

Цахим шуудан: info@lgbtcentre.mn

- ЛГБТИ хувь хүн, тэдний гэр бүл ялгаварлан гадуурхалт, үзэн ядалтын гэмт хэрэгт өртсөн тохиолдолд эрх зүйн зөвлөгөө, тусламжийг хүргэх;
- ЛГБТИ хүмүүсийг бүхий л төвшинд үр дүнтэй, хүртээмжтэй эрх тэгш хамгаалдаг байлгахын тулд Үндсэн хуулийн ялгаварлан гадуурхалтыг хориглосон 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх үүднээс бэлгийн чиг баримжаа, хүйсийн ялгаатай байдлаас үл хамааран хамгаалагдсан байх эрх зүйн орчин бүрдүүлэхээр өргөн хүрээнд нотолгоонд суурилсан нөлөөллийн ажлыг зохион байгуулах;
- Төрийн алба хаагч, үүнээс хууль сахиулах ажилтнуудыг ЛГБТИ хүмүүсийн онцлогийг мэдэрч үйлчилдэг байх чадавхыг бэхжүүлэх.
- Хууль хууль сахиулах чиглэлээр боловсрол олгодог сургууль (тухайлбал Хууль сахиулах дээд сургууль, их дээд сургуулийн хуулийн сургууль)-ийн сургалтын хөтөлбөрт ЛГБТИ хүний эрхийн тухай тусгах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Гэр бүл, хүүхэд, залуусын хөгжлийн газар (ГБХЗХГ)

Хүүхдийн төлөө Засгийн газрын бодлого, хууль тогтоомж, төслийг хэрэгжүүлэх, хүүхдийн хөгжил, нийгмийн оролцоог дэмжих, хүүхдийг аливаа хүчирхийллийн хохирогч болохоос сэргийлэх, нийгмийн үйлчилгээг үзүүлдэг. Төвийн болон орон нутгийн хэлтсүүдэд хүртээмж бүхий үндэсний төвшний эмзэг бүлгийн хүүхдүүдийн бүртгэлийн мэдээллийн сантай. Хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн эрхийн зөрчлийн талаар 24 цагийн турш дуудлага хүлээн авах Хүүхдийн тусламжийн утас 108-ыг 22 ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллуулж байна. Түр хамгаалах байрыг (24 - 168 цаг хүртэл хугацаанд) ажиллуулж, тохиолдлын нөхцөл байдлаас хамаарч дээд тал 6 хүртэл сараар хамгаалах үйлчилгээг үзүүлж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд харьяалагддаг.

ТӨГСӨВ.